



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ*

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**НЭГДСЭН ХУРАЛДААН**



## ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр, Баасан гараг**

|                                          |               |
|------------------------------------------|---------------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>   | <i>1</i>      |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>        | <i>2-56</i>   |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | <i>57-138</i> |

|                                                                                                                                                                                                                                                                                                        |               |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|
| <b>1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/</b>                                                                                                        | <b>56-64</b>  |
| <b>2. Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025.10.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, үргэлжилнэ/</b>                                                                                                                | <b>64-76</b>  |
| <b>3. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/</b> | <b>76-138</b> |

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы  
11 дүгээр сарын 07-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 67 гишүүн хүрэлцэн ирж, 53.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 33 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Бямбасүрэн, С.Ганбаатар, Ц.Мөнхбат, Б.Түвшин, А.Ундраа, Ч.Ундрэм, О.Цогтгэрэл, Д.Энхтуяа;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Х.Булгантуяа, Н.Номтойбаяр, М.Нарантуяа-Нара, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Батсүмбэрэл, Л.Гантөмөр, Б.Жаргалан, Б.Заяабал, С.Лүндэг, Л.Мөнхбаатар, Г.Очирбат, Б.Тулга, Ж.Чинбүрэн;

Тасалсан: Х.Баттулга, С.Замира;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-11 минут, О.Амгаланбаатар-38 минут, М.Бадамсүрэн-04 минут, Б.Батбаатар-08 минут, Б.Батцэцэг-18 минут, Э.Болормаа-05 минут, Ж.Галбадрах-28 минут, А.Ганбаатар-55 минут, Г.Ганбаатар-31 минут, Д.Ганбат-19 минут, Ц.Даваасүрэн-40 минут, Т.Доржханд-2 цаг 48 минут, Б.Дэлгэрсайхан-5 цаг 06 минут, Д.Жаргалсайхан-06 минут, Ч.Лодойсамбуу-05 минут, Л.Мөнхбаясгалан-3 цаг 41 минут, П.Мөнхтулга-3 цаг 48 минут, Б.Найдалаа-1 цаг 16 минут, О.Номинчимэг-1 цаг 45 минут, Э.Одбаяр-36 минут, Л.Оюун-Эрдэнэ-18 минут, Б.Пунсалмаа-04 минут, Р.Сэддорж-55 минут, Ц.Туваан-35 минут, Н.Учрал-04 минут, Б.Уянга-3 цаг 44 минут, Д.Цогтбаатар-1 цаг 10 минут, Л.Энх-Амгалан-30 минут, Б.Энхбаяр-17 минут, Ж.Энхбаяр-45 минут.

**Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт  
өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний  
өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсжаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Нийслэлийн өмчит “Улаанбаатар түншлэл төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал З.Батырбек нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

*Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг санал хураалтаар үргэлжлүүлэн явуулав.*

**Нэг.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал**

**Б.Пүрэвдорж:** 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, М.Бадамсүрэн, Ц.Баатархүү, Ж.Баясгалан, Б.Бейсен, Г.Лувсанжамц, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Д.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төсөлд доор дурдсан 1 дүгээр зүйл нэмэх:

**“1 дүгээр зүйл.**Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай 17<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

**17<sup>1</sup> дүгээр зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт**

17<sup>1</sup>.1.Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1.а дэд заалтыг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дагаж мөрдөнө.

17<sup>1</sup>.2.Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1.б дэд заалтыг 2027 оны төсвийн жилээс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 36 |
| Татгалзсан: | 37 |
| Бүгд:       | 73 |

49.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 48 |
| Татгалзсан: | 26 |
| Бүгд:       | 74 |

64.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 46 |
|-------------|----|

Татгалзсан: 28  
Бүгд: 74  
62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15.2.1.а дэд заалтын “2026 оны татварын жилээс эхлэн” гэснийг “албан татвар төлөгчийн албан татвар суутган төлөгчтэй хийсэн” гэж, “1 дүгээр зүйл” гэснийг “2 дугаар зүйл” гэж, “2 дугаар зүйл” гэснийг “3 дугаар зүйл” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51  
Татгалзсан: 24  
Бүгд: 75  
68.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “01 дүгээр” гэснийг “10 дугаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53  
Татгалзсан: 22  
Бүгд: 75  
70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Саналын томьёоллын 1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54  
Татгалзсан: 21  
Бүгд: 75  
72.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хоёр.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

### **Найруулгын санал**

**Б.Пүрэвдорж:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “8.1.3 дахь заалтын “төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрлийг авах” гэснийг “төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийг авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлэх” гэж, мөн зүйлийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52  
Татгалзсан: 23  
Бүгд: 75  
69.3 хувийн саналаар дэмжигдлээ.

**Гурав.“Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

**Б.Пүрэвдорж:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “Монгол Улсын Үндэсний 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах” гэснийг “Монгол Улсын Үндсэн хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдох зарчмын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45  
Татгалзсан: 30  
Бүгд: 75  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52  
Татгалзсан: 24  
Бүгд: 76  
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3/Энэ тогтоолын 1 дэх дэд заалтыг хэрэгжүүлэхдээ хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, бүтээгдэхүүн арилжаалах зэрэг бүхий л үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод нээлттэй, үр ашигтай зохион байгуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52  
Татгалзсан: 24  
Бүгд: 76  
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал**

**Нэг.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Б.Пүрэвдорж:** 1.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 18.4 дэх хэсгийн “хийж болно” гэснийг “хийнэ.” гэж өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 41  
Татгалзсан: 35  
Бүгд: 76  
53.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51  
Татгалзсан: 25  
Бүгд: 76  
67.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтыг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлж, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 34  
Татгалзсан: 45  
Бүгд: 79  
43.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43  
Татгалзсан: 37  
Бүгд: 80  
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 42  
Татгалзсан: 38  
Бүгд: 80  
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалтын 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.1.7 дахь заалт нэмэх:

“25.1.7.нийгмийн нөлөөллийн шинжилгээний санал, дүгнэлт;” гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43  
Татгалзсан: 37

Бүгд: 80  
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “заалт, 17 дугаар зүйлийн 17.1.2.б дэх дэд заалт, 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4.2 дахь” гэснийг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48  
Татгалзсан: 33  
Бүгд: 81  
59.3 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хоёр.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

**Б.Пүрэвдорж:** 1.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3-т” гэснийг “12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, 12.1.5-д” гэж, “мөн зүйлийн 12.1.4-т” гэснийг “мөн зүйлийн 12.1.4, 12.1.5-д” гэж тус тус өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 41  
Татгалзсан: 40  
Бүгд: 81  
50.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**Гурав.“Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад дор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх:

“5/Тавантолгойн бүлэг ордтой холбоотойгоор байгуулсан, хэрэгжүүлсэн төрийн нууцад авсан гэрээ, хэлцэл, тэдгээрийг байгуулахыг зөвшөөрсөн, дэмжсэн төрийн нууцад авсан холбогдох бүх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу төрийн нууцаас гаргах арга хэмжээг 2026 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор авч хэрэгжүүлж, Монгол Улсын Их Хуралд тайлагнах.” гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.  
Зөвшөөрсөн: 20  
Татгалзсан: 62  
Бүгд: 82  
24.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025.10.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, үргэлжилнэ/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

*“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг асуулт, хариултаар үргэлжлүүлэн хэлэлцэв.*

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Ч.Лодойсамбуу, Д.Ганбат, Ж.Баярмаа нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, О.Алтангэрэл нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Х.Тэмүүжин нар үг хэлэв.

**Б.Пүрэвдорж:** Байнгын хорооны саналаар “Хянан шалгах түр хороо байгуулах” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 46 |
| Татгалзсан: | 46 |
| Бүгд:       | 92 |

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Ж.Батжаргал нар үг хэлж, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа хариулав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:04/

**Гурав.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, А.Энхбат, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэнджав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Энхболд, мөн газрын Санхүүгийн аудитын газрын захирал Ц.Наранчимэг, Нийцлийн аудитын газрын захирал Б.Баттуяа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү,

төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Урьболд, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Э.Гэрэлбат, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсжаргал, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Гаалийн ерөнхий газрын Татвар орлогын газрын дарга С.Баярмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Р.Тэгшжаргал нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Х.Ганхуяг нар үг хэлэв.

*Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 47 минут үргэлжилж, 12 цаг 20 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 25 минутад эхлэв.*

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг танилцуулав.

Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг дараах 6 асуудлаар чиглэл авч, төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлэгт буцааж, дахин хэлэлцүүлэх горимын санал гаргав. Үүнд:

1.Ажлын хэсгийн саналын хавсралтын 2-т тусгагдсан бүсчилсэн хөгжилтэй холбоотой сэдэв;

2.Төсвийн байнгын хорооны нэр бүхий гишүүнээс гаргасан Засгийн газрын нөөц сангаас тодорхой дүнгээр бууруулж, зохицуулалт хийх санал;

3.Ажлын хэсгийн төсвийн тэнцэлд нөлөөлөхгүй зохицуулалтын 16 дугаар саналын Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдийн лабораторийн багаж, тоног төхөөрөмж гэсэн төсөл арга хэмжээ;

4.Байнгын хорооны саналыг санал хураалт явуулах үед Өргөдлийн байнгын хорооны саналын Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2026 оны хэрэгжүүлэх хөтөлбөрийн саналаас эхлэн бусад Байнгын хорооны болон Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал;

5.Ажлын хэсгийн саналын томъёоллын хавсралт 2 буюу Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт нэмэгдүүлэх саналууд;

6.Шинжлэх ухаан, технологийн сангийн зардал нийт хувьчилж бууруулах зардал.

**Б.Пүрэвдорж:** Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуягийн саналаар, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14-т “нэгдсэн хуралдаанаас төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзвэл Төсвийн байнгын хороонд чиглэл өгч буцааж болно. Чиглэл өгсөн тодорхой асуудлаас бусад асуудлыг хөндөхийг хориглоно.” гэж заасны дагуу төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг тодорхой 6 асуудлын хүрээнд дахин явуулах чиглэл өгч, буцаахыг дэмжье гэсэн хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 59  
Татгалзсан: 40  
Бүгд: 99  
59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

*Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

### **Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал**

**Б.Пүрэвдорж:** 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Д.Батбаяр, Ж.Алдаржавхлан, Р.Батболд, Б.Заяабал, Д.Жаргалсайхан, Х.Жангабыл, П.Мөнхтулга, Г.Тэмүүлэн /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан,

**Нэг.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад тусгагдсан урсгал болон хөрөнгө оруулалтын зардалд зохицуулалт хийх санал**

#### **1.1.Зардал бууруулах санал:**

##### ***Урсгал зардал бууруулах:***

- Төрийн албан хаагчдын цалин хөлс, Хүүхдийн мөнгөн тэтгэмж, Нийгмийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Боловсролын салбарын гүйцэтгэлийн санхүүжилт, улсын төсвөөс санхүүжих эрүүл мэнд, боловсролын байгууллагууд, гамшиг, ослоос хамгаалах, эрэн хайх, аврах ажиллагааны зардал, Засгийн газрын зээлийн үйлчилгээний хүүгийн зардал, гадаад зээл, тусламжаас санхүүжих урсгал зардал, 100 хувь өөрийн орлогоос санхүүжих зардлыг хөндөхгүйгээр аймгуудын урсгал зардлыг 6.0 хувиар, бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлыг 12.8 хувиар бууруулж, нийт 411,447.6 сая төгрөгөөр;

- Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “1,542,428.4” гэснийг “1,235,328.4” гэж холбогдох шийдвэрийн хамт өөрчлөн, гадаад зээллэгийн ашиглалтыг 307,100.0 сая төгрөгөөр;

- Улсын Их Хурлын гишүүдийн зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 88.9 сая төгрөгөөр;

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын “Эрчим хүчний экспортыг дэмжих нэгж”-ийн урсгал зардлыг 2,588.6 сая төгрөгөөр;

- Ойн газрын урсгал зардалд ойжуулалтын зардалд зориулж 44,161.7 сая төгрөг тусгагдсан тул Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны урсгал зардалд давхар тусгагдсан ойжуулалтын хөтөлбөрийн зардлыг 5,023.5 сая төгрөгөөр;

- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцын аялал жуулчлалын чиглэлийн хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасыг 8,000.0 сая төгрөгөөр;

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын “Шинэ хоршоо хөтөлбөр”-ийн 2026 оноос шинээр олгохоор тооцсон зээлийн хүүгийн татаасыг 22,000.0 сая төгрөгөөр;

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын Зээлийн батлан даалтын сангийн дүрмийн санг нэмэгдүүлэхэд тусгагдсан санхүүжилтийг 25,000.0 сая төгрөгөөр;

- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн санхүүжилтийг 10,000.0 сая төгрөгөөр;

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын төрийн албан хаагчийг мэргэшүүлэх зардалд зориулж Удирдлагын академид олгодог санхүүжилтийг 4,636.6 сая төгрөгөөр;

- 2026 оны төсвийн жилд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шадар сайд нарын ажлын алба болон бүх яамдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардал шинээр тусгагдсаныг хасаж, нийт 10,000.0 сая төгрөгөөр;

- Хархорум хотын Захирагчийн ажлын албаны урсгал зардлыг 2025 оны түвшинд тооцож 2,840.0 сая төгрөгөөр;

- Орон нутгаас бусад бүх төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал засварын зардлыг 40,000.0 сая төгрөгөөр;

- Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын их засварын зардлыг Төсвийн шатлал хоорондын тооцооллыг оруулснаар тооцож 40,000.0 сая төгрөгөөр;

- Үндэсний аудитын газрын урсгал зардлыг 2025 оны түвшинд тооцож 4,916.8 сая төгрөгөөр;

- Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын эрдэм, шинжилгээ судалгааны ажлын зардлыг 916.8 сая төгрөгөөр;

- Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцын судалгаа шинжилгээний зардлыг 1,510.2 сая төгрөгөөр;

- Шадар сайдын төсвийн багцын эрдэм шинжилгээ, судалгааны зардлыг 9,000.0 сая төгрөгөөр;

- Орон нутгийн авто замын сангийн санхүүжилтийг төсвийн шатлал хоорондын харилцаагаар тооцсон дүнгээр буюу 60,000.0 сая төгрөгөөр;

- Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Улсын ерөнхий прокурор болон Шадар сайдаас бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлыг 2025 оны түвшинд тооцож нийт 6,816.7 сая төгрөгөөр буюу нийт 971,885.7 сая төгрөгөөр бууруулах.

### ***Хөрөнгийн зардал бууруулах:***

- Төслийн 2 дугаар хавсралтын Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой болон боловсрол, эрүүл мэнд, онцгой байдал, батлан хамгаалах, соёл, улсын бүртгэл, шүүх шинжилгээ, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага, сонгуулийн тоног төхөөрөмжөөс бусад шинээр хэрэгжүүлэх тоног төхөөрөмжийн санхүүжилтийг 50 хувиар буюу 62,930.4 сая төгрөгөөр, 2026 онд дуусах хөрөнгө оруулалтын төслүүдийг хөндөхгүйгээр, 2027 он болон түүнээс цааших онуудад шилжих хөрөнгө оруулалтын төслүүдийн 2026 онд санхүүжих дүнг зам, тээврийн салбарынхыг 17.2 хувиар буюу 77,367.8 сая төгрөгөөр, бусад салбарынхыг 15 хувиар буюу 127,010.7 сая төгрөгөөр, УТ2601300905 төслийн кодтой “Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой барилга байгууламж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 150,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацааг 2026-2027 он гэж өөрчлөн, 2026 онд санхүүжих дүнг 50,000.0 сая төгрөгөөр, уг саналуудад давхардаагүй Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлж, нийт 14,529.3 сая төгрөгөөр Хавсралт 1-д тусгагдсаны дагуу нийт 331,838.2 сая төгрөгөөр бууруулах.

### **1.2.Зардал нэмэгдүүлэх санал:**

#### ***Урсгал зардал нэмэгдүүлэх санал:***

- Боловсролын салбарын гүйцэтгэлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх хүрээнд багш нарын үндсэн цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-ээс 742.0 мянган төгрөгөөр, 11 дүгээр сарын 01-ээс 2,800.0 мянган төгрөгт хүргэхээр тооцож Боловсролын сайдын урсгал зардлыг 518,620.2 сая төгрөгөөр;

- Эмч, эмнэлгийн байгууллагын ажиллагсдын цалинг 15 хувиар нэмэгдүүлэхэд зориулж Эрүүл мэндийн сайдын урсгал зардлыг 190,300.0 сая төгрөгөөр;

- Төрийн өмчийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ажилчдын цалинг 15 хувиар нэмэгдүүлэхэд зориулж Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн

сайдын урсгал зардлыг 9,794.9 сая төгрөгөөр, Боловсролын сайдын урсгал зардлыг 925.7 сая төгрөгөөр, нийт 10,720.6 сая төгрөгөөр;

- Ахмад настны тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлэхээр төсөлд тусгагдсаныг инфляцын түвшинтэй уялдуулан тооцож 8.6 хувь болгон нэмэгдүүлэхэд зориулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын урсгал зардлыг 145,000.0 сая төгрөгөөр;

- Халамжийн тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлэхээр төсөлд тусгагдсаныг инфляцын түвшинтэй уялдуулан тооцож 8.6 хувь хувь болгон нэмэгдүүлэхэд зориулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын урсгал зардлыг 19,500.0 сая төгрөгөөр;

- Монгол Улсын иргэний дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүүхэд залуучуудын суралцах тэгш боломжийг хангах, дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгодог “Илгээлт-2100” хөтөлбөрийн санхүүжилтийг 33,000.0 сая төгрөгөөр;

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын урсгал зардлыг 2,446.8 сая төгрөгөөр;

- Хүний эрхийн сурах бичигт зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 231.9 сая төгрөгөөр;

- Шатахууны нөөцийн агуулах, дэд бүтэц бүрдүүлэх хүүгийн татаас, хяналтын системийг бүрдүүлэх зардалд 20,000.0 сая төгрөгөөр буюу нийт 939,819.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

### ***Хөрөнгийн зардал нэмэгдүүлэх санал:***

- Магадлалын ерөнхий дүгнэлтэд хийсэн аудитын дүгнэлтийг үндэслэж хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэхтэй холбогдуулан эрүүл мэнд, боловсролын салбарын зарим төсөл, арга хэмжээг төсөлд шинээр тусгах, санхүүжих дүнг нэмэгдүүлэх, мөн Хөгжлийн бодлогын зарим баримт бичгүүд, бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгагдсан авто зам, гүүр, эрчим хүч, иргэдийн орон нутагтаа ажиллаж, амьдрах, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн өрсөлдөх чадвартай бүсүүдийг бий болгох зорилт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор хөрөнгийн зардлыг 363,904.4 сая төгрөгөөр буюу Хавсралт 2-т тусгагдсаны дагуу нэмэх.

### **1.3. Орлого нэмэгдүүлэх санал:**

Татварын зарлагыг бууруулах буюу нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжих хугацааг хойшлуулж, үүнтэй уялдуулан татварын орлогыг 375,000.0 сая төгрөгөөр, мөн төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 2025 оны төсөвлөсөн дүнд хүргэж 5,000.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх.

### **1.4. Орлого бууруулах санал:**

Агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлогоос төсөвт төвлөрүүлэхээр тооцсон дүнг 40,000.0 сая төгрөгөөр, мөн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг 10,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулах гэсэн саналыг хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

## **2.Төсвийн тэнцэлд нөлөөлөхгүй зохицуулалтын санал**

**Б.Пүрэвдорж:** 2.1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601100108 төслийн кодтой “Татварын мэдээллийн системийн дэд бүтэц, серверийн болон татварын албадын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 23,026.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 19,706.6 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр төслийн 2 дугаар хавсралтад “Чойбалсан нисэх буудал /Аэродром/-ын хөөрч, буух зурвас, шинэчлэх /Дорнод, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг 59,120.0 сая төгрөг, санхүүжих дүн 19,706.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57  
Татгалзсан: 40  
Бүгд: 97  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 3,068.7 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Цэцэрлэгийн барилга 150 ор /Дорнод, Дашбалбар сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 6,137.4 сая төгрөг, санхүүжих дүн 3,068.7 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57  
Татгалзсан: 40  
Бүгд: 97  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 2,231.9 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Цэцэрлэгийн барилга 150 ор /Дорнод, Матад сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 4,463.6 сая төгрөг, санхүүжих дүн 2,231.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56  
Татгалзсан: 41

Бүгд: 97  
57.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102900758 төслийн кодтой “Гандангийн дэнж” шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв, барилгын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг 23,484.9 сая төгрөг, санхүүжих дүн 6,130.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,090.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Хүүхэд залуучуудын “Зүүн наран” хүрээлэн /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 9,271.9 сая төгрөг, санхүүжих дүн 3,090.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58  
Татгалзсан: 39  
Бүгд: 97  
59.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой “Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 186,000.6 сая төгрөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,719.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Монголын нууц товчоо цогцолборын барилгын гадна тохижилтын ажлын нэмэлт ажил /Хэнтий, Дэлгэрхаан сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 685.0 сая төгрөг”, “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Баян-Овоо сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн 434.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг, “Уурын зуухны барилгын шугам сүлжээний засвар /Хэнтий, Мөрөн сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 600.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58  
Татгалзсан: 40  
Бүгд: 98  
59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,080.2 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Баян-Адарга сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн 404.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Бэрх тосгон/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн 651.8 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Шихихутаг, нууц товчоо түүхэн аялал жуулчлалын барилгын нэмэлт санхүүжилт” /Хэнтий, Норовлин сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 641.6 сая төгрөг”

гэсэн төсөл, арга хэмжээг, “Их хуралдай цогцолборын барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Биндэр сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 238.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Соёлын төвийн барилга, /Хэнтий, Батширээт сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 436.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг, “Соёлын төвийн барилга, /Хэнтий Цэнхэрмандал сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,707.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 41

Бүгд: 98

58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800893 төслийн кодтой “Замын-Үүд талаас Сайншанд чиглэлийн 16 км хатуу хучилттай замын хэсэгчилсэн их засвар /Дорноговь/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 22,268.3 сая төгрөг, санхүүжих дүн 10,020.8 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасаж, энэ эх үүсвэрээр “Саран хөхөө дуулалт театр, төсөвт өртөг 15,800.0 сая төгрөг, санхүүжих дүн 8,300.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 46

Бүгд: 98

53.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2003400774 төслийн кодтой Байгалийн түүхийн музейн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2020-2026 он, төсөвт өртөг 130,618.4 сая төгрөг, санхүүжих дүн 51,982.6 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг аудитын магадлалын ерөнхий дүгнэлтийг үндэслэн 94,691.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, санхүүжих дүнг 36,000.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Байгалийн түүхийн музейн үзүүлэг дэглэлт, үзмэрийн интерьерийн зураг, цуглуулга, үзмэрийн тоноглол, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 178,368.0 сая төгрөг, санхүүжих дүн 36,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 46

Бүгд: 98

53.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.9.Ажлын хэсгийн гаргасан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад тусгагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Цөлжилттэй тэмцэх тухай" суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлын үед зохиогдох соёл, урлагийн арга хэмжээний зардлыг 4,000.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын багцын Кино урлагийг дэмжих сангийн санхүүжилтийг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 48  
Татгалзсан: 51  
Бүгд: 99  
48.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53  
Татгалзсан: 46  
Бүгд: 99  
53.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 52  
Татгалзсан: 48  
Бүгд: 100  
52.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602900572 төслийн кодтой “Үерийн хамгаалалтын далангийн 2, 3 дугаар ээлжийн байгууламж /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг нь 10,407.8 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 3,122.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, энэ эх үүсвэрээр “Шинэ суурьшлын бүсийн дэд бүтцийн ажил /Архангай Эрдэнэбулган сум/”, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 25,651.2 сая төгрөг, санхүүжих дүн 3,122.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58  
Татгалзсан: 42  
Бүгд: 100  
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 2,400.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Ахмадын сувиллын иж бүрэн засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 19-р хороо/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,300.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээ болон “Хиймэл оюун мэдээллийн технологийн “Google”-ийн хөтөлбөр хэрэгжүүлэх лаборатори сургуулийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 2

дугаар сургууль/ хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,100.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59  
Татгалзсан: 41  
Бүгд: 100  
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400293 төслийн кодтой “Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 26,586.5 сая төгрөг, санхүүжих дүн 7,976.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 600.0 сая төгрөгөөр, УТ2601400293 төслийн кодтой “Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн ажилчдын орон сууцны барилга, 50 айл /Говь-Алтай, Есөнбулаг сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 5,949.2 сая төгрөг, санхүүжих дүн 2,082.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 600.0 сая төгрөгөөр, УТ2601400232 төслийн кодтой “Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 20,132.1 сая төгрөг, санхүүжих дүн 9,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 300.0 сая төгрөгөөр буюу нийт 1,500.0 сая төгрөгөөр хөрөнгийн зардлыг бууруулж, Батлан хамгаалах яамны харьяа Үндэсний батлан хамгаалахын Их сургуулийн урсгал зардлыг 1,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54  
Татгалзсан: 46  
Бүгд: 100  
54.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402901667 төслийн кодтой “Ховд хотын ундны усны хоёр дахь эх үүсвэр /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2024-2028 он, төсөвт өртөг 38,071.2 сая төгрөг, санхүүжих дүн 5,825.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,500.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Сум, багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Увс, Завхан, Ховд, Говь-Алтай/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 4,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49  
Татгалзсан: 51  
Бүгд: 100  
49.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 46  
Бүгд: 100  
54.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 53  
Татгалзсан: 47  
Бүгд: 100  
53.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102900392 төслийн кодтой “Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /Архангай/, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг 26,964.8 сая төгрөг, санхүүжих дүн 6,118.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,608.5 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Нийтийн ариун цэврийн байгууламж бүхий барилгын гадна замын авто зогсоол /Архангай, Цэнхэр сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,608.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60  
Татгалзсан: 40  
Бүгд: 100  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдийн лабораторийн багаж, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 32,544.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 1,200.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Кембрижийн хөтөлбөр хэрэгжүүлэх лаборатори сургуулийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн” /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 166 дугаар сургууль/, хэрэгжих хугацаа 1,200.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

2.16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601100108 төслийн кодтой “Татварын мэдээллийн системийн дэд бүтэц, серверийн болон татварын албадын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 23,026.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 3,320.3 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Газрын тос боловсруулах үйлдвэрийн цахилгаан хангамжийн 110кВ-ын ЦДАШ, 110/35/10кВ-ын Ширээт дэд станц, хэрэгжих хугацаа 2026-2028 он, 16,837.9 сая төгрөг, санхүүжих дүн 3,320.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60  
Татгалзсан: 40  
Бүгд: 100

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

### **3.Төсвийн тэнцэлд нөлөөлөхгүй санал**

#### **3.1.Төсвийн захирагч хооронд шилжүүлэх:**

**Б.Пүрэвдорж:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын Сэлэнгэ аймгийн Мандал сумын хүүхдийн ордны үйл ажиллагааг орон нутаг руу шилжүүлэх замаар Сэлэнгэ аймгийн суурь зардлыг 421.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60  
Татгалзсан: 40  
Бүгд: 100  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

#### **3.2.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр өөрчлөх санал:**

**Б.Пүрэвдорж:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400557 төслийн кодтой “Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаанд нэн шаардлагатай тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний “үйл ажиллагаанд нэн шаардлагатай” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58  
Татгалзсан: 42  
Бүгд: 100  
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400570 төслийн кодтой “Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын төрийн өмчийн барилга байгууламжийн хүчитгэл, их засвар /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний “хүчитгэл,” гэснийг “сэргээн засварлах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62  
Татгалзсан: 38  
Бүгд: 100  
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602900811 “Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Архангай, Өвөрхангай/” гэсэн төсөл, арга хэмжээний “Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” гэснийг “Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67  
Татгалзсан: 33  
Бүгд: 100  
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

### **3.3.Төслийн 1 дүгээр хавсралтын талаарх санал:**

**Б.Пүрэвдорж:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “16.1.3.4 Цагаатгал, нөхөн олговортой холбоотой хууль тогтоомжийн нэгдмэл байдлыг хангах, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024 он, Суурь түвшин: 25, Зорилтот түвшин: “40” гэсэн дэд заалт, “16.1.3.5 Их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад хэлмэгдүүлэлт, түүний хор уршгийг таниулах чиглэлээр сургалтад хамрагдсан сурагчдын хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024 он, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10 %” гэсэн дэд заалт тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67  
Татгалзсан: 33  
Бүгд: 100  
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

### **3.4.Засгийн газрын 2026 оны төсвийн жилд шинээр үүсгэх өрийн хэмжээнд өөрчлөлт оруулах санал:**

**Б.Пүрэвдорж:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг буюу “Өрийн удирдлагын тухай хуулийн 28<sup>1.1</sup>-д заасан зориулалтаар гаргах аймгийн үнэт цаасны дээд хэмжээг 150,000.0 сая төгрөг хүртэл” гэсний “аймгийн” гэснийг “аймаг, нийслэлийн” гэж, “150,000.0 сая төгрөг” гэснийг “425,000.0 сая төгрөг” гэж, холбогдох шийдвэрийн төслийн хамт өөрчлөх гүйцээн боловсруулах чиглэл өгч, буцаахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64  
Татгалзсан: 36  
Бүгд: 100  
64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

### **4.Зарчмын зөрүүтэй саналын томьёололд нийцүүлэн хуулийн төсөлд өөрчлөлт оруулах санал:**

**Б.Пүрэвдорж:** 4.1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан дэмжигдсэн саналуудыг төсвийн тооцоололд бүрэн тусгаж, зарчмын зөрүүтэй дэмжигдсэн саналуудыг нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг тусгах, үүнтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын зарцуулах урсгал болон хөрөнгийн зардал, төвлөрүүлэх орлогын хэмжээ, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн болон Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагад нөлөөлөх өөрчлөлт, мөн төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томьёог жигдлэх засварыг хийх, мөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, эдийн засгийн ангилал, хэрэгжих хугацааг саналын томьёололд нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 35  
Бүгд: 100  
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.2.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн тооцоололд өөрчлөлт оруулах болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналын томъёололтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн холбогдох хуулийн төслийг боловсруулж Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63  
Татгалзсан: 37  
Бүгд: 100  
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

#### **Хоёр.Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан санал:**

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49  
Татгалзсан: 49  
Бүгд: 98  
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 41

Бүгд: 98

58.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 42

Бүгд: 98

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсений гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601502049 төслийн кодтой “Ерөнхий боловсролын сургуулиудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 26,146.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “3 дугаар сургуулийн биеийн тамирын заалны барилга /Баян-Өлгий, Цэнгэл сум/, төсөвт өртөг ... сая төгрөг, санхүүжих дүн 1,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен үг хэлж, саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

38.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд төсвийн алдагдлыг тодорхойлсон зүйл, заалт байхгүй байгаа нь уг хуулийн 1.1 дэх заалттай зөрчилдөж байна. Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуулийн төсөлд төсвийн алдагдлыг тодорхойлсон зүйл, заалт байхгүй байгаа тул “Төсвийн алдагдлыг тодорхойлсон зүйл, заалтыг Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагаас давсан орлогоор санхүүжүүлсэн тооцоог тусгах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлж, саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

39.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн тооцоололд төсвийн алдагдал 1,380,000.0 сая төгрөг гэж гаргахдаа Нийгмийн даатгалын сангийн зарлагаас давсан орлого 1,281,362.7 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагаас давсан орлого 354,002.6 сая төгрөгийг ашигласан нь Нийгмийн даатгалын сангийн тухай хуулийн 12.2-т “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд нь шилжүүлэн зарцуулах, нэгтгэх, зориулалтын бусаар ашиглахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн тул тооцооллоос хасаж, төсвийн алдагдлыг 3,015,365.4 сая төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 2.9 хувьтай тэнцүүлж бодитоор тооцох замаар 1,065,11.7 сая төгрөгөөр тэнцэл сайжруулах. Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601501785,

УТ2601501777, УТ2601501767 төслийн кодтой төсөл, арга хэмжээнээс бусад төслүүдийн санхүүжилтийг 2027 он болгон хойшлуулж, нийт 1,065,011.7 сая төгрөгийн буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 1.9 хувьд хүргэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлж, саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

40.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, ҮОМШӨ-ний даатгалын санд төвлөрсөн орлогыг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, Орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлийг үнэлж дүгнэлт хийх, хууль, эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулах, олон нийтэд сурталчлах зардалд 3,500.0 сая төгрөг, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан, эрт тэтгэвэрт гарсан ахмадуудыг асрах, сувилах, сэргээн засах зардалд 5,000.0 сая төгрөг, Олон нийтийн хяналтыг мэргэжлийн болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зардалд 1,500.0 сая төгрөгийг тус тус тусгах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлж, Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг тайлбар хийв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

41.Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагийн гаргасан, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 оны төсвийн жилд хэрэгжих хөрөнгө оруулалтын нийт зардал болох 3,267.3 тэрбум төгрөгийн зардлаас Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, зэвсэгт хүчин, боловсролын салбараас бусад салбарт 2026 онд шинээр баригдах барилга байгууламжийн хөрөнгө оруулалтыг тэвчих замаар нийт 301,066.7 сая төгрөгийн санхүүжилтийг хэмнэж, энэ эх үүсвэрээр Эрүүл мэндийн даатгалын сангийн төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцан төлөх даатгуулагчдын шимтгэлийн орлого 431,181.3 сая төгрөгийг 301,066.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 732,848.3 сая төгрөг болгох гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 46

Бүгд: 98

53.1 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан дараах зарим төсөл, арга хэмжээг хасаж болон санхүүжих дүнг бууруулж нийт 411,069.3 сая төгрөгийн 60 хувиар Боловсролын салбарын урсгал зардлыг, 20 хувиар Эрүүл мэндийн салбарын урсгал зардлыг, ахмад настны тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэлд 20 хувийг тусгах Үүнд:

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808085 төслийн кодтой “Аргалант-Баянцогт сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 26.7 км, төмөрбетон гүүр, 36 у/м /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 44,729.5 сая төгрөг, санхүүжих дүн 15,166.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808211 төслийн кодтой “Баруунбүрэн-Амарбаясгалант хийд чиглэлийн хатуу хучилттай авто зам, 33.4 км /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 39,472.1 сая төгрөг, санхүүжих дүн 15,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808162 төслийн кодтой “Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66 км /Баруун бүс/, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 150,926.6 сая төгрөг, санхүүжих дүн 23,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804339 төслийн кодтой “Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай авто зам, 54.18 км /Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 66,368.6 сая төгрөг, санхүүжих дүн 42,904.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804371 төслийн кодтой “Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 44,988.8 сая төгрөг, санхүүжих дүн 30,499.8 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804360 төслийн кодтой “Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замаас Хужирт сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 43.3 км /Өвөрхангай, Хужирт сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 69,037.3 сая төгрөг, санхүүжих дүн 38,576.2 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804406 төслийн кодтой “Ховд-Дөргөн сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 40.7 км /Ховд, Дөргөн сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 49,854.2 сая төгрөг, санхүүжих дүн 25,159.7 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804412 төслийн кодтой “Хэрлэн голын төмөрбетон гүүр, 265 у/м, хатуу хучилттай авто зам, 14.2 км /Хэнтий, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 49,920.1 сая төгрөг, санхүүжих дүн 21,065.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102800632 төслийн кодтой “Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай авто зам, 122.4 км /Төв, Угтаалцайдам, Цээл, Заамар сум/, хэрэгжих хугацаа 2022-2026 он, төсөвт өртөг 182,566.3 сая төгрөг, санхүүжих дүн 80,101.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800805 төслийн кодтой “Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 37 км /Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 106,868.4 сая төгрөг, санхүүжих дүн 20,036.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт

өртөг 170,899.7 сая төгрөг, санхүүжих дүн 25,635.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800907 төслийн кодтой “Хэрлэн голын төмөрбетон гүүр, 217.6 у/м /Дорнод, Хэрлэн сум/ хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 22,845.1 сая төгрөг, санхүүжих дүн 6,053.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400215 төслийн кодтой “Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/ хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 8,396.8 сая төгрөг, санхүүжих дүн 3,778.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2403100364 төслийн кодтой “Өвлийн спортын ордны барилга /Дархан-Уул, Дархан сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 22,438.0 сая төгрөг, санхүүжих дүн 6,423.7 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102900758 төслийн кодтой “Гандангийн дэнж” шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв, барилгын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг 23,484.9 сая төгрөг, санхүүжих дүн 6,130.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601900178 төслийн кодтой “Үр тариа хадгалах агуулах /Увс/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 9,000.0 сая төгрөг, санхүүжих 4,050.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602001067 төслийн кодтой “Хавдар судлалын Үндэсний төв-II” цогцолборын А, С блокийн барилга, гадна шугам сүлжээ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 234,232.9 сая төгрөг, санхүүжих 40,523.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 20,261.0 сая төгрөгөөр бууруулах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602001014 төслийн кодтой “Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Үндэсний оношилгоо, эмчилгээний төв барилгын их засвар /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 4,383.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 2,191.5 сая төгрөгөөр тус тус бууруулах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлж, саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

*Хуралдаан 18 цаг 21 минутаас 18 цаг 36 минутад түр завсарлав.*

**Б.Пүрэвдорж:** 43.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601900239 төслийн кодтой “Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн паркийн арьс шир, боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих

хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 9,438.3 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 2,831.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51  
Татгалзсан: 44  
Бүгд: 95  
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601900237 төслийн кодтой “Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн паркийн цахилгаан хангамж, гол шугам сүлжээний ажил /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,953.6 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 1,779.2 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57  
Татгалзсан: 38  
Бүгд: 95  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400215 төслийн кодтой “Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 8,396.8 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 3,778.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56  
Татгалзсан: 39  
Бүгд: 95  
58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 641.6 сая төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр “Шихихутаг нууц товчоо түүхэн аялал жуулчлалын цогцолборын барилга”-ын нэмэлт төсөв /Хэнтий, Норовлин сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн 641.6 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг нэмж тусгах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58  
Татгалзсан: 37  
Бүгд: 95  
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 238.6 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Их хуралдай цогцолборын барилга”-ын гадна тохижилтын нэмэлт ажил, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн 238.6 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмж тусгах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58  
Татгалзсан: 37  
Бүгд: 95  
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 685.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Монголын нууц товчоо цогцолборын барилга”-ын гадна тохижилтын нэмэлт ажил, /Хэнтий, Дэлгэрхаан сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн 685.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмж тусгах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52  
Татгалзсан: 43  
Бүгд: 95  
54.7 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606700119 төслийн кодтой “Төрийн цахим үйлчилгээ, хиймэл оюун, их өгөгдлийн суурь дэд бүтцийн тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 19,445.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 700.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын төсвийн багцад “Өсвөрийн инженерүүдийн инновацийн төвийн барилгын ТЭЗҮ, зураг төсөв”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 700.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 88  
Бүгд: 95  
7.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

50.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 700.0 сая төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцад “Нийслэлийн түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд унадаг дугуй, скүүтэрийн гүүрэн тусгай зам барих ТЭЗҮ, зураг төсөв, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 700.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 69  
Бүгд: 95  
25.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

51.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Хүнсний болон үрийн буудайн нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, эргэлтийн хөрөнгийн сантай болгоход зориулсан татаасыг 23,000.0 сая төгрөгөөр бууруулах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58  
Татгалзсан: 37  
Бүгд: 95  
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд инновац нэвтрүүлэх, тухайн жилд худалдан авсан техникт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх, бордоог хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, бэлчээрийн ашиглалт, хамгааллыг сайжруулах, отрын нөөц бэлчээр, усан хангамж, өвс тэжээлийн нөөц, хангамжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулсан татаасыг 24,300.0 сая төгрөгөөр бууруулах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59  
Татгалзсан: 36  
Бүгд: 95  
62.1 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Атрын 4 дүгээр аянд зориулсан Хүнсний ногооны урамшууллын татаасыг 11,500.0 сая төгрөгөөр бууруулах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57  
Татгалзсан: 38  
Бүгд: 95  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

54.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Цагаан алт хөтөлбөрийн ноосны урамшууллын татаасыг 15,600.0 сая төгрөгөөр бууруулах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58  
Татгалзсан: 37  
Бүгд: 95  
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь арьс ширний урамшууллын татаасыг 6,200.0 сая төгрөгөөр бууруулах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55  
Татгалзсан: 40  
Бүгд: 95  
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Цагаан алт хөтөлбөрийн “Бусад арга хэмжээ”-нд тусгагдсан санхүүжилтийг 600.0 сая төгрөгөөр бууруулах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57  
Татгалзсан: 38  
Бүгд: 95  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

57.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн хүүгийн дэмжлэгийг 608,900.0 сая төгрөгөөр бууруулах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58  
Татгалзсан: 37  
Бүгд: 95  
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, Ц.Мөнхбат, Г.Ганбаатар, Р.Эрдэнэбүрэн нарын гаргасан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багц дахь Эдийн засгийн хөгжлийн

төлөвлөлт хөтөлбөрийн зардлыг 856.3 сая төгрөгөөр бууруулж, Говийг усжуулах судалгааны нэгжийн урсгал зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 81

Бүгд: 95

14.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

59.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багц дахь Агаар орчныг бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийг 78,530.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, энэ эх үүсвэрийг дараах төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжих дүнг бууруулж болон төслөөс хасаж тооцох. Үүнд:

-Төслийн 2 дугаар хавсралтын УТ2600100054 төслийн кодтой “Ерөнхийлөгчийн Тамгын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 500.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээг хасах;

- УТ2600200018 төслийн кодтой “Улсын Их Хурлын Тамгын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 3,637.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2601200838 төслийн кодтой “Гадаадын иргэн, харьяатын газрын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,365.4 сая төгрөг, санхүүжих дүн 1,064.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2601200355 төслийн кодтой “Цагдаагийн газрын барилга /Булган, Булган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 5,353.6 сая төгрөг, санхүүжих дүн 1,606.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2601501976 төслийн кодтой “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн эмнэлгийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 9,237.6 сая төгрөг, санхүүжих дүн 2,771.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2601501953 төслийн кодтой “Хангайн бүсийн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цогцолборын гадна тохижилт /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,126.8 сая төгрөг, санхүүжих дүн 1,407.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2602800888 төслийн кодтой “Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Зүүн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 60,156.2 сая төгрөг, санхүүжих дүн 18,046.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2602800636 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архустын гудамж хүртэлх авто замын өргөтгөл,

шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 170,899.7 сая төгрөг, санхүүжих дүн 25,635.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2603400215 төслийн кодтой “Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 8,396.8 сая төгрөг, санхүүжих дүн 3,778.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2603400522 төслийн кодтой “Спорт заалны барилга /Ховд, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,103.4 сая төгрөг, санхүүжих дүн 1,396.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2603400239 төслийн кодтой “Спорт заалны барилга /Хөвсгөл, Түнэл сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,156.8 сая төгрөг, санхүүжих дүн 970.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2603400052 төслийн кодтой “Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 6,728.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,018.7 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2602900939 төслийн кодтой “Инженерийн шугам сүлжээ /Ховд, Дарви сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,792.7 сая төгрөг, санхүүжих дүн 1,256.8 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2602900037 төслийн кодтой “Үерийн хамгаалалтын барилга, байгууламж, далан суваг /Хөвсгөл, Их-Уул сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,652.9 сая төгрөг, санхүүжих дүн 1,643.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2602900572 төслийн кодтой “Үерийн хамгаалалтын далангийн 2, 3 дугаар ээлжийн байгууламж /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 10,407.8 сая төгрөг” санхүүжих дүн 3,122.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2602900674 төслийн кодтой “Үерийн хамгаалалтын далангийн байгууламж, 5 км /Завхан, Улиастай сум, Жаргалант, Чигэстэй баг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 7,829.8 сая төгрөг, санхүүжих дүн 3,523.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2606700065 төслийн кодтой “Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 14,368.5 сая төгрөг, санхүүжих дүн 4,310.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2603300016 төслийн кодтой “Авлигатай тэмцэх газрын барилгын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 239.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах;

- УТ2601300963 төслийн кодтой “Цаг уурын харуулын барилга /Баян-Өлгий, Булган, Увс, Баянхонгор, Дундговь, Хөвсгөл, Архангай, Говь-Алтай, Завхан, Ховд/,

хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 388.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах;

УТ2601501638 төслийн кодтой “Дотуур байрын барилга, 75 ор /Сүхбаатар, Халзан сум, 1 дүгээр баг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,695.5 сая төгрөг, санхүүжих дүн 1,213.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц үг хэлэв.

Зөвшөөрсөн: 50  
Татгалзсан: 45  
Бүгд: 95  
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

60.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2101101137 төслийн кодтой “Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 546,556.0 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 121,721.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,390.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны “Тарифт цалингийн жишиг шинэчлэн батлах тухай” 95 дугаар тушаал батлагдсантай холбогдуулан үүссэн зардлын зөрүү 1,111.0 сая төгрөг, Монгол Улсын дээд шүүхийн байр /Хангарди/-ны гадна фасадыг дулаалах, засварлах ажлыг гүйцэтгэх 279.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48  
Татгалзсан: 47  
Бүгд: 95  
50.5 хувийн саналаар дэмжигдлээ.

61.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 170,899.7 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 25,635.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,798.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Прокурорын газрын цахим хавтаст хэрэг, зөрчлийн системийн сервер, тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг 4,798.0 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 4,798.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52  
Татгалзсан: 43  
Бүгд: 95  
54.7 хувийн саналаар дэмжигдлээ.

62.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой “Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу

хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 216,979.6 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 12,631.3 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Дүүргийн шүүхийн нэгдсэн барилга /Хан-Уул цогцолбор/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 75,254.5 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 28,663.5 сая” төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 12,631.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49  
Татгалзсан: 46  
Бүгд: 95  
51.6 хувийн саналаар дэмжигдлээ.

63.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын урсгал зардлыг 300.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.  
Зөвшөөрсөн: 19  
Татгалзсан: 76  
Бүгд: 95  
20.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

64.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Боловсрол, Эрүүл мэнд болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбараас бусад салбарын урсгал зардлыг 15 хувиар бууруулж, энэ эх үүсвэрээр ахмад настнуудын тэтгэврийг 10 хувь дээр нэмэх 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг 567.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52  
Татгалзсан: 43  
Бүгд: 95  
54.7 хувийн саналаар дэмжигдлээ.

65.Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагийн гаргасан, Бүх төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардлыг 2 хувь буюу 770.0 тэрбум төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудын цалинг 50 хувиар нэмэхээр тооцож Эрүүл мэндийн сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 45  
Татгалзсан: 50  
Бүгд: 95  
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51  
Татгалзсан: 45  
Бүгд: 96  
53.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 50  
Татгалзсан: 46  
Бүгд: 96  
52.1 хувийн саналаар дэмжигдлээ.

66.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ч.Анар, Х.Баасанжаргал, Ж.Галбадрах, Д.Бум-Очир, Д.Ганмаа, Б.Жаргалан, Ж.Золжаргал, С.Зулпхар, Б.Мөнхсоёл, А.Ундраа, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, Б.Хэрлэн, Д.Энхтүвшин нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Их Хурлын даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн “2.1.1.1 Хууль тогтоомжид хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байна.” гэсэн дэд заалтыг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц үг хэлэв.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 94  
Бүгд: 96  
2.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

67.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ч.Анар, Х.Баасанжаргал, Ж.Галбадрах, Д.Бум-Очир, Д.Ганмаа, Б.Жаргалан, Ж.Золжаргал, С.Зулпхар, Б.Мөнхсоёл, А.Ундраа, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, Б.Хэрлэн, Д.Энхтүвшин нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Их Хурлын даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “2.1.1.2 Хүний эрхийг хангах чиглэлээр баталсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%.” гэсэн дэд заалт, “2.1.1.3 ОУ-ын гэрээ, конвенцын хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “2.1.1.4 Хүний эрх, жендерийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээний хэрэгжилт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 48.3, Зорилтот түвшин: 50.7” гэсэн дэд заалт, “2.1.1.5 Шийдвэр гаргалт нь олон нийтийн оролцоотой, иргэдийн санаа бодлыг тусгасан үр дүнтэй гэдэгт итгэдэг хүн амын эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 48.3, Зорилтот түвшин: 50.7” гэсэн дэд заалт, “2.1.1.6 Хууль, шийдвэрийн давхардал, хийдэл, зөрчлийн тоо буурсан хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024,

Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т-10%” гэсэн дэд заалт тус тус нэмэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 76

Бүгд: 96

20.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

68.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ч.Анар, Х.Баасанжаргал, Ж.Галбадрах, Д.Бум-Очир, Д.Ганмаа, Б.Жаргалан, Ж.Золжаргал, С.Зулпхар, Б.Мөнхсоёл, А.Ундраа, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, Б.Хэрлэн, Д.Энхтүвшин нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “4.1.1.1 Хяналтын шатны журмаар шийдвэрлэгдэж буй хэргийн дундаж хугацаа /бууруулах/ Хэмжих нэгж: Хоног, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т-10%” гэсэн дэд заалт, “4.1.1.2 Хууль хэрэглээний нэгдмэл байдлын түвшин. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2023, Суурь түвшин: 67.8, Зорилтот түвшин: 70” гэсэн дэд заалт, “4.1.1.3 Хууль тогтоомжийг боловсронгуй болгохоор боловсруулж хүргүүлсэн санал. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 3, Зорилтот түвшин: 6” гэсэн дэд заалт, “4.1.1.4 Судалгааны чанарыг дээшлүүлэх арга хэмжээ. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 0, Зорилтот түвшин: 1” гэсэн дэд заалт, “4.1.1.5 Шүүхийн цахимжилт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2023, Суурь түвшин: 76.4, Зорилтот түвшин: 79” гэсэн дэд заалт, “4.1.1.6 Шүүхийн шийдвэрийн нээлттэй, ил тод байдал. Хэмжих нэгж: Хоног, Суурь он: 2024, Суурь түвшин: 22.7, Зорилтот түвшин: 20” гэсэн дэд заалт, “4.1.1.7 Шүүн таслах ажиллагаанд оролцоход шаардлагатай хүртээмжийн үйлчилгээ хүссэн иргэдэд эзлэх үйлчилгээ авч чадсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “4.1.1.8 Хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн талаарх мэдээллийг тэгш хүртээмжтэй (дохионы хэлмэрч, хадмал орчуулга зэрэг хүртээмж) олон нийтэд мэдээлсэн мэдээллийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 0, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “4.1.1.9 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн эрхийг хангасан арга хэмжээ. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10” гэсэн дэд заалт, “4.1.1.10 Шүүхийн шийдвэрийг ойлгомжтой байлгах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ (шүүхийн шийдвэрийн тойм, хураангуй бичсэн тоо ба нийт шийдвэрийн харьцаа, олон нийтэд нээлттэй мэдээлсэн байдал). Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “4.1.1.11 Давж заалдах тогтолцооны үр нөлөө (хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцсэн үндэслэл). Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10” гэсэн дэд заалт, “4.1.1.12 Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-д заасан арга хэмжээний хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт тус тус нэмэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 89

Бүгд: 96

7.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан 6 асуудлын хүрээнд гүйцээн боловсруулах чиглэл авах тухай горимын санал дэмжигдсэнтэй холбогдуулан бусад саналыг Төсвийн байнгын хороонд чиглэл өгч, буцаасан тул санал хураалт явуулаагүй болно.

*Уг асуудлыг 20 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн референт Б.Нарантуяа, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 7 цаг 09 минут үргэлжилж, 126 гишүүнээс 101 гишүүн хүрэлцэн ирж, 80.2 хувийн ирцтэйгээр 20 цаг 02 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
*2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр, Баасан гараг*  
*Төрийн ордон “Их хуралдай” танхим*  
*10 цаг 33 минут.*

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Нийт 126 гишүүнээс 66 гишүүн, 67 гишүүн. Ирж 53,2 хувьтай боллоо. Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 5 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна./ Засгийн газар 2025 оны 9 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ./ Зарчмын зөрүүтэй 15 саналтай.

2 дугаарт “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ./Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025 оны 10 сарын 6-ны өдөр өргөн мэдүүлсэн, үргэлжилнэ/

3 дугаарт Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулна. /Засгийн газар 2025 оны 09 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/ зарчмын зөрүүтэй 160 саналтай.

4 дүгээрт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулна. /Засгийн газар 2025 оны 09 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/ тодорхой асуудлын хүрээнд.

5 дугаарт Баталсан хуулийн эцсийн найруулгыг сонсоно.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.**

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж дууссан.

Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 15 санал байна. Гишүүд санал

хураалтад бэлтгэе. Ердийн олонх. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно.

Зарчмын зөрүүтэй санал нь энд ороогүй байна шүү дээ.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

### **Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал**

**Нэг.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.**

Төсөлд доор дурдсан 1 дүгээр зүйл нэмэх:

**“1 дүгээр зүйл.**Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай 17<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

#### **17<sup>1</sup> дүгээр зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт**

17<sup>1</sup>.1.Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1.а дэх дэд заалтыг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дагаж мөрдөнө.

17<sup>1</sup>.2.Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1.б дэх дэд заалтыг 2027 оны төсвийн жилээс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Бадамсүрэн, Ц.Баатархүү, Ж.Баясгалан, Б.Бейсен, Г.Лувсанжамц, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Д.Энхтүвшин /цаашид “ажлын хэсэг” гэх/. Санал хураалт. Зарим хүмүүс төхөөрөмждөө орж амжаагүй гэж байна. 1 нь санал гаргана даа. Бум-Очир.

**Д.Бум-Очир:** Уучлаарай төхөөрөмжид орж амжаагүй байсан байна. Санал хураалтаа дахин явуулж өгнө үү. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Хүчингүй болгох санал гаргах ёстой .

**Д.Бум-Очир:** Төхөөрөмждөө орж амжаагүй байсан байна. Уучлаарай. Саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахиж санал хураалт явуулж өгнө үү.

**Б.Пүрэвдорж:** Дуламын Бум-Очир гишүүний саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт. 74 гишүүнээс 48 дэмжиж, 64,9 хувиар дэмжигдлээ.

Түрүүн уншсан саналын томьёоллын дагуу дахин санал хураалт явуулъя. 74 гишүүнээс 46 гишүүн дэмжиж, 62.2 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 15.2.1.а дахь дэд заалтын “2026 оны татварын жилээс эхлэн” гэснийг “албан татвар төлөгчийн албан татвар суутган төлөгчтэй хийсэн” гэж, “1 дүгээр зүйл” гэснийг “2 дугаар зүйл” гэж, “2 дугаар зүйл” гэснийг “3 дугаар зүйл” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 75 гишүүнээс 51 гишүүн дэмжиж, 68 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “01 дүгээр” гэснийг “10 дугаар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 75 гишүүнээс 53 гишүүн дэмжиж 70,7 хувиар санал дэмжигдлээ.

4.Саналын томъёоллын 1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 75 гишүүнээс 54 гишүүн дэмжиж 72 хувиар санал дэмжигдлээ.

**Хоёр.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.**

### **Найруулгын санал**

1.Төслийн 4 дүгээр зүйлийн “8.1.3 дахь заалтын “төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрлийг авах” гэснийг “төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийг авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлэх” гэж, мөн зүйлийн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 75 гишүүнээс 52 гишүүн дэмжиж, 69,3 хувиар санал дэмжигдлээ.

**Гурав.“Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.**

1.Төслийн 1 дэх заалтын “Монгол Улсын Үндэсний 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах” гэснийг “Монгол Улсын Үндсэн хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдох зарчмын” гэж өөрчлөх.Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 75 гишүүнээс 45 гишүүн дэмжиж, 60 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дахь дэд заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 76 гишүүнээс 52 гишүүн дэмжиж, 68,8 хувиар санал дэмжигдлээ. 68,4 хувиар.

3.Төслийн 3 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3/Энэ тогтоолын 1 дэх дэд заалтыг хэрэгжүүлэхдээ хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, бүтээгдэхүүн арилжаалах зэрэг бүхий л үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод нээлттэй, үр ашигтай зохион байгуулах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 76 гишүүнээс 52 гишүүн дэмжиж, 68,4 хувиар санал дэмжигдлээ.

### **Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал**

**Нэг.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.**

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 18.4 дэх хэсгийн “хийж болно” гэснийг “хийнэ.” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Саналтайгаа холбогдуулан санал гаргасан гишүүн үг хэлэх боломжтой. Эрдэнэбат гишүүн үг хэлье.

**С.Эрдэнэбат:** Энэ дээр нийгмийн үнэлгээ хийж болно гэсэн байж байгаа юм. Тэгэхээр ер нь Төр, хувийн хэвшлийн түншлэлүүдтэй хийх энэ гэрээ контрактууд төслийг сонгон шалгаруулахдаа нийгмийн шууд болон дам нөлөөллүүдийг бид нар бас үнэлгээнд нь оруулж өгвөл энэ өөрөө эргээд нийгэмд хэрэгтэй. Тийм учраас энийг бол болно гэдэг нь бол болохгүй ч байсан болно гэдэг ийм давхар агуулга хийж байгаа учраас нэгэнт тийм асуудлыг оруулж ирж байгаа бол нийгмийнх нь үнэлгээнүүдийг хийж, тухайн тэр орон нутаг, бүс нутаг, хот, салбартаа ямар нийгмийн үр өгөөжтэй юм бэ гэдэг талаар нь ийм үнэлгээ хийж байвал илүү бүтээн байгуулалтууд хийх ажлууд бол утга төгөлдөр, ард иргэд ч гэсэн ойлгох ийм ийм зүйл юм. Тийм учраас та бүгдийг энэ саналыг бол дэмжихгүйгээр босгож, хуулийн төсөлд оруулж ирэхийг хүсэж байна. Хүрэхгүй гэсэн үг. 4 дүгээр санал бас мөн ялгаа байхгүй. Кноп хүрэхгүйгээр босгож, дэмжиж өгөхийг хүсье.

**Б.Пүрэвдорж:** Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 76 гишүүнээс 41 гишүүн дэмжиж, 53,9 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 76 гишүүнээс 51 гишүүн дэмжиж, 67,1 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг. Өөрийнхөө саналыг тайлбарлаж Энхцэцэг гишүүн үг хэлнэ.

**С.Энхцэцэг:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Төр, хувийн хэвшлийн тухай хуулийн 6.1 гэсэн заалт болохоор ямар заалт вэ гэхээр аймаг, нийслэл бонд гаргаад төр, хувийн хэвшлийн хөрөнгөөр эрчим хүчний эх үүсвэр барих ийм боломжийг нээж өгч байгаа. Тэгээд яг төр, хувийн хэвшил дээр ямар заалт байдаг вэ гэхээр 2 хязгаарлалтыг оруулж өгсөн заалт байдаг юм.

Нэг нь болохоор тухайн аймаг, нийслэл нь 100 мянган айлаас дээш байх;

2 дугаарт нь болохоор улсын төсвөөс ямар нэгэн зээлийг сүүлийн 3 жилд авахгүй байх тэр тохиолдолд эрчим хүчний эх үүсвэрийг барьж болно гэсэн ийм 2 хязгаарлалттай байдаг юм. Тэгээд энэ хуулиар болохоор тэр 2 хязгаарлалтыг авч хаях гээд байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ дээр яах вэ, нэг талаараа эрчим хүчний эх үүсвэрийг тухайн аймаг, нийслэл дур мэдээд барих ийм нөхцөл бий болж байгаа. Яах вэ, энэ бас байж болно. Гэхдээ энд ямар эрсдэл бий болгох вэ гэхээр та бүхэн мэдэж байгаа. Сүүлийн үед нийслэл маань нэлээн эрчим хүчний эх үүсвэрүүд барьж байгаа. Энэ дээр бол эрчим хүчний салбарын оролцоо, Сангийн яамны оролцоо ч гэдэг юм уу, ямар ч байсан ямар ч оролцоогүйгээр шалгаруулаад, тэгээд шалгаруулсныхаа дараа тэр нөгөө Пи Пи Эй бид нар ялангуяа цахилгаан эрчим хүчний хувьд цаашаа ер нь зах зээлийн хувьд либералчлах ёстой гэж маш их ярьж байгаа. Тэр хүрээндээ бид нар Улсын Их Хурлын ажлын хэсэг бол хуулийн орчныг

бүрдүүлэх гээд явж байгаа. Гэтэл энэ хуулиар нөгөө аймгууд маань дур мэдээд нөгөө бид нарын яриад байдаг өндөр тарифтай гээд байдаг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг 15, 16 центээр хэрвээ бариад явчих юм бол юун нөгөө эрчим хүчний салбарын либералчлал, юун нөгөө хямд тарифтай эрчим хүчний эх үүсвэрийг оруулах ийм бололцоо бол нэлээн хаагдахаар байгаа. Тийм учраас энэ дээр бол орон нутгийн хувьд дулаан хангамжийн хувьд бол угаасаа орон нутгийн шинж чанартай. Өөрөөр хэлбэл тухайн аймаг, сум, нийслэл бол дулаан хангамжийнхаа асуудлыг шийдээд явах боломжтой.

Цахилгаан хангамжийн хувьд бол бид нар системийн хэмжээнд, улсын хэмжээнд байдаг учраас нэгдсэн бодлогоор зангидаж явах ёстой. Тийм учраас бас тэр хязгаарлалтуудтай нь хэвээр нь үлдээе гэдгээр энэ заалтыг хасаач ээ гэсэн ийм саналыг оруулж байгаа. Тэгээд та бүхэн энийг товчдоо хүрэхгүй босгож өгөхийг хүсэж байна.

Энэ бол эрчим хүчний либералчлал. Тэгээд цаашдаа бол бид нар энэ Пи Пи Эй гэдэг буюу урт хугацаатай, өндөр тарифтай цахилгаан эрчим хүчний эх үүсвэр оруулах асуудлыг бол ер нь байхгүй болгохгүй бол энэ салбар бол эдийн засгийн хувьд бол маш хүнд байдалд орно.Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Яг энэ асуудал дээр энэ орон нутгийн эрх мэдлийн асуудал чинь байхгүй болж байгаа юм биш үү. Учрал сайд нэг тайлбарлаж хэлж өг дөө. Учрал сайд.

**Н.Учрал:** Энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль чинь бол орон нутагт эрх мэдлийг өгье, бие дааж түншлэлийн төсөл хэрэгжүүлье гэж оруулж ирсэн шүү дээ. Тэгэхээр ингээд буцаагаад аймаг өөрөө шийдэхгүй гэдэг ийм санал хураалгаад буцаж байхаар түншлэлийн хууль ач холбогдолгүй болчихоод байна шүү дээ. Аймаг, орон нутгаа дэмжье. Тийм учраас энэ дээр сая энэ кноп дарагдаагүй учраас санал дахиж хураалгаж өгөөч ээ гэж хүсэж байна.

**Б.Пүрэвдорж:** Ганхуяг гишүүн үг хэлье.

**Х.Ганхуяг:** Байнгын хороо дээр хураагдсан санал. Тэгээд Байнгын хорооны саналыг дэмжиж, та бүхэнд санал өгөхийг хүсье ээ. Тэгээд санал хураалт дахиж явуулж өгнө үү. Тэрийгээ микрофон дээрээ хэл л дээ.

**Х.Ганхуяг:** Сая кноп ажилласангүй.

**Б.Пүрэвдорж:** Ганхуяг гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. 80 гишүүнээс 43 гишүүн дэмжиж 53,8 хувиар дэмжигдлээ.

Тэгээд түрүүчийн Төслийн 3 дугаар зүйлийн 6 дугаар заалтыг хасах Энхцэцэг гишүүний Төсвийн байнгын хороондоо дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналаар дахин санал хураалт явуулъя. Санал хураалт дэмжигдсэнгүй.

Орон нутгийн эрх мэдэл нь тэгээд ямар ч эрх мэдэлгүй болчихлоо. Ер нь бол Улаанбаатар хотдоо бүх юмаа концессоор бүх юмаа хийчхээд эндээ л байнга ялалт

байгуулж байя. Орон нутаг бол ингээд хөгжихгүй хоосон хоцрог л гэдэг ийм МАН-ынхны санал боллоо шүү.

Төслийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалтын 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.1.7 дахь заалт нэмэх:

“25.1.7.нийгмийн нөлөөллийн шинжилгээний санал, дүгнэлт;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Төсвийн байнгын хороо. Та түрүүн тайлбарлаад хэлчихсэн за Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 80 гишүүнээс 43 гишүүн дэмжиж, 53,8 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 5 дугаар зүйлийн “заалт, 17 дугаар зүйлийн 17.1.2.б дэх дэд заалт, 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4.2 дахь” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэс гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя санал хураалт. 81 гишүүнээс 48 гишүүн дэмжиж, 59,3 хувиар дэмжигдлээ. Санал дэмжигдлээ.

**Хоёр.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.**

1.Төслийн 1 дэх заалтын “12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3-т” гэснийг “12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, 12.1.5-д” гэж, “мөн зүйлийн 12.1.4-т” гэснийг “мөн зүйлийн 12.1.4, 12.1.5-д” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг. Сайнзориг гишүүн саналтайгаа холбогдуулан үг хэлнэ.

**П.Сайнзориг:** Хурал даргалагчид баярлалаа. Энэ бол Засгийн газар үнэт цаас гаргах гэж байгаа юм. 2 чиглэлээр. Дотоодын болон гадаад валют босгох байдлаар. Дотоодын бондыг зөвхөн төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор гаргана гэсэн дээр би 12.1.5-ыг нэмж байгаа юм. Энэ нь өөрөө эргээд бас тодорхой хэмжээний бодлогын бичиг баримтад туссан энэ төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд бас гаргаж болно гэдэг нэг зүйл нэмье гэж байгаа. Өрийн удирдлагын тухай хууль дээр зааж өгч байна гэсэн үг. Энэ илүү их орон нутагт боломж гарна гэсэн үг.

2 дугаарт гадаад бонд дээр 1 тэрбум долларыг бас бонд, үнэт цаас гаргана гэж байгаа. Энэ дээр бас бодлогын бичиг баримтад туссан энэ зүйлүүдийг хэрэгжүүлэх байдалтай байж болно гэдэг зүйлийг л нэмж байгаа. Заавал гэсэн үг биш. Тэгэхгүйгээр 1 тэрбум долларыг зөвхөн өрийн удирдлагыг дахин зохицуулалт хийх гэдэг дээр гаргах гээд байгаа байхгүй юу. Өр зүгээр байгаа гэсэн мөртөө яагаад ингээд гаргаад байгааг би ойлгохгүй байна. Нэгэнт зүгээр байгаа гээд Жавхлан сайд маань хэлж байгаа учраас энэ бас мөрийн хөтөлбөр байдаг юм уу, улс оронд хэрэгтэй тэр төслүүд дээр үнэт цаас, бонд гаргах энэ эрхийг нь Засгийн газарт нээгээд өгье. Төсөв бол жоохон хязгаартай байгаа. Тэгээд энэ дээрээ харин Засгийн газар мэдээж холбогдох Өрийн удирдлагын тухай хуульд заасныхаа дагуу энэ боломжийг эдэлье гэдэг дээр байгаа. Тэгэхээр та бүгд энэ санал дээр бас кноподоо хүрэхгүйгээр босгож, дэмжиж өгөөч ээ гэж хүсэж байна.

**Б.Пүрэвдорж:** Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг томъёоллын дагуу санал хураалт явуулъя. Санал хураалт. 81 гишүүнээс 41 гишүүн дэмжиж 50,6 хувиар санал дэмжигдлээ.

**Гурав. “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.**

1. Төслийн 1 дэх заалтад дор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх:

“5/Тавантолгойн бүлэг ордтой холбоотойгоор байгуулсан, хэрэгжүүлсэн төрийн нууцад авсан гэрээ, хэлцэл, тэдгээрийг байгуулахыг зөвшөөрсөн, дэмжсэн төрийн нууцад авсан холбогдох бүх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу төрийн нууцаас гаргах арга хэмжээг 2026 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор авч хэрэгжүүлж, Монгол Улсын Их Хуралд тайлагнах.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг. Гаргасан саналтай холбогдуулан П.Сайнзориг гишүүн үг хэлнэ.

**П.Сайнзориг:** Манайхан энэ “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг төсөв дагуулаад Засгийн газар өргөн барьсан. Үүнтэй холбоотойгоор бас нийгэмд өрнөөд л байгаа. Ерөөсөө нүүрс гэдэг зүйлийг л тойроод л хулгай гээд, бие биедээ хоч өгч байгаа. Сая Засгийн газар яах вэ зүгээр гэрээнүүдийг бүгдийг нь ил тод болголоо гэсэн байна лээ. Тэгэхдээ энэ гэрээ бол зөвхөн ил тод болоод хангалттай биш байгаа. Энэ гэрээг байгуулах зөвшөөрөл өгсөн, чиглэл өгсөн одоо нууцад байгаа бүх шийдвэрүүдийг ил болгоно. Хэн ямар чиглэлээр аль түвшиндээ чиглэл өгөөд, аль түвшиндээ зөвшөөрөл өгөөд, энэ оффтейк гэрээнүүдийг чинь байгуулсан юм бэ гэдгийг 3 сарын 1-ний дотор, ирэх жилийн 3 сарын 1-ний дотор ил болгоод, буцаагаад ямархуу байдалтай хэрэгжүүлснээ Улсын Их Хуралд тайлагнаж гэдэг заалтыг л энэ тогтоол дээр оруулж өгч байгаа. Энэ ил тод байдлыг хангаж байж төсвийн орлого цаашдаа бүрдэнэ. Энэ бол ерөөсөө цэвэр төсвийн орлогыг бүрдүүлэхэд ил тод байдлыг хангая. Өмнөх энэ хулгай зэлгий гэдэг зүйл чинь хэний шийдвэрээр явчхаад байсан юм бэ гэдгээ ил тод болгоё гэдэг зүйлийг л хэлж байгаа.

Тийм учраас та бүгд битгий кноподоо хүрээсэй гэж бодож байна. Энийг кноподоо хүрч байгаа хүмүүс нууц л гэсэн үг. Нүүрсний хулгайг дэмжиж байна гэсэн үг. Тийм учраас энэ зүйл дээр кноподоо хүрэхгүй байж, энэ өнгөрсөн хугацаанд энэ оффтейк гэрээ болон бусад гэрээнүүдийн байгуулах зөвшөөрлийг аль институт ямар шийдвэрээр, хэн гэдэг этгээдүүд өгөөд байсан юм бэ. Ямар чиглэл өгөөд байсан юм бэ гэдгийг ил тод болгоё. Ингэж байж Монгол Улсын дараа нь төсвийн орлого бүрдэнэ. Энэ яриад байгаа хардалт сэрдэлтүүд бас цэгцэрнэ гэж үзэж байгаа. Тийм учраас гишүүд маань битгий энэ ногоон кноподоо хүрээрэй. Хүрч байгаа хүмүүсийг олон нийт харж байгаа байх. Харах юм бол та бүгд нүүрсний хулгайг өөрөө дэмжиж байгаа гэсэн энэ мессеж явна шүү гэдэг зүйлийг би бас энэ индэр дээрээс хэлье.

**Б.Пүрэвдорж:** Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 82 гишүүнээс 20 гишүүн дэмжиж, 24,4 хувиар санал дэмжигдсэнгүй.

4 дүгээр санал дээр 42 гишүүн дэмжиж 52,5 хувиар Байнгын хорооны санал дэмжигдсэн байна шүү гэдгийг хэлэх ёстой юм байна. 3 дахь санал дээр.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

11.03 цаг.

Хэлэлцэх. Асуудал 2. Дараагийн асуудалд оръё.

**“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.**

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан нэр өгсөн дарааллын дагуу асуулт асууж, үг хэлнэ. Дарааллын дагуу асуулт асуух зөвшөөрөл олгоё. Ренчиндоржийн Батболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Р.Батболд:** Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Энэ түр хороо санаачлагчаас асуумаар байгаа юм. Энэ уг нь Монгол Улсын Их Хурлын даргын 210 дугаар захирамжаар 2025 оны 5 сарын 8-нд ажлын хэсэг байгуулагдаад, ажиллаад байгаа. Тэгээд энэ нь болохоор стратегийн энэ ач холбогдолтой ордууд гэж байгаа боловч яг үнэндээ бол Ухаа худаг ордын асуудлаар ажиллаад байгаа ажлын хэсэг байгаа юм.

Таны Засгийн газрын үед Хууль зүйн сайдаар ажиллаж байсан Алтангэрэл гишүүний мэдээллийг сонсоод, тэн дээр 2 боть ном тараагдаад, ингээд бүх үйл ажиллагаатайгаа танилцаад, яваад байгаа ийм ажлын хэсэг байгаа юм. Энэ дотор уг нь 11 гишүүн байгаа юм. Ардчилсан намын Мөнхтулга гишүүнээр ахлуулсан, Баасанжаргал, Батболд, Батнайрамдал Б.Бат-Эрдэнэ, Болормаа, Бямбасүрэн, Зулпхар, Жаргалан, Нарантуяа-Нара, Пүрэвдаваа гэсэн ийм бүрэлдэхүүнтэй. Тэгээд энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг бас бид нар олох гэж нэлээн юм болсон. Нэлээн олон гишүүд байсан. Тэгээд ашиг сонирхол гэдэг юм уу, сонирхлын зөрчилтэй гээд нэлээн гишүүд нь өөрсдөө бас нэрээ татаад, больё гэсэн. Энэ ажлын хэсэг чинь орохгүй гээд ажилласан. Тэгээд энэ ажлын хэсэг маань өөрөө одоо ажлаа хийгээд явж байгаа. Шинжээчийн багаа томилуулчихсан. 3 чиглэлээр ажиллаад явж байгаа.

1 нь хууль эрх зүйн талаас нь, нөгөөдөх нь уул уурхайн талаас нь, 3 дугаарт нь санхүү талаас нь гээд ингээд 3 чиглэлээр ажлын хэсгээ байгуулчихсан яваад байгаа. Тэгээд энэ ажлын хэсгийг та ер нь яг юу гэж ойлгоод байгаа юм бэ. Бид нарыг ажил хийхгүй байна гэж ойлгоод байгаа юм уу. Яагаад гэнэт хянан шалгах ийм түр хороо байгуулах ийм санал, санаа төрсөн юм бэ гэдэг асуулт байгаа юм.

Би гайхаад байгаа нь энэ ажлын хэсэгт орчихсон 3 гишүүн маань бас энэ дээр гарын үсгээ зурчихсан байх юм. Тэгээд энийг бас гайхаад л байх юм. Баасанжаргал гишүүн, Батнайрамдал, Э.Болормаа гээд 3 гишүүн. Тэгээд ерөөсөө болохгүй байгаа юм уу. Яагаад байгаа юм. Энэ дээр юу гэж бодож байгаа юм. Энийг нэг тайлбарлаад өгөөч.

**Б.Пүрэвдорж:** Түр хороог санаачлагч Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Баярлалаа. Гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурал дээр тухайн үед ажлын хэсэг гарахад Засгийн газрын ажлын хэсгийг Алтангэрэл сайд ахлаад, Засгийн газар дээр бас бид нар нэлээн ийм томоохон мэдээллүүдийг Улсын Их Хурлын гишүүдэд нэг бүрчлэн бас хүргэсэн ийм ажил яг хийгдэж байсан. Үүний ард бас бид нар Мөнхтулга гишүүнтэй хэд хэдэн удаа бас санал солилцсон. Тэр уулзалтад Алтангэрэл сайд, миний хувьд ч гэсэн бас байж, яаж энэ мэдээллүүдийг илүү том агуулгаар нь хурдтай ажиллаж болох вэ. Зөвхөн 1, 2 референттэй, 1, 2 шинжээчидтэй ингээд бас явахааргүй нэлээн тийм том далайцтай хэмжээний асуудал учраас түр хороо байдлаар өргөтгөж ажиллах нь бол зүйтэй юм гээд. Ингээд үүний дараа Засгийн газар солигдчихсон. Засгийн газар солигдсоны дараа энэ мэдээллийг илүү өргөн хүрээнд өгч, бас иргэдийн мэдэх эрх хангагдахад Засгийн газар дээр бас ажиллаж байсан энэ ажлын хэсгийн туршлагатай гишүүдийг оруулах нь бас зүйтэй юм гэж үзсэн. Ийм үндэслэл байгаа.

Тэгээд хамтраад, оролцоод ажиллаж бол болно. Их Хурлын даргатай удирдлагуудтай санал солилцсон байгаа.

**Б.Пүрэвдорж:** Батболд гишүүн тодруулъя.

**Р.Батболд:** Яах вэ, одоо болохоор ийм юм оруулж ирчхээд, тэгээд хамтраад ажиллаж болно гэдэг юм яриад байх юм. Тэгэх байсан юм бол зүгээр ажлын хэсэг рүү бид нар ийм ийм бүрэлдэхүүнтэй оръё гэж хэлж болохгүй байсан юм уу гэдэг асуудал байгаад байна л даа. Тэгээд 1 асуудал гараад ирэхээр асуудлыг асуудлаар дараад байдаг ийм муухай юм чинь л яваад байгаа юм уу гэж зүгээр харагдаад байгаа юм. Одоо энэ түр хороо байгуулчихаар энэ ажиллаж байгаа ажлын хэсгээ яах юм. Энэ хүмүүсийг яах юм. Бид нарыг ажил хийгээгүй гэж үзээд байгаа юм уу, юу гэж бодоод байгаа юм. Энийгээ л нэг тайлбарлаад өгчихмөөр байгаа юм.

**Б.Пүрэвдорж:** Алтангэрэл гишүүн санаачлагчдын хувьд хариулж болно. Хариулъя.

**О.Алтангэрэл:** Манай Батболд гишүүн бол Мөнхтулга гишүүний байгуулсан ажлын хэсэгт бас идэвхтэй ажиллаж байгаа ийм гишүүн.

1 дүгээрт Мөнхтулга гишүүний ахалж байгаа ажлын хэсэг бол энэ стратегийн орд газрууд Оюутолгой, Асгатын мөнгөний орд, Тавантолгой гээд ер нь стратегийн ордыг бүтнээр нь ярих ёстой ажлын хэсэг. Тэгээд хууль зүйн дүгнэлт гаргах үүрэг бүхий гээд Улсын Их Хурлын даргын захирамж дээр тодорхой байдаг. Хянан шалгах түр хороо бол бид нар энийг ямар зорилготой байна гэхээр анх лицензийг нь яаж олгосон юм. Тэр олгосон нөхрийг дуудмаар байна. Яагаад өөрийнхөө хамааралгүй компанид авсан юм. Ямар, ямар албан тушаалтнууд оролцсон юм. Хэдэн төгрөгөөр цааш нь зарсан юм гээд илүү нарийн гэдэс дотрын ажил хийх гээд байгаа юм.

Тэгэхээр Хянан шалгах түр хорооны хүрээнд илүү өргөн, илүү олон мэдээлэл цуглуулах, илүү нарийн ажиллагаа хийх шаардлагатай байна л гэсэн ийм шаардлагын дагуу тогтоолын төсөл санаачлах шаардлагатай байна гэж үзэж бидний хэсэг гишүүд дэмжиж, гарын үсэг зурсан гэдэг тайлбарыг хэлье.

**Б.Пүрэвдорж:** Нэмж тодруулъя. Батболд гишүүн.

**Р.Батболд:** Яах вэ, энэ 210 энэ ажлын хэсэг чинь бол ер нь стратегийн орд гэсэн халхавчтай Ухаа худгийг шалгах гэсэн ажлын хэсэг л байгаа шүү дээ. Надад нэг их аль аль талд нь ороод байх юм алга. Зүгээр одоо манай намын даргын зүгээс намайг энэ түр хороонд оруулах ийм нэр өгчихсөн явж байгаа. Тэгээд би 1 асуудлаар 1 ажлын хэсэг дээр ажиллаад, 1 Хянан шалгах хороон дээр ажиллаад явах юм уу. Яах юм. Тэгээд энийгээ нэг тийш нь шийдээд өгөөч ээ л гээд би уг нь түрүүчийн Байнгын хорооны хурал дээр асуудлыг хойшлуулсан шүү дээ. Даргын дэргэдэх зөвлөл нь шийддэг юм уу, хэн нь шийдэх юм. Тэгээд хийх ажилгүй хүмүүс байгаа юм шиг 1 асуудлыг 1 ажлын хэсэг, 1 юу гээд яваад байх юм уу гэдэг асуудал л хөндөгдөөд байгаа юм л даа.

**Б.Пүрэвдорж:** Оюунсайханы Алтангэрэл гишүүн. Энэ тогтоол санаачлагч үг хэлдэг юм уу. Уг нь болдоггүй юм даа. Үг хэлье.

**О.Алтангэрэл:** Баярлалаа. Тэгээд өнөөдөр яг ингээд Монголын ард түмнийг сүүлийн 10 гаруй жил энэ төр засаг нийт төсвийг авч явж байгаа Тавантолгойн асуудлыг ярьж гэхээр Засгийн газар нь ингээд бүрэн бүрэлдэхүүнээ дэрхийгээд босоод гарчихлаа. 5-хан минутын өмнө. Засгийн газар нь ерөөсөө сонсохгүй. Ер нь ингээд энэ Ухаа худаг дээр юм ажиглагдаад байгаа. Тавантолгойн асуудал ярина гэхээр ирц хүрдэггүй, Тавантолгойн асуудал ярина гэхээр ямар нэг үл үзэгдэх гар гэдэг шиг ийм зохицуулалт явдаг. Ийм асуудлууд бол ер нь зөндөө гарч байгаа. Тэгээд би 2 үндсэн асуудлыг хэлэх гээд байгаа юм.

1 дүгээрт энэ байгалийн баялаг гэдэг юм чинь хэн нэгэн хүний өмч ерөөсөө биш ээ. Нутагт нь очоод, уул хангайг нь ухаад, талыг там болгочхоод өөрсдөд нь юу ч оногдохгүй байгаад энэ орон нутгийн иргэд чинь бухимдалтай байгаад байгаа юм. Сая сая тонноор нь хилээр зөөж гаргачхаад, амьдрал ахуйд нь нөлөөлөхгүй болохоор ард түмэн энд чинь ууртай байгаа юм. Тэгэхээр бид нар ер нь ганцхан энэ Тавантолгойн орд газар гэлтгүй, энэ Монголын баялгийг яаж иргэдэд тэгш хүртээмжтэй байх вэ гэдгийг ярих цаг болчихсон юм. Ярихын тулд бид нар эхнээс нь үзэх хэрэгтэй болчхоод байгаа юм. Яаж энэ Тавантолгой гэдэг том орд дамжиж, энэ олон хүний гар дамжив. Дунд нь хэн хэн гэдэг төрийн өндөр албан тушаалтан оролцов. Хэн хэн хувьдаа хэдэн сая долларын ашиг хийв гэдгийг бид нар үзэх болчхоод байгаа юм. Дуудаж ирээд асуугаад, Улсын Их Хурал хууль тогтоох дээд байгууллага мөн юм бол тэр эхийнхээ хүрээнд асуух ёстой болчхоод байгаа юм. Тэгээд зарим хүмүүст сануулж хэлмээр байгаа юм.

Хэн нэгэн нүүрсний хулгайчийг баяжуулах гэж Манлайбаатар Дамдинсүрэн гамингийн шоронд босоогоороо үхээгүй юм шүү.

Хэн нэгэн авлигачин түшмэлийн халаасанд мөнгө цутгах гэж Өвөрхангай аймгийн Төгрөг сумын харьяат Лувсанцэрэнгийн Аюуш гэдэг залуу 21 насандаа Жанчхүүгийн даваанд 12 буудуулж нас бараагүй ээ.

Хэн нэгэн төр дамнасан, олигархи компанийг баяжуулах гэж манай Уул уурхайн сайд Дамдиннямын төрсөн нутаг Увс аймгийн Өмнөговь сумын Бэгзийн Гиваан гэдэг залуу 1948 онд Байтаг богдод алуулаагүй юм.

Энэ чинь Монголын ард түмний үеийн үед эх орончдын цусаа урсгаж ирсэн эх орон, энд хадгалагдаж байгаа баялгийг өнөөдөр энэ эх орныхоо эздэд нь яаж хүртээмжтэй байх вэ гэдэг асуудлаа л ярьж байгаа юм. Цаашилбал, энд ерөөсөө

хувийн хэвшлийг төрд нийгэмчлэх, булааж авах ийм асуудал огт яригдаагүй. Яригдах ч ёсгүй. Улсын Их Хурал ийм юм хийх ёсгүй.

Тэгэхдээ бид энэ асуудлыг одоо ярьж эцэслэж, хувийн хэвшилдээ ч халгаагүй, гадаадын хөрөнгө оруулалтдаа ч ойлгомжтой, бодлогоо цаашид тодорхойлохын тулд одоо ярьж, эцэслэж, нэг тийш нь гаргаж явах зайлшгүй шаардлагатай болчихоод байгаа юм. Хэзээ ч дуусдаггүй нэг ийм хэрүүлтэй. Сүүлийн 10 гаруй жил л ярилаа. Энийг нэг эцэслэе л дээ. Улсын Их Хурал хууль тогтоох дээд байгууллага юм бол, ард түмний төлөөллийг шууд хэрэгжүүлж байгаа байгууллага юм бол энийг нэг эцэслээд, одоо шийдвэрээ гаргацгаамаар байгаа байхгүй юу.

Үүнээс цааш Монголын баялгийг ашиглахдаа энэ алдааг давтахгүй. Дундаас нь хэн нэгэн авлигачин, хэн нэгэн олигарх ингэж завшихгүй. Энэ баялаг ард түмэнд ингэж очно. Арга зам нь энэ юм. Яагаад гэвэл бид нар урьдын алдаандаа дүгнэлт хийчихсэн юм гэж хэлэхийн тулд бид нар энэ асуудлаар сонсгол хийх ёстой болчихож байгаа юм. Яагаад сонсгол хийх гээд байгаа юм бэ гэж асуугаад. Өмнө нь нүүрсний сонсгол гэж хийж байсан. Энэ сонсголын үр дүн одоо хүртэл үргэлжлээд, олон нийтэд олон асуудлыг ил тод болгоод явж байгаа. Тийм учраас энэ асуудлаар хэнийх нь зөв, хэнийх нь бурууг дэнсэлье. Баримттай ярья. Гэрчүүдийг сонсьё. Өнөөгийн Их Хурал энэ их хулгайг цэгцлэх, байгалийн баялгийг 1 нэгнээсээ өрсөж авах гэсэн энэ уралдаанд цэг тавих, хууль тогтоомжид нийцүүлэх ажлыг хийсэн тэр түүхэн Их Хурал байх боломжийг олъё л гэж энэ тогтоолын төслийг санаачилсан юм. Дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Ч.Лодойсамбуу:** Яах вэ, би Байнгын хороо дээр бас саналаа хэлсэн юм. Энэ Ухаа худгаа шалгана л биз. Гол нь бусад бүх нүүрсний ордыг хамтад нь оруулаад ирчхэж байгаа нь эргээд манай Ардчилсан намынхны санаачилга бүдгэрээд, ард талд нь ижил сэдэвтэй учраас гээд үлдчих гээд байгаа ийм эрсдэл байгаа юм гэдгийг сануулаад байгаа юм. Оюун-Эрдэнэ гишүүн бол яах вэ амаараа хэлж байгаа юм л даа. Би энэ дэмжиж байна. Би бүр хэлэлцүүлгээс тэрийг нь бүр салгаад авсан ч болно гэж байгаа юм.

Гэхдээ нөгөө үг яах вэ, бид нар чинь цаас гарч, гарсан шийдвэрээ харж, биелүүлж ажиллана. Тэгээд ганц хүний санал биш, энэ 33 гишүүн саналаа гаргачихсан байгаа учраас. Тэгээд энэ Их Хурлын дэд дарга, хурал даргалагчаас хүсэж байгаа юм. Энэ гарч байгаа тогтоолын төсөл маань өөрөө Хяналт шалгалтын тухай хуулийн 32.2-ыг хуулиа зөрччихсөн байгаад байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр хүрээ хязгаар маш тодорхой байх ёстой гэдгийг хүрээ хязгаар нь тодорхойгүй, хүрээ хязгааргүй болчихоод байгаа юм. Монголын бүх ордыг шалгая гээд байна шүү дээ. 5 жил Ерөнхий сайд хийсэн хүн нь өөрийнхөө байх үеийн шийдвэрүүдийг бүгдийг нь өөрөө шалгах болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр ерөөсөө би ямар санал гаргаад байна вэ гэхээр энийгээ салгаад, тодорхой болгочих. Ухаа худгаа шалгах нь шалгаад, бусад нь манай Ардчилсан намаас гарч байгаа гишүүдийн гаргаж байгаа санал нь бас тэр саналаараа яваад, ингээд бие биеийгээ шалгацгаая. Ер нь манайх ингээд нэг бодлогын реформ хийж чадахгүй, төр нь ингээд алдаа гаргахыг нь харж сууж байгаад алдаа гаргангуут нь сонсдог ийм л үйл ажиллагаа явуулдаг болчихсон юм шүү дээ. Тэгээд нэгэнт ингээд

цаашдаа энэ Засгийн газар шинэ реформын шинжтэй юм хийхгүй, алдаа гаргачхаад, гаргасан алдаагаа сонсоцгоодог, нэгнийгээ хянадаг, шалгадаг ажлаа хийх гэж байгаа юм бол бие биеийгээ тус тусад нь шалгая гэдэг л ийм санал гаргаж байгаа юм.

Тэгээд Дэгийн тухай хууль дээр болохоор энэ тогтоолын төслийг эцэслэн батлахдаа хэрвээ шаардлагатай гэж үзэх юм бол хурал даргалагч Байнгын хороонд 1 удаа буцааж болох юм байна лээ. Гэтэл энэ Хяналт шалгалтын тухай хуулиар болохоор энийг заавал Их Хурал нь шууд батална гээд заачихсан. Тэгээд Дэгийн тухай хуулиа дагах юм уу, Хяналт шалгалтын тухай хуулиа дагах юм уу мэдэгдэхгүй болчихоод байгаа юм. Ганц л зүйл байгаа нь салгачхаач ээ. Ухаа худгаа шалгах нь тэндээ шалгачих. Бусад хэлэлцээ, гэрээ хэлэлцээртэй холбоотой бүх мэдээлэл ил болсон ч гэсэн шалтгааны тухай асууж хянан шалгах түр хороо байгуулах Ардчилсан намынхаа саналыг бас тусад нь аваад үлдмээр байгаа юм. Тэгээд энийг яаж, хэрхэн шийдэх вэ л гэж хурал даргалагч нараас л бараг асуумаар санагдаад байгаа юм. Яаж энийг шийдэх вэ. Энэ ингээд энүүгээрээ явах юм бол манай Ардчилсан намаас гаргасан Түр хорооны санал бол байхгүй юм байна лээ л дээ. 1 сэдвээр, хаврын чуулганаар ч энийг оруулж ирэх боломжгүй болчих ийм эрсдэл үүсээд байгаа юм. Энийг яах вэ. Энэ дээр манай Тамгын газар тайлбар өгөөд, зөвлөөд, яах ёстой гэдгийг хэлээд өгөөч.

Тэгээд энэ санал гаргасан 33 гишүүнээсээ бас хүсэж байгаа юм. Хэрвээ энэ 33 гишүүн өөрсдөө хүсэх юм бол Хяналт шалгалтын тухай хуулиараа өөрсдөө хүсэх юм бол батлагдсан тогтоолдоо өөрчлөлт оруулах тогтоолыг бас өргөн барьж болох юм байна лээ. Тэгэхээр салгаад өгчхөөч гэж байгаа юм. Тэгээд л болоо. Тэгээд Ухаа худгаа тэрийг шалгацгаа. Бусдыг нь манай Ардчилсан намын гишүүд гаргасан саналынхаа дагуу бас шалгацгаая. Шударга шүү дээ.

**Б.Пүрэвдорж:** Лодойсамбуу гишүүний асуултад тогтоолын төсөл санаачлагч Оюун-Эрдэнэ гишүүн хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Би Эдийн засгийн байнгын хороо дээр гишүүний асуултад бол тодорхой хариулсан. Энэ дээр бол би санал нэг байгаа. Нэг үгээр хэлбэл Гашуунсухайт-Ганц модтой холбоотой манай Засгийн газрын үед хийгдсэн тэр гэрээтэй холбоотой энэ асуудлыг нягтлах нь бол зөв. Энэ бол ингээд ил тод байдлаа хангаад ингээд явах нь бол зөв. Энэ Ухаа худагтай холбоотой энэ асуудал бол угаасаа л Засгийн газар ярьж байсан асуудал. Бас сүүлийн 10 сарын хугацаанд нэлээдгүй их материалуудыг цуглуулаад, Их Хуралд өгсөн асуудал.

Тэгэхээр одоо бид нар бас гишүүнийхээ хувьд энэ мэдээлэл дээрээ үндэслээд, ажлаа хийх нь бас зүйтэй. Тийм учраас би энэ тогтоол батлагдсаны ард Пүрэвдорж дарга аа, юу яая. Лодой гишүүнтэй ярьж байгаад энэ саналыг 33 гишүүнтэйгээ ярилцаж хуралдаад, тогтоолд өөрчлөлт оруулах ийм саналыг Алтангэрэл гишүүнтэй бид нар ярьж байгаад эрх зүйн хувьд маргаангүй болох асуудал дээр ингэж хандаад явчихъя гэдэг тийм саналыг хэлж байна.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр юуны манай Тамгын газрынхан иж бүрдлийг бүрдүүлээд, өөрөөр хэлбэл тэр хүрээ, хамрах хязгаар энэ тэрийг бүгдийг нь харж байгаад, тэр хуулийн зохицуулалтын дагуу бүх бичиг баримтыг хүлээж авах ёстой. Тэгээд энэ шаардлагыг хангаад, энэ материал бичиг баримтыг өгсөн гэж би ойлгож байгаа.

Тийм учраас хэрвээ ингээд тэр сая Хяналт шалгалтын тухай хуулийн дагуу бас тодорхой хүрээг хамрах тийм дахин тогтоолыг өргөн барих бол энэ тогтоол санаачлагчдын өөрсдийнх нь эрхийн асуудал. Тийм учраас манай Их Хурлын Тамгын газрынхан ч бүрдэл хангасан л гэж оруулж ирж өгсөн байгаа. Дараагийнх нь Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Д.Ганбат:** Сайн байцгаана уу. Бид нар бас ямар ч байсан нөгөө парламентын засаглалтай улс орон бас болж л байна л даа. Бас ордон дотроо, энэ танхим дотроо бид нар асуудлаа шийдээд, төсвөө хэлэлцэж, ярилцаад ингээд явж байна. Энэ их сайн, зөв зүйтэй байна. Манай Пүрэвдорж дарга ч гэсэн ганц төрийн албан хаагч дээр сонин зан гаргаснаас биш, энэ Улсын Их Хурлыг бол их сайн удирдаж байна. Энэ төсвийг бол ингээд манай Ардчилсан нам, манай дэд дарга бол тэргүүлээд баталчих нь зөв. Та хэд маань тэгээд 15-аар арай тарчилгүй шиг, энэ Ази доторх нөгөө юу билээ 100 жил болж байгаа ууган нам гэдэг билүү. Тэгээд дүн нуруутай гарчхаарай гэж бас энэ парламентад нэлээн хэдэн хэдэн жил суусан хүний хувьд хэлчихье.

Улс орноо битгий нураачхаарай, намаа битгий тараачхаарай гэдгийг хэлье. Оюун-Эрдэнэ гишүүн маань маш хурдтай их сайн ажилласан. 33 гишүүнээр гарын үсэг зуруулаад, энэ хэл ам болоод байгаа энэ нүүрсний асуудлыг бас ард түмний мэдэх эрхийг хангая гээд ингээд явж байгаа нь их зөв зүйтэй. Гэхдээ тэр Эдийн засгийн байнгын хороо дээр бол бас их санал зөрөлдөж байгаа харагдана лээ.

Оффтейк гэрээ нөгөө Ухаа худаг 2 бол нэг дор ингээд үзье харъя гэсэн юм байгаа юм байна лээ. Тэр оффтейк гэрээ нь бол ихэнх нь Оюун-Эрдэнэ гишүүнийг Ерөнхий сайд байх үеийн нэлээн хэдэн гэрээ байгаа юм байна гэж ойлгосон. Тэгэхээр өөрөө өөрийгөө шалгах нь бол бас ашиг сонирхлын зөрчил байна уу, яана вэ. Тэр зүйлээ яриад, ганцхан Ухаа худгаа ярья гэдэг дээр та нар явж байгаа юм байна гэж ойлголоо. Тэрийгээ та нар нэг мөр болгочих.

Тэгээд Баярмаа гишүүн бид 2-оос санаачлаад, 40 гаруй гишүүн гар, хөлийн үсэг зурчихсан бас түр хороо байгуулах бас л нүүрстэй л холбоотой л доо. Гэхдээ Харбины гэрээтэй холбоотой юм. Үүний ач холбогдол нь юу гэхээр Харбины гэрээ бол бид нар жилийн л өмнө байгуулсан гэрээ. Тэгээд өөрөө байгуулсан Ерөнхий сайд нь ч гэсэн хэлж байгаа шүү дээ. Засаж залруулах зүйл байвал засаж залруулчхаарай энэ тэр гээд. Тэр Ухаа худаг оффтейк гэрээ бол хаашаа ч зугтаад алга болчихгүй. Байж л байгаа юм байж л байна. Харбины гэрээг бол бид нар бас тэр 3-ыг цогцоор нь гэж байгаа шүү дээ. Монголын ард түмэнд бага ч гэсэн зөв зүйтэй юм хийсэн бол зөв зүйтэй гэдгийг нь харуулаад, бас алдаа дутагдал байвал тэрийг нь бага дээр нь засаад ингэчих боломж байгаа юм. Тэгэхээр 1 л удаагийн чуулганаар 2 ийм түр хороо байгуулах ийм хуулийн зохицуулалттай. Тэгэхээр та хэдийнх маань хойшилчихвол энэ Харбины гэрээ очер дугаараар ороод ирэх юм. Тэр нь ч зөв зүйтэй байх. Ихэнх Улсын Их Хурлын гишүүд тэгж бодож байгаа юм байна гэж бас би ойлгоод байгаа. Бодвол энэ санал хураалтаараа ингээд харуулах байх л даа.

Тэгээд ер нь манайх чинь нүүрснээс л хамааралтай болчихоод байна шүү дээ. Өнгөрсөн 10 жилээ бид нар сайн ашиглаж чадаагүй. Одоо ирж байгаа 5 жил юу юугүй л ногоон эдийн засаг гэхгүй юм шиг байна. Тэр АНУ-ын Ерөнхийлөгч Трампын яриад байгаагаар бол бас нүүрсээ ашиглая, хаа сайгүй явъя гэж байна. Урд хөрш маань ч гэсэн бас зарлачихлаа. Бид нар нүүрс дээрээ 5, 6 жил, 10-аад жил байна

гэчихсэн байгаа. Энэ хугацаанд хэдүүлээ амжаад тэр төмөр замаа, гаргаж байгаа удаан хугацааны нүүрсээ, үнэ цэнээ энэ тэр бид нар яриад, бас ийм байна гэдгийг ард түмэндээ ойлгуулаад, засаж залруулах юм байвал засаж залруулаад ингээд явчихъя гэсэн ийм санаачилга байгаа юм.

Тэгээд аль алийг нь оруулаад явъя. Гэхдээ байрыг нь солиод явчихвал зөв зүйтэй байна. Эдийн засгийн байнгын хороо дээр та хэд маань ч тэгсэн юм байна. Өмнө нь байгуулсан тэр ажлын хэсэг байгаа шүү дээ. Мөнхтулга гишүүний ахалсан. Сая Батболд гишүүн яриад байна лээ. Тэд нар маань ч их идэвхтэй сайн ажиллаж байгаа юм байна лээ. Бараг 9 шинжээч авчихсан. Тэр хэдийгээ ажиллуулах гээд байдаг. Нөгөө хэд нь бас цалинг нь ч өгөөгүй юм байна лээ шүү дээ. Энэ Улсын Их Хурал чинь. Бас тэгж болохгүй л дээ. Хүн ажиллуулчихаад бас цалин цавууг нь өгөхгүй бол бас өөр хүмүүс л цалинг нь тавина шүү дээ. Тэгээд ийм ..../минут дуусав/

**Б.Пүрэвдорж:** Хариулах уу. Оюун-Эрдэнэ гишүүн хариулъя. Тэрнээс өмнө нэг юм зарлаадахъя.Одоо Оюун-Эрдэнэ гишүүн үг хэлсний дараагаар санал хураалт явуулна. Тийм учраас гишүүдийн ирцийг сайжруулах талаар ажиллаарай. 2 бүлгийн дарга.

**Л.Оюун-Эрдэнэ:** Энэ Ухаа худагтай холбоотой асуудлаас ингээд л бид нар тойрсоор л ирсэн юм байна лээ л дээ. Би Алтангэрэл гишүүнтэй бас санал нэг байгаа. Сая Эдийн засгийн байнгын хорооны хурал хэдэн ч удаа хойшлов. Миний мэдэхээр лав 4 удаа хойшилсон. Тэр нөгөө Харбинтай, Гашуунсухайт-Ганцмод хил холболттой холбоотой асуудлыг саяхан л бид нар Их Хурлаараа баталсан. Тэрийг тэгээд шалгахад нэг их оройтоод байхгүй байх. Хамтарсан Засгийн газрын үед баталсан. Энэ дээр би бүтэн нээлттэй байгаа. Харин энэ Ухаа худагтай холбоотой, нэгэнтээ ингээд бас ном материалууд гарчихсан ийм зүйл дээрээ ингээд ажиллаад явах нь бол зүйтэй байх. Би бас Их хурлын эрхэм гишүүддээ уриалж байна. Засгийн газар ч гэсэн нүүрстэй холбоотой асуудлыг ингээд гаргаж тавиад явж байгаа. Зөв. Гэхдээ Ухаа худгийг оруулахгүйгээр нүүрс яриад бол нэмэргүй шүү. Дээ. Бодийн оффтейкийг ярихгүйгээр бусад гэрээг ил болгоод нэмэргүй шүү дээ. Хамгийн томоос нь эхлэх ёстой биз дээ. Тэгэхгүй тэгээд нэг нөгөө гөлөг төөрүүлж байгаа юм шиг, тэгээд учиргүй баахан юм яриад, тэгээд тэр нь үнэн худлаа нь мэдэгдэхгүй баахан юм болоод, тэгээд бүх гарын үсгүүдээ гаргаад, хэний үед яасан байна. Тэгээд яриад явах нь л зөв.

Тийм учраас Их Хурлын эрхэм гишүүд та бүхэн маань энэ түр хороог бас дэмжиж өгөхийг хичээнгүйлэн хүсье. Энэ бол нийгэмд хүлээлт болчихсон ийм сэдэв шүү гэдгийг бас хэлье.

**Б.Пүрэвдорж:** Дашдондогийн Ганбат гишүүн нэмж тодруулна.

**Д.Ганбат:** Бид нар юмаа үзэж харах нь зүйтэй. Аль болохоор л ард түмний мэдэх эрхийг хангаж ажиллах ёстой. Түр хороо ч бас ялангуяа тэр Энхбаяр гишүүний ахалсан, Оюун-Эрдэнэ сайдын байх үеийн тэр нүүрсний түр хороо бол их сайн ажилласан. Нэлээн юмыг гаргаж өгч байсан. Цаашдаа ч түр хороог ажиллуулж байх нь зүйтэй юм байна.

Бас нэг юм байна. Юу байна вэ гэхээр бид нар хувийн хэвшил рүүгээ дайрдаг.

Хувийн хэвшлээ үгүйсгэдэг. Ийм байж болохгүй. Өнгөтэй, өөдтэй хэдхэн компаниуд л байна шүү дээ манайд. Гарч ирэх гээд л гарч ирж чадахгүй байна. Энэ хэд татвараа төлж байна. Тэд нар ажлыг нь сайн байр болгож байна. Цалинг нь өгч байна. Тэгээд улсаасаа баян компани болчихлоо гээд л дайрах гээд л байдаг. Зайлуул тэр хэд маань улсаасаа баян болж яасан ч чадахгүй байна. Үгүй ээ, дэлхий дээр АНУ-д тэр Америк улсаас чинь баян 20, 30, 100 компани байна шүү дээ. Тэгж л улс орон ...../минут дуусав/

**Б.Пүрэвдорж:** Оюун-Эрдэнэ гишүүн хариулъя.

**Л.Оюун-Эрдэнэ:** Хувийн хэвшилтэй холбоотой, хөрөнгө оруулагчтай холбоотой ямар ч асуудал байхгүй. Гагцхүү Монгол Улсын стратегийн орд Их Хурлаар орохгүйгээр шууд өгчих нь зөв үү, буруу юу гэдэг энэ асуудлыг л дүгнэх гэж байгаа юм.

Тийм учраас энэ дээр бас санаа зовохгүй байж болно гэдгийг хэлье.

**Б.Пүрэвдорж:** Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Ж.Баярмаа:** Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Сая гишүүд нэлээн асуух шиг болсон.

Хамгийн 1 дүгээрт Хянан шалгах тухай хуулийнхаа дагуу одоо орж ирсэн оффтейк гэрээг шалгах гэж байгаа гэдгээрээ ашиг сонирхлын зөрчилтэй байгаад, та энэ бүрэлдэхүүнд нь орж болох уу. Бүрэлдэхүүнд нь. Миний уншсанаар бол ашиг сонирхлын зөрчилтэй хүн бүрэлдэхүүнд нь орж болохгүй юм байна лээ. Түр хорооны. Тэгэхээр салгах нийлүүлэхийг бол мэдэхгүй. Ямар ч байсан ороод ирчихсэнээрээ бол та өөрөө өөрийгөө шалгах тухай л асуудал оруулж ирээд байна шүү дээ. Нөгөө хадны мангаа Ухаа худгийн нэр бариад, Ухаа худгийг урдаа барьчхаад, тэгээд нөгөө оффтейк гэрээнүүдийг өөрөө шалгах гээд байна л даа. Та 5 жил ажиллахдаа шалгахгүй юу хийж байсан юм бэ. Өмнө нь 2 жил ч билүү Хэрэг эрхлэхийн даргаар ажиллаж байхдаа аль эрт шалгаад учир начрыг нь олчихгүй яасан юм бэ. Тэгээд сүүлийн 1 жилийн тухайд бид нар асуугаад л байдаг байсан. Шалгаж байгаа юм уу, юу болж байна нөгөө Ухаа ухаан худаг гээд. Үндсэн хуулийнхаа дагуу тодорхой хувийг нь буцаад төрд авах ёстой гэдэг асуудлыг та сошиалаар бол байнга явуулдаг. Өөрөө ч хэлдэг. Тэр ажлаа та тэгээд юу болгосон юм бэ.

Миний санаж байгаагаар бол 7 хоног болгон та Эдийн засгийн зөвлөл дээр энэ Ухаа худгийн компанийн захиралтай уулзаад суудаг байсан шүү дээ. Тэр үеэрээ яг өөрөө ажлаа хийж байхдаа энийгээ яагаад шалгаагүй юм бэ. Ер нь тэр үр дүн чинь юу болсон юм бэ. Буцааж авах. Тэр асуудал. Нөгөө Үндсэн хуульд нийцүүлэх. 2 дахь асуудал. 1 дэх асуудал та бүрэлдэхүүнд нь орж болж байгаа юм уу гээд.

Одоо ингээд ярихаар та дахиад Ухаа худгийг шалгуулахгүй гээд уналаа гээд сошиалаар 15 давхраасаа балбуулаад унах уу. 3 дахь асуулт.

4 дэх асуулт. Ер нь бол Ухаа худгийг шалгаасай. Мэдсэн бол би бас тэр ажлын хэсэгт нь орьё гэж бодсон юм. Даанч мэдэгдэхгүй ингээд гялс зуруулаад явчихсан байна лээ.

5 дахь асуулт Харбины хэлэлцээр бол маш чухал, нэн шинэ байгуулагдсан гэрээ. Тэгэхээр энэ гэрээгээ асуудал дагуулахаас нь өмнө асуудал байгаа бол шалгаад, Монгол Улсын эрх ашгийн төлөө болгох шаардлагатай бол болгоод, ингээд засах нь нөгөө хэдэн жил ярьж байгаа тэр Ухаа худагтаа шалгахаас арай илүү үр дүнтэй юм биш үү.

Сая бүгд ярьж байна. Тэнд ажлын хэсэг байгуулагдчихсан ажиллаж байна шүү дээ. Тэгээд тэр ажлын мөнгө төгрөгийг нь яагаад өгөхгүй байгаа юм бол. Их Хурлын даргаас асуух уу. Санхүүжилтийн асуудлыг нь шийдэхгүй байгаа гэсэн. Тэрийгээ яагаад бушуухан шийдээд, тэр эксперт, эрдэмтдийн ажлыг нь хийлгэхгүй байгаа юм бэ. Нэгэнт эхэлчихсэн ажлыг.

Одоо биржээр нүүрсний үнэ хэд байгаа вэ. Бид нарын шалгах гээд байгаа гол нюанс чинь тэр байгаа шүү дээ. Биржийн үнээр худалдаж авахыг айлын тал хүлээн зөвшөөрлөө гэсэн 1 бичиг яваад байгаа шүү дээ. Гэхдээ 5 хувийн л хөнгөлөлт үзүүлээч ээ гэж хүссэн айлын тал гээд. Өөрөөр хэлбэл биржийн үнэ хэд байгаа вэ. 100 доллар байлаа гэхэд 5 хувь хөнгөлөөд 95, одоо бараг 120 байгаа байх. Тэгэхээр 100 гаруй доллароор зарах ийм боломж байсан юм биш үү. Тэрийг аль шатад нь хэн болиулаад, өнөөдөр 57 доллароор зараад байгаа юм бэ гэдэг асуудал яригдаж байгаа шүү дээ. Хэрвээ энийг зөв болгох юм бол бараг 10 орчим тэрбум долларын ийм ашиг Монгол Улсад орох нь гээд хүмүүс яриад байгаа. Үнэн эсэхийг нь мэдэхгүй. Гагцхүү бид нар шалгаж мухарлах ёстой. Шаардлага.../минут дуусав/

**Б.Пүрэвдорж:** Оюун-Эрдэнэ гишүүн хариулъя.

**Л.Оюун-Эрдэнэ:** Би бас таныг орж ирэхээс өмнө ярьж байсан юм. Тэр хүрээтэй холбоотой асуудал дээр энэ Харбины гэрээг шалгахыг дэмжиж байгаа. Эдийн засгийн байнгын хороон дээр би байр сууриа илэрхийлсэн. Тэрийг нягтлах нь бол зүйтэй. Харбинтай холбоотой асуудлыг бас ярьж байгаа учраас Харбины энэ Гашуунсухайт-Ганцмодтой холбоотой түүхийг та бас сайн судалбал, танай намын 2 Ерөнхийлөгчтэй их холбоотой ийм асуудал болж хувирдаг шүү. Энэ нь өөрөө юу вэ гэхээр 2014 онд Элбэгдорж Ерөнхийлөгчийн үед гэрээ хийчихсэн. Дараа нь Баттулга Ерөнхийлөгч нөгөө нарийн царигаа өргөн цариг болгочихсон. Ингээд энэ маргаан нь явж байгаад Хятадын талд 10 жилийн хугацааны ийм алдагдсан боломжийн өртөг үүсчихсэн. Энийг мухар төмөр зам тавьчихсан, яаж холбох вэ гэдэг л ийм асуудал байсан. Тэгээд тухайн үед ярьж байсан тэр нөхцөлөөсөө битгий дордуулаач ээ. Тавантолгойтой холбоотой асуудлыг лицензийг нь олгохоор гэрээ хийчихсэн байсан. Тэрийг больё. Тэгээд 2 улсын Засгийн газар Эм Си Эс гэдэг компани байхгүйгээр хоорондоо хийчихье гэдэг ийм л гэрээ болсон. Тэгээд Туваан сайд, Алтангэрэл сайд тухайн үед бүгдээрээ л хамтдаа ажилласан. Тэгэхээр энийг бол нягтлаад, шалгах бол бүрэн боломжтой.

Дээрээс нь нууц бол биш ээ. Энэ зүгээр нөгөө талдаа мэдэгдээд Их Хурлын гишүүд шууд танилцах ийм боломжтой гэрээ шүү гэдгийг та бүхэндээ бас хэлъе. Гэхдээ Харбины асуудлыг гаргаж ирж бас Ухаа худгийн асуудлыг хойшлуулах гээд хэрэггүй байх. Эхлээд биш ээ, энэ чинь Засгийн газар ажиллаж байх үе гэхээр энэ чинь бараг 1 жилийн хувьд байхгүй юу. Тэгэхээр та хэд адаглаад бас ийм товхимлоо цуглуулаад, материалаа жоохон бэлдчих нь бас зүйтэй болов уу гэж бодож байна. 7 сараас авхуулаад бид нар ярьж эхэлсэн. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Жудагийн Баярмаа гишүүн нэмж тодруулъя.

**Ж.Баярмаа:** 7 сараас эхэлсэн байсан юм уу. Тэгээд яагаад та яг таны үед байгуулагдсан Харбины гэрээг буюу маш их алдагдалтай байж болзошгүй тэр гэрээг байгуулсан гэрээг чинь шалгая гээд гарын үсэг зуруулж байх агшинд гялс амжуулж өгсөн юм бэ гэдэг асуулт байгаад байгаа юм.

2-т өнөөдөр нүүрсний үнэ хэд байгаа юм бол биржээр. Тэгээд яагаад биржийн үнээр авъя гэдэг ийм асуудлыг хүлээн зөвшөөрсөн байхад, яах вэ, 5 хувийн хөнгөлөлт үзүүлээч ээ гэж хүссэн байна лээ шүү дээ. Энэ сошиалаар дүүрэн явж байна лээ шүү дээ. Тэр Амарбаясгалан спикерийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байхад нь 2024 оны 2 сард Ганбат гээд БЭТ-ийн бичсэн тайлан, танилцуулга байна лээ л дээ. Яагаад өнөөдөр 120 доллароор зарагдаж байгаа энэ нүүрс маань 50 доллар болчихсон юм бэ гэдгийг яаралтай шалгаж, энэ Монголын эрх ашгийн төлөө .../минут дуусав/

**Б.Пүрэвдорж:** Оюун-Эрдэнэ гишүүн хариулъя.

**Л.Оюун-Эрдэнэ:** Би бас энэ Засгийн газрынханд хэлж байгаа. Тэгээд танд ч бас хэлье. Нягтлаад Засгийн газар Их Хурал руу оруулж ирээд, цуцлахад боломжтой. Тэгээд илүү нэмэх боломж байвал шууд цуцалчхаж болно шүү дээ. Таныг бол би бас ийм эдийн засгийн томоохон төслүүдийг хөдөлгөхийн төлөө байдаг, энэ улс төржиж гацсан энэ олон асуудлууд илүү шийдлээ олоосой гэж боддог гэдэг ийм өнцгөөс би бас хардаг байсан юм. Бараг 20 жил гацсан энэ төслөө буцаагаад гацаа гэж байгаа юм бол тэгье л дээ. Би тэрийг хамгаалаад байгаа юм юу ч байхгүй шүү. Болохгүй бол тэгээд л ирэх 7 хоногт оруулж ирээд л цуцалчихгүй юу. Нууц биш ээ. Зүгээр шууд нөгөө талдаа мэдэгдээд л оруулчихна. Туваан сайд урд чинь сууж байна. Асуу. .../минут дуусав/

**Б.Пүрэвдорж:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ирцээ сайжруулъя Батжаргал дарга аа. Ирцээ сайжруулъя Тэмүүжин гишүүн ээ. Үүдэнд сууж байгаа хүмүүс наашаа ороорой. Санал хураалт явах гэж байна. Ирц сайжиртал Тэмүүжин гишүүн үг хэлнэ.

**Х.Тэмүүжин:** Өнөөдрийн мэндийг гишүүддээ хүргэе. Ер нь бол парламентын ардчилал бүхий улс орнуудад 2 зарчим байгаа. Олонх шийдвэр гаргана. Цөөнх хяналт тавина гэж. Цөөнх хяналт тавина гэдгийн хамгийн гол агуулга юу вэ гэхээр олонх шийдвэрээ гаргахдаа тал бүрийн санал, бодлыг сонсож байж шийдвэрээ илүү алдаа мадаггүй гаргаасай гэдэг үүднээс парламентын дотоод ардчилал ажилладаг. Парламентын хяналтын түр хороо гэдэг энэ Үндсэн хуулийн шинэ механизм бол цөөнхөд, асуудал дээр цөөнх болсон гишүүдэд хяналт хэрэгжүүлэх боломж олгох гэж байгуулагдсан механизм. Анх энэ байгуулагдсан механизмыг буруу ашигласан учраас одоо бид маш үл ойлгогдох байдалд орж байгаа.

Дахиад нэг зарчим. Парламентын хяналтын механизмыг Засгийн газар хэрэгжүүлж, эсвэл хэрэгжүүлэхийг эсрэг зогсож болохгүй гэдэг зарчим байгаа. Та бүхэн Улсын Их Хуралд хэт олонх болсон байх үедээ парламентын энэ хяналтыг Хууль зүйн сайдаараа ахлуулж байгаад сонсгол хийсэн. Парламентын сонсгол юм уу, Засгийн газрын сонсгол юм уу гэдэг нь ойлгогдохгүй болтол жонхууруулсан. Өнөөдөр хар. Парламентын хяналт яаж ажиллах вэ гэсэн чинь Засгийн газрын 1 ч гишүүн байхгүй болчихсон. 1 бол парламентын хяналтыг Засгийн газар гүйж орж ирж өмнүүр нь хийх гэж оролдоод байдаг. Эсвэл парламентын хяналтыг Засгийн газар нь хэрэгжүүлэхгүй, хийлгэхгүй гээд гацаагаад байдаг маш буруу соёл одоо

явж байна. Парламентын энэ хяналтын түр хороог цөөнх гарын үсгээ зураад, байгуулах гэж байхад олонх нь байгуулахгүй гээд санал хураалтаар унагах юм бол парламент цаашдаа хяналт хэрэгжүүлэх чадамжгүй болно гэсэн үг. Парламентат ёс байхгүй болно гэсэн үг. Парламентын хамгийн гол агуулга ямар нэгэн тусгайлсан тодорхой олон нийтийг хямраасан ийм сэдэв дээр парламентын гишүүдийн тодорхой хэсэг нь гарын үсэг зурсан бол тэр түр хороог парламент байгуулаад ажиллуулах ёстой. Гэтэл одоо хар. Бид өнөөдөр энэ түр хороо байгуулахгүй гээд унагах юм бол дараа нь Ардчилсан намын 42 гишүүн гарын үсэг зурсан ч гэсэн өнөөдөр намын даргаасаа болоод хэрэлдсэн байгаа энэ 2 тал нэгдээд зогсоход, цаашид Ардчилсан нам 1 ч Түр хороо байгуулахгүй хэмжээнд ирнэ. Ийм дампуу соёлыг, ийм гажуу үйлдлийг бид бол дэмжиж ерөөсөө болохгүй.

Парламентын гишүүд гарын үсгээ зураад, энэ асуудал дээр түр хороо байгуулна гээд Улсын Их Хуралд өргөн барьсан л бол Улсын Их Хурал тэрийг нь байгуулж өгөх ёстой шүү. Бид boomerang шийдэж болохгүй. Буцаж ирдэг. Өнөөдөр ийм галзуурлыг, улс төрийн галзуурлыг намын даргаасаа болоод эрх баригчид нь эрх баригчид биш болчихсон байгаа энэ галзуурал дээр дөрөөлөөд парламентын хамгийн дэвшилттэй шинэчлэл болсон хяналт шалгалтын түр хороо байгуулах энэ механизмыг гацаадаг, үгүйсгэдэг, гишүүд гарын үсэг зурсан ч гэсэн байгуулахгүй байж болдог гэдэг ийм жишиг рүү явах юм бол дараа ард үлдэж байгаа 4 чуулган дээр Ардчилсан нам 1 ч түр хороо байгуулахгүй хэмжээнд ирнэ шүү. Энийгээ бид бодох ёстой. Цөөнх нь цөөнх шиг, олонх нь олонх шиг байж чадахгүй энэ галзуурлаараа Монгол Улсын парламентыг битгий дампууруулчихаарай.

Танай намын дарга хэн байх бол танай намын асуудал. Монгол Улс парламенттай байх гэдэг бол Монгол Улсын парламент Засгийн газраа хянаж чадах ёстой гэдэг бол энэ Үндсэн хуулийн байгууллын суурь зарчим шүү. Үндсэн хуулийн суурь дэг журам шүү. Би энийг л хэлмээр байна. Олон өдөр бараг сар гаруй харлаа. Ардын намын 3 хурал, Удирдах зөвлөл, Бага хурал, Их хурал энэ 3 хурлын дунд Засгийн газар ч үгүй боллоо. Парламент ч үгүй боллоо. Танай олонхын бүлэг ч үгүй боллоо. Намын дарга ч .../минут дуусав/

**Б.Пүрэвдорж:** Ирцэд нэлээн хэдэн гишүүд ороод ирлээ. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Санал хураалттай бэлтгэе.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт Цуцлаадахъя. Энэ томъёоллоо уншаагүй явчихсан байна шүү.

Санал хураалт 1. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураана. Би түрүүн томъёолол уншаагүй учраас хүчингүй гээд хэлчихсэн шүү. Санал хураалтыг явуулъя. Энийг хүчингүй болгочихъё. Би түрүүн санал хураалтын томъёолол уншилгүйгээр санал хураалт явсан учраас тэрийгээ цуцалж байна. Энэ дээр горимын санал гаргах шаардлага байхгүй. Тэгэхээр дахиад би уншихъя. Томъёолол уншаагүй учраас.

1 дүгээрт “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураая. 92 гишүүнээс хэд болчхов. 46 гишүүн дэмжиж, 50 хувиар санал дэмжигдсэнгүй.

Алтангэрэл горимын санал гаргая.

**О.Алтангэрэл:** Горимын санал гаргаж байна. Энэ төхөөрөмж гацсан байна. Жишээлбэл Оюунсайханы Алтангэрэл гээд татгалзсан дээр гарсан байна. Энд 3 удаа санал хураахад би гурвууланд нь дэмжсэнээр өгсөн. Дандаа татгалзсанаар гарсан. Энэ яаж байгаа юм. Яагаад. Эсвэл бүр сүүлдээ юугаа дийлэхгүй болохоор программ хангамжаар хийж байгаа юм уу. Тэнд Баасанжаргал гишүүн дэмжсэнийг өгөхөд энд татгалзсан гэж гарсан байна. Дэмжсэн хүмүүсийг татгалзсан болгосон байна. Одоо сүүлдээ энэ компьютероор янзалж байгаа юм уу энэ хүмүүсийн саналыг. Санал хураалтыг хүчингүй болгох санал гаргаж байна.

**Б.Пүрэвдорж:** Алтангэрэл гишүүн ээ, та өөрөө дэмжсэн байна. Саяын санал дээр. Алтангэрэл гишүүн ээ, та хамгийн сүүлийн 50 хувийн санал хураалт дээр дэмжиж санал өгсөн байна. Баасанжаргал гишүүн та дэмжиж санал өгсөн байна. Үгүй ээ. Тэрний түрүүчийнх дээр нь бүр уначихсан байсныг нь илүү сайн болголоо шүү дээ. Сайнзориг гишүүн бас дэмжсэн гарсан байна шүү дээ. Пүрэвдорж гишүүн дэмжсэн байна. Дахиж гарсан нь тийм байна уу дарга аа. Өөрөө түрүүн ярьчихсан юм. Уу. Сайнзориг гишүүн дэмжсэн байна уу. Пүрэвдорж гишүүн дэмжсэн байна айн Ингэе энэ чинь энд үгүй ээ үгүй энэ та хүрээд ир л дээ. Энд ирээд уншиж үзчих л дээ. Энэ дотор эсрэг санал өгсөн хүмүүс маш цөөхөн байна. Санал гаргах эсрэг санал өгсөн хүн энэ танхим дотор байхгүй байгаад байна л даа. Тэгэхээр Батжаргал гишүүн горимын санал.

**Ж.Батжаргал:** Хурал даргалагчаа энэ Их Хурлын санал хураалтын тоног төхөөрөмжүүд чинь техникийн сааталтай байна гээд олон гишүүд яриад байна. Тийм учраас техникийн саатлаа арилгая. Тийм учраас манай намын бүлэг яг саяын асуудлаар тодорхой хугацаанд завсарлага авч байна. Ийм санал оруулж байна. Хугацаагаа хэлчих Батжаргал гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Дэгийн тухай хуулийнхаа дагуу 5 хоногийн завсраар авъя. Тэгэхээр Батжаргал гишүүн ээ, энэ чинь юу юм байна. Одоо ингээд саяын санал хураалтаар дуусчихаар бүр хэлэлцүүлэг дуусчих гээд байна. Тэгэхээр эсрэг санал өгсөн 1 хүнээр горимын санал гаргуулмаар байна л даа. Нөгөө гүйлгэж гардаг юу нь дахиж явдаггүй юм байна. Харин зургийг нь аваад тавьчих юм байна.

Одоо энэ танхимд чинь эсрэг санал өгсөн хүн бараг байхгүй байна. Горимын санал гаргах хүн байхгүй байна. Техник гацсан шүү дээ. Би хэлээд байна шүү дээ. Энэ чинь 2 хуваагдчихаад 1 хэсэг хүмүүс нь огт эсрэг санал өгөөд байна шүү дээ. Би тэгээд яах юм Ардын намынхан. Би тэгээд эд нарыг чинь урьж авчрах юм уу. Та нар байдгаараа л дэмжиж санал өглөө шүү дээ. Ингэж болж байна.

Манай Их хурлын тухай хуулиар дэг сахиулах үүрэг бүхий хүн Ерөнхий нарийн бичгийн дарга байна гэсэн байгаа. Тэгээд Ерөнхий нарийн бичгийн дарга тодорхой тайлбар хийе. Аль эсвэл Дондогмаа дарга хийх үү. Дондогмаа дарга тайлбар хийчих. Индрийн 1 дүгээр микрофон.

**Ч.Дондогмаа:** Дэгийн хуулийн завсарлага авахтай холбоотой зохицуулалтыг уншиж танилцуулъя. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар нам, эвслийн бүлэг завсарлага авах эрхтэй. Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.15-д заасны дагуу завсарлага авах эрхтэй. Завсарлага авах хугацаа ажлын 5-аас илүүгүй өдөр байх шаардлагатай гээд 30.1.15-д болохоор нам, эвслийн бүлэг хэлэлцэж байгаа асуудлаар завсарлага авах эрхтэй гэж заасан байгаа. Тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авах эрхтэй.

Яг хуралдаан удирдах дараалалд зааснаараа бол санал хураалт явагдсан байгаа. Хуралдаан даргалагч санал хураалтын дүнг танилцуулсан. Тогтоолын төслийг баталсан юм уу, дараагийн процессыг эхлээгүй байгаа. Эсвэл батлагдаагүй ч юм уу алх цохисон шийдвэр одоогоор гараагүй байгаа гэсэн үг. Тэгэхээр бүлэг яг тухайн хэлэлцэж байгаа асуудалтай буюу завсарлан авах боломжтой.

**Б.Пүрэвдорж:** Пүрэвдаваа гишүүн горимын санал гаргая.

**Д.Пүрэвдаваа:** Өдрийн мэнд хүргэе. Горимын санал гаргах саналтай байна. Санал хураалтад оролцож амжсангүй. Яг орж ирэх хугацаанд санал хураалт болоод өнгөрчихлөө. Тийм учраас хүчингүй болгож өгнө үү Дахин санал хураалгах нөхцөлөөр хангаж өгнө үү гэж хүсье.

**Б.Пүрэвдорж:** Пүрэвдаваа гишүүн горимын санал гаргалаа.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 13.1.9-ийн есөд заасны дагуу илтгэл, танилцуулга сонсох, асуулт, хариулт явуулах, санал, дүгнэлт танилцуулах, санал хураах цагийг хуралдаан даргалагчид тогтоох ийм заалттай. Тийм учраас ирэх 7 хоногийн чуулганы эхний асуудлаар санал хураалт явуулна. Энэ асуудлыг хойшлууллаа.

12.04 цаг.

Хэлэлцэх асуудал 3.

**Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Монгол Улсын Засгийн газар 2025 оны 9 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/**

Төслийн 3 дахь хэлэлцүүлгийн талаар явуулж эхэлье. Төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэгдсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзориг танилцуулна. Индэрт урьж байна.

Энэ хэлэлцэх асуудалтай холбогдуулан Монгол Ардын намын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал үг хэлнэ.

**Ж.Батжаргал:** Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал дээр нягтлах, бас эргэн хэлэлцэх асуудлууд байна гэж ингэж үзэж байгаа.

1 дүгээрт. Хөрөнгө оруулалтын жагсаалтын 2 дугаар хавсралт, мөн тодорхой дурдагдаж орсон 179 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын жагсаалт, дэг зөрчиж санал хураалт явагдсан байх асуудлууд дээр Дэгийн тухай хуулийнхаа 71.14 дэх заалтын дагуу Төсвийн байнгын хороонд чиглэг өгч буцаах нь зүйтэй гэсэн ийм байдлаар би санал оруулж байна. Үүнийг хэлэлцүүлж дэмжиж өгөөч гэж чиглэл авъя.

**Б.Пүрэвдорж:** Чуулганаас чиглэл авах зохицуулалтыг бас танилцуулж хэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14 дэх хэсэг “нэгдсэн хуралдаанаас төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзвэл Төсвийн байнгын хороонд чиглэл өгч буцааж болно. Чиглэл өгсөн тодорхой асуудлаас бусад асуудлыг хөндөхийг хориглоно.” гэсэн ийм заалттай. Энэ асуудлаар ажлын хэсгийн дарга Хассуурийн Ганхуяг үг хэлнэ.

**Х.Ганхуяг:** Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14-д зааснаар “нэгдсэн хуралдаанаас төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзвэл Төсвийн байнгын хороонд чиглэл өгч буцааж болно.” гэж заасан байдаг. Тэгээд үүнд зааснаар бид нар 6 асуудал дээр чиглэл авмаар байгаа.

1 дүгээр асуудал бол ажлын хэсгийн саналын хавсралтын 2-т тусгагдсан бүсчилсэн хөгжилтэй холбоотой сэдэв;

2-т нь Төсвийн байнгын хорооны нэр бүхий гишүүнээс гаргасан Засгийн газрын нөөц сангаас тодорхой дүнгээр бууруулж, зохицуулалт хийх санал дээр;

3.Ажлын хэсгийн төсвийн тэнцэлд нөлөөлөхгүй зохицуулалтын 16 дугаар саналын ШУА-ийн хүрээлэнгүүдийн лабораторийн багаж, тоног төхөөрөмж гэсэн төсөл арга хэмжээн дээр;

4.Байнгын хорооны саналыг санал хураалт явуулах үед Өргөдлийн байнгын хорооны саналын Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2026 оны хэрэгжүүлэх хөтөлбөрийн саналаас эхлэн бусад Байнгын хорооны болон Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны саналууд дээр;

5.Ажлын хэсгийн саналын томьёоллын хавсралт 2 буюу Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт нэмэгдүүлэх саналууд буюу Ардчилсан намын гэж яригдаад байгаа 179 тэрбум дээр;

6.ШУТС-ийн зардал нийт хувьчилж бууруулах зардалд хамрагдсан байгаа асуудлаар гээд 6 чиглэлээр авмаар байна дарга аа.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр яг энэ бичиг над дээр ирсэн байгаа. Хассуурийн Ганхуяг ажлын хэсгийн даргын гаргасан 6 ажлын хүрээнд чиглэл өгөх тухай асуудлыг бүлгийн дарга зөвшөөрч байна уу. Зөвшөөрлөө гэж ойлгоё.

Тэгэхээр би 5 дугаар зүйл дээр 1 зүйлийг хэлье гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл Ардчилсан намын нийтдээ 42 Их Хурлын гишүүн нийтдээ 179 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг тавих саналыг тойргууддаа тавих саналыг гаргасан байгаа. Тэгэхээр энэ жилийн хувьд бол нийтдээ 3,2 их наяд төгрөгийн төсвийн шууд хөрөнгө оруулалтаар 1,9 их наяд төгрөгийн зээл тусламжаар санхүүжүүлж хөрөнгө оруулалтыг санхүүжүүлж байгаа. Нийтдээ 5,1 их наяд болж байгаа. Энэ 5,1 их наядаас 179 гэдэг бол 3,6 хувь л байгаа.

Гэтэл Ардчилсан намын бүлгийн гишүүд бол нийт Их Хурлын гишүүдийн 42 буюу 1/3 нь байгаа. Энэ нь бол 33 хувийг эзэлдэг. Тэгсэн мөртөө 3.6 хувийн хөрөнгө оруулалтыг тавихад Монгол Ардын намын бүлгийн гишүүд маш их эсэргүүцэж байгаа. Тэгэхээр ер нь бол би та нарт 1 тоо бас дахиад хэлээд өгчихье.

Өөрөөр хэлбэл танай намын дарга байсан хүний 2024 онд 1 их наяд 180 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, 2025 онд 1 их наяд 67 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөвт өртөгтэй. Ирэх жилийн хувьд 771 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай ийм ажлууд зөвхөн Хэнтий аймагт хийгдэж байгаа. Намын дарга, Ерөнхий сайд байх үедээ энэ хөрөнгө оруулалтыг тавьсан. Энэ хөрөнгө оруулалтыг ирэх жил санхүүжих төсөв нь болохоор нийтдээ 282 тэрбум төгрөг байна. Ганцхан хүний тавьж байгаа энэ хөрөнгө оруулалт Их Хурлын Ардчилсан намын бүлгийн 42-оос даруй 100 тэрбумаар илүү байгаад байна шүү дээ. Хууль баталдаг, дээрээс нь хөдөө, орон нутгаас энэ ард иргэдийн саналыг авч, тэдний сайн сайхны төлөө ажил хийж, энэ төсвийн хөрөнгө оруулалтыг хуваарилах бас томоохон үүрэгтэй Ардчилсан намынхныг заавал тэр 179-өөс нь хасна гэдэг ийм санал орж ирж байгаа нь би бас зарчмын хувьд болохгүй байна гэж үзэж байгаа.

Тэгэхдээ ажлын хэсэг дээр, Байнгын хороо дээр та нар олонх. Хасвал тэр биз. Ардчилсан намын бүлгийг хариуцсан дэд даргын хувьд энэ хүмүүсээсээ сонгогдсон дэд даргын хувьд бол би Ардчилсан намын гишүүдийн ийм өчүүхэн хөрөнгө оруулалтыг хасаж байгааг би бас эсэргүүцэж үг хэлье гэж бодлоо. Баярлалаа.

Чиглэл авах нь санал хураалтаар юм байна. Дэг нь тийм байх шиг байна. Тийм учраас гишүүдийн ирцийг сайжруулъя. Энэ завсарлагааны үеэр асуудлаа яриад, өнөөдөр нийтдээ 160-аад санал хураалттай. Тийм учраас 15-ны дотор улсын төсвөө батлахгүй бол Их Хурал төсвөө баталж чадахгүй чадамжгүй гэж үзэж, Их Хурал тарах ийм нөхцөл байдал руу орно. Хэрвээ Их Хурал тарах юм бол 1 сарын 20 үеэр сонгууль явна шүү дээ. Ирцээ сайжруулъя.

Энэ Засгийн газрын төсвийн чиглэл өгч буцаахад заавал бас санал хураалт явах ёстой юм байна. Чиглэл өгөх тохиолдолд заавал санал хураах ёстой юм байна. Тийм учраас ирцээ маш хурдан сайжруулаад, үдийн цайны завсарлагаар ажлын хэсэг хуралдаад, асуудлаа шийдчихье. Засгийн газрын сайд нар орж ирээрэй. Санал хураалтад бэлтгэе. Ингээд саяын Хассуурийн Ганхуяг гишүүний гаргасан болон Жигжидийн Батжаргал Монгол Ардын намын бүлгийн даргын гаргасан саналын дагуу 6 асуудлаар, бусад асуудлыг хөндөхийг хориглож байгаа. Энэ асуудлаар чиглэл өгч байна. Гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Баярлалаа. Байнгын хороонд чиглэл өгч байна. Ганхуяг гишүүн үг хэлье.

**Х.Ганхуяг:** Дарга аа, нөгөө санал хураалт явуулахгүй бол энэ саяын таны хаасан юу чинь ерөнхийдөө бол хүчин төгөлдөр бус болчихоод байна л даа. Заавал ч үгүй санал хураалттай юм билээ. Дэгээрээ яг энэ чинь бүр хуульдаа заачихсан байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14-т заачихсан байгаа. Заавал санал хураалт хийгдэнэ. Тэгж байж буцна гэсэн үг. Тийм чиглэл өгөх.

**Б.Пүрэвдорж:** Үдээс өмнөх чуулганы хуралдааныг завсарлууллаа.

12.20 цаг.

ЗАВСАРЛАГА.

**Б.Пүрэвдорж:** Үдээс хойших чуулганы хуралдааны цаг эхэлсэн. Гэвч харамсалтай нь санал хураалтаар явах ёстой. Гишүүдийг танхимдаа урьж байна. 2 бүлэг ирцээ сайжруулаарай. Шууд саналаар хураалтаар явагдана.

Үдээс хойших чуулганы хуралдааныг эхлүүлэе. Төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Индэрт урьж байна. Уучлаарай Пүрэвжавын Ганзориг.

**П.Ганзориг:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр нэгдсэн хуралдаанаа хийж, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр бусад Байнгын хороод болон Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын бусад Байнгын хороод болон Төсвийн зарлагын хяналтын дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн төслийг хэлэлцээд санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасны дагуу баримтлан явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хорооны 2025 оны 22, 23 дугаар тогтоолоор Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуягаар ахлуулан Улсын Их Хурлын 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажилласан.

Дээрх ажлын хэсгээс боловсрол, эрүүл мэндийн салбарт үүсээд байгаа нөхцөл байдал, нийгмийн шаардлагыг харгалзан багш, эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнууд, төрийн өмчийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ажиллагсдын цалин, ахмад настны болон халамжийн тэтгэврийг инфляцын түвшинд уялдуулан нэмэгдүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд тусгагдсан урсгал зардалд дүн шинжилгээ хийж, төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлыг 6-12,8 хувиар бууруулах, зарим төслийн ерөнхийлөн захирагчдын урсгал

зардлыг 2025 оны түвшинд байлгах тэвчиж болох зардлыг хойшлуулах нь зүйтэй гэж үзсэн.

Мөн Улсын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй зарим хөрөнгө оруулалтын төслүүдийг хасах, 2026 онд дуусах хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг бууруулахгүй байх зарчмыг баримталсан бөгөөд дараа онуудад шилжих санхүүжих төслүүдийн санхүүжилтийг тодорхой хувиар бууруулах, зарим салбарын тоног төхөөрөмжийн зардлыг 50 хувиар бууруулах, Нэгдсэн Үндэсний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой барилга байгууламжийн санхүүжих дүнг бууруулахаар тус тус тооцлоо.

Байнгын хорооны хуралдаанаар асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяагийн гаргасан төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэвэр гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламж болох 36 хүртэлх сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийн зардлыг төсөлд бүрэн тусгах гэсэн саналын хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бөгөөд уг саналд Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг цөөнх болсон.

Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.9 дэх хэсэгт заасны дагуу ажлын хэсэг бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулан олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол, төсвийн төслийн 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн санал, дүгнэлтийг уншихгүй юм байна. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлт байхгүй байна.

Ажлын хэсгийн гишүүдийн нэрийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Эдийн засаг, хөгжлийн сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ланганы Отгонтуяа, Амаржаргалын Энхбат нар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Занданбазарын Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Буяндэлгэрийн Баттуяа Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний Аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн

яамны Төрийн нарийн бичгийн дарга, Цэрэндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Төмрийн баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Батболдын Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаа, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Баяраагийн Урьболд Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Жаргалсайханы Гэрэлбат Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Сангидоржийн Баярмаа Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газрын дарга. Ажлын хэсгийг оруулаарай.

Төсвийн байнгын хорооноос нэгтгэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж эхэлнэ. Санал хурааж эхлэхээс өмнө үдээс өмнөх чуулганы хуралдаанаар төсвийн ажлын хэсгийн дарга Хассуурийн Ганхуягаас 6 асуудлаар гүйцээн боловсруулах санал хураалтыг явуулж, Төсвийн байнгын хорооны хороонд гурав дугаар хэлэлцүүлгийг явуулж өгөөч гэдэг ийм хүсэлт гаргасан.

Нэгдүгээрх нь бол ажлын хэсгийн саналын хавсралт 2-т тусгагдсан бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ, бүсүүдэд гэсэн төсөл, арга хэмжээний талаар энийг бүтээн байгуулалтын ажлыг задалж, нэрээр нь тавих ажлыг хийх ёстой юм байна.

Хоёрт нь Төсвийн байнгын хорооны нэр бүхий гишүүнээс гаргасан Засгийн газрын нөөц сангаас тодорхой дүнгээр бууруулж, зохицуулалт хийх саналын талаар Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы гаргасан саналыг ажлын хэсэг санал болгох,

Гуравдугаарх нь ажлын хэсгийн төсвийн тэнцэлд нөлөөлөхгүй зохицуулалтын 16 дугаар саналын Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдийн лабораторийн багаж, тоног төхөөрөмж Улаанбаатар Баянзүрх дүүрэг гэсэн төсөл, арга хэмжээний талаар Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл гаргаж дэмжигдсэн ажлын хэсгийн санал болж орсон. Энэ доор нь нэмж төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ улсын хэмжээнд гэж өөрчлөх юм байна.

Дөрөвдүгээрт нь бусад Байнгын хорооны саналыг санал хураалт явуулах үеийн Өргөдлийн байнгын хорооны саналын Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн талаарх саналаас эхлэн бусад Байнгын

хорооны болон Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны саналуудад хуралдаан даргалагч солигдсон учраас энэ асуудлаар дахин гүйцээн боловсруулах юм байна.

Тавд нь ажлын хэсгийн саналын томъёоллын хавсралт 2 буюу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт нэмэгдүүлэх саналуудад энэ арга хэмжээ Ардчилсан намын 42 гишүүний 179 тэрбум төгрөгөөр Монгол Улсын бүх аймаг, сумдад тавьж байгаа хөрөнгө оруулалтыг хасах Монгол Ардын намын санал орж ирж байгаа юм байна.

Зургаад нь Шинжлэх ухаан, технологийн сангийн зардал нийт хувьчилж бууруулах зардалд хамрагдсан байгаа асуудлаар гэсэн энэ 6 асуудлаар гүйцээн боловсруулах саналыг ажлын хэсгийн дарга Хассуурийн Ганхуяг гаргасан байгаа. Энэ саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14 дэх хэсэг “нэгдсэн хуралдаанаас төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзвэл Төсвийн байнгын хороонд чиглэл өгч буцааж болно. Чиглэл өгсөн тодорхой асуудлаас бусад асуудлыг хөндөхийг хориглоно.” гэсэн заалтын дагуу чиглэл өгөх асуудлаар санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад бэлтгээрэй. Учрал гишүүн суугаарай. Санал хураалтад бэлтгээрэй. 70 гаруй гишүүн энд сууж байна. 64 нь санал хураалтад бэлтгэж, хурууныхаа хээг уншуулсан байна. 6 асуудлаар Төсвийн байнгын хороонд чиглэл өгч буцаах асуудлаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 99 гишүүн оролцож, 59 гишүүн дэмжиж, хэдэн хувийн санал авсан бэ. 59,6 хувиар санал дэмжигдлээ.

Тэгэхээр өнөөдрийн чуулганы хуралдаан бол үргэлжлээд явна. Өөрөөр хэлбэл бусад санал хураалтаа явуулж байгаад чуулганы хуралдаанаа завсарлуулж энэ чиглэл өгсөн асуудлаараа Төсвийн байнгын хуралдаж, чиглэлийн асуудлаар тодорхой саналуудыг гаргаж ирүүлнэ. Одоо шууд санал хураалт явна шүү дээ. Шууд явна. Та хэд сууж байгаарай. Та эрхээ эдэлж болно. Тийм учраас энэ дээр үг хэлэх тухай асуудал байхгүй. Баасанжаргал гишүүнийг ирцээс хасъя. Болормаа гишүүнийг ирцээс хасъя.

Эхний ээлжид Тамгын газар дэмжсэн саналуудыг ирүүлж бай. Эхнээсээ дэмжсэн саналаар санал хураалт явуулна шүү дээ. Дараа нь дэмжээгүй саналаар хураана. Баасанжаргал гишүүнд үг өгье.

**Х.Баасанжаргал:** Хуралдааны ирцээс гарах хүсэлтэй байгаа. Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 7.5-д Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн асуудлаар хэлэлцэх гэж байгаа буюу энэ танхимд өчигдөр, уржигдар хуралдсан Төсвийн байнгын хорооны хуралдаан өөрөө үндсэндээ Үндсэн хуулиа зөрчсөн. Ганхуяг гишүүний өмнөөс Аубакир гишүүн санал өгсөн. 1 дүгээрт. Дэгийн тухай хуульд заасан зөрчлийг 2 гишүүн хоёулаа гаргасан.

2 дугаарт Аубакир гишүүн өөрөө сайд атлаа дахиад Байнгын хорооны хуралдааныг даргалсан. Төсвийн байнгын хорооны хуралдааныг даргалсан ийм 2 ноцтой зөрчил гаргасан асуудлаар санал хураалт явуулсан Төсвийн байнгын хорооны хуралдааныг үргэлжлүүлэх гэж байгаа учраас би албан ёсоор ирцээс гарч байгаа. 1 дүгээр үндэслэл. Энийг би зориуд хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх

гэж би микрофон дээр арайхийж үг авлаа. Энийг бас хуралдааны тэмдэглэлд зориуд тэмдэглэж үлдээе.

2 дугаарт одоо бид нар 6 чиглэлээр гээд бусад үлдсэн саналыг хурааа гэх юм бол энэ 6 чиглэлд аль нь ороод, аль нь ороогүй гэдэг нь огт гишүүдэд мэдэгдэхгүй. Одоо болтол гишүүдэд зарчмын зөрүүтэй саналыг огт өгөөгүй байгаа. Зарчмын зөрүүтэй саналаа гар дээрээ авсан гишүүн 1 ч байхгүй. Энэнээс аль нь саяын 6 чиглэлд хамаарах, аль нь хамаарахгүй гэдэг нь огт мэдэгдэхгүй байгаа. Ийм асуудлаар гишүүдийг зориуд санал хураалтад түлхэж, санал хураалт өгөхөөс өөр аргагүй байдалд орж байгаа учраас би албан ёсоор ирцээс гарч байна. Бусад гишүүдийг ч гэсэн ирцээс гарахыг уриалж байна.

**Б.Пүрэвдорж:** Тойрогтоо гишүүд ирцээс их гарах юм бол хохирно шүү гэдгийг хэлье. Баасанжаргал гишүүнийг ирцээс хасъя. Би шууд нэрийг нь уншаад явчихъя. Ирцээс гарах Уянга, Сандаг-Очир, Энхцэцэг, Болормаа нарыг ирцээс хасъя.

Ер нь бол яг энэ суудал дээр сууснаас хойш бол яг энэ зарчмын зөрүүтэй санал Төсвийн байнгын хороо дээр болон бусад Байнгын хороо дээр хэлэлцэгдсэн бүх саналууд бүгдээрээ хэвлэгдэж, гишүүдийн гар дээр очсон байх ёстой. Гэтэл очоогүй байна. Удахгүй ирэх юм байна. Ийм байдлаар Тамгын газрын үйл ажиллагаа явж байгаа. Би бол бушуухан шиг Булгантуяаг ирж удирдаасай. Ер нь албан ёсны даргын үүрэг гүйцэтгэж байгаа шүү дээ. Ирээд удирдаач ээ. Тэгвэл илүү энэ Тамгын газрынхан үйлчлэх юм шиг байна. Тийм учраас намайг энд байгаа учраас энд тийм гацаасан байдалтай, Улсын Их Хурлын үйл ажиллагааг жоохон удаашруулсан байдалтай явж байна. Тийм учраас Тамгын газрынхныг ажлаа хийхийг шаардаж байна. Үг байхгүй.

Өнгөрсөн жил яг төсвийн гуравдугаар хэлэлцүүлэг явж байх үед болсон протоколыг би уншиж танилцуулъя.

Өөрөөр хэлбэл 71.14 дэх заалт бол хэдийгээр 9-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан ч гэсэн яг энэ агуулгаараа урьд нь байсан заалт юм байна. Амарбаясгалан дарга, тэгэхээр энэ асуудлыг гүйцээн боловсруулах, өөрөөр хэлбэл өнгөрсөн жилийн шүүхийн асуудлыг Цогтбаатар даргын саналаар бас тухайн үед буцааж байсан. Тэгээд энэ асуудлаар гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тохиолдолд эх үүсвэртэй холбоотой асуудал давхар хөндөнө гэдгийг бас энэ протоколд тэмдэглэж хэлүүлье. Хууль зүйн байнгын хороо хуралдана. Төсвийн байнгын хороо хуралдана. Тэгээд тэр зардлынхаа эх үүсвэрийг дахиж ярилцъя гэсэн үг шүү. Тэгэхээр Дэгийн тухай хуулийн 71.14 дэх заалтаар уг асуудлыг Байнгын хороонд чиглэл өгч буцааа гэснийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя гээд 66,7 хувиар дэгийн тухай хуулийн 71.14 дэх заалт дэмжигдлээ. Тэгэхээр уг асуудал Байнгын хороодод буцаагдлаа. Эцсийн хэлэлцүүлэг дээр дахин боловсруулж орж ирэх нь. Эх үүсвэртэй холбоотой асуудал дээр Засгийн газар энэ дээр анхаарах хэрэгтэй. Ер нь Засгийн газрын зүгээс дараа дараа жилийн улсын төсөв дээр гүйцэтгэх засаглалтай холбоотой төсвийг энэ мэдээж хэрэг улсын төсвийнхөө нөхцөл боломж бүх зүйлийг харгалзан үзэж, хуулийн хэрэгжилтийг хангаж орж явах шаардлагатай гэдгийг дашрамд хэлье гээд, дараагийнхаа нөгөө дэмжигдсэн саналуудаа шууд хураалгаад явсан байна.

Одоо тэгээд та үг хэлэхийн тулд урьд өдөр нь 17 цагаас өмнө албан бичгээр бүлгийн даргаараа дамжуулж үг хэлэх ёстой.

Тэгэхээр сая 6 асуудлаар үдээс өмнөх хуралдаан дээр Хассуурийн Ганхуяг ажлын хэсгийн ахлагч яг тодорхой хэлж, би үдээс хойших хуралдаан дээр ерөнхий агуулгыг нь хэлж ярьсан байгаа. Тэгэхээр одоо санал хураалт явж байх үед яг энэ нөгөө чиглэл авах асуудлуудыг бүгдийг нь хэлээд өгнө. Тэрийг нь та нар чиглэл авч байгаа асуудал гэж ойлгоорой.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн зөрчлийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

### **Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал**

Ажлын хэсгийн санал. Энэ санал бол тэр чигээрээ чиглэл өгч байгаа санал байгаа шүү. Тэгээд чиглэл өгөгдөж байгаа учраас би унших ёстой юу. Энийг эхлээд уншаадахъя.

**1.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн Ерөнхийлөгчийн захирагч нарын төсвийн багцад тусгагдсан урсгал болон хөрөнгө оруулалтын зардал зохицуулах зохицуулалт хийх санал**

#### **1.1 Зардал бууруулах санал:**

##### **Урсгал зардал бууруулах**

- Төрийн албан хаагчдын цалин хөлс, Хүүхдийн мөнгөн тэтгэмж, Нийгмийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Боловсролын салбарын гүйцэтгэлийн санхүүжилт, улсын төсвөөс санхүүжих эрүүл мэнд, боловсролын байгууллагууд, гамшиг, ослоос хамгаалах, эрэн хайх, аврах ажиллагааны зардал, Засгийн газрын зээлийн үйлчилгээний хүүгийн зардал, гадаад зээл, тусламжаас санхүүжих урсгал зардал, 100 хувь өөрийн орлогоос санхүүжих зардлыг хөндөхгүйгээр аймгуудын урсгал зардлыг 6.0 хувиар, бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлыг 12.8 хувиар бууруулж, нийт 411,447.6 сая төгрөгөөр;

- Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “1,542,428.4” гэснийг “1,235,328.4” гэж холбогдох шийдвэрийн хамт өөрчлөн, гадаад зээллэгийн ашиглалтыг 307,100.0 сая төгрөгөөр;

- Улсын Их Хурлын гишүүдийн зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 88.9 сая төгрөгөөр;

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын “Эрчим хүчний экспортыг дэмжих нэгж”-ийн урсгал зардлыг 2,588.6 сая төгрөгөөр;

- Ойн газрын урсгал зардалд ойжуулалтын зардалд зориулж 44,161.7 сая төгрөг тусгагдсан тул Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны урсгал зардалд давхар тусгагдсан ойжуулалтын хөтөлбөрийн зардлыг 5,023.5 сая төгрөгөөр;

- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцын аялал жуулчлалын чиглэлийн хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасыг 8,000.0 сая төгрөгөөр;

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын “Шинэ хоршоо хөтөлбөр”-ийн 2026 оноос шинээр олгохоор тооцсон зээлийн хүүгийн татаасыг 22,000.0 сая төгрөгөөр;

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын Зээлийн батлан даалтын сангийн дүрмийн санг нэмэгдүүлэхэд тусгагдсан санхүүжилтийг 25,000.0 сая төгрөгөөр;

- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн санхүүжилтийг 10,000.0 сая төгрөгөөр;

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын төрийн албан хаагчийг мэргэшүүлэх зардалд зориулж Удирдлагын академид олгодог санхүүжилтийг 4,636.6 сая төгрөгөөр;

- 2026 оны төсвийн жилд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шадар сайд нарын ажлын алба болон бүх яамдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардал шинээр тусгагдсаныг хасаж, нийт 10,000.0 сая төгрөгөөр;

- Хархорум хотын Захирагчийн ажлын албаны урсгал зардлыг 2025 оны түвшинд тооцож 2,840.0 сая төгрөгөөр;

- Орон нутгаас бусад бүх төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал засварын зардлыг 40,000.0 сая төгрөгөөр;

- Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын их засварын зардлыг Төсвийн шатлал хоорондын тооцооллыг оруулснаар тооцож 40,000.0 сая төгрөгөөр;

- Үндэсний аудитын газрын урсгал зардлыг 2025 оны түвшинд тооцож 4,916.8 сая төгрөгөөр;

- Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын эрдэм, шинжилгээ судалгааны ажлын зардлыг 916.8 сая төгрөгөөр;

- Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцын судалгаа шинжилгээний зардлыг 1,510.2 сая төгрөгөөр;

- Шадар сайдын төсвийн багцын эрдэм шинжилгээ, судалгааны зардлыг 9,000.0 сая төгрөгөөр;

- Орон нутгийн авто замын сангийн санхүүжилтийг төсвийн шатлал хоорондын харилцаагаар тооцсон дүнгээр буюу 60,000.0 сая төгрөгөөр;

- Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Улсын ерөнхий прокурор болон Шадар сайдаас бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлыг 2025 оны түвшинд тооцож нийт 6,816.7 сая төгрөгөөр буюу нийт 971,885.7 сая төгрөгөөр бууруулах.

## **Хөрөнгийн зардал бууруулах:**

- Төслийн 2 дугаар хавсралтын Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой болон боловсрол, эрүүл мэнд, онцгой байдал, батлан хамгаалах, соёл, улсын бүртгэл, шүүх шинжилгээ, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага, сонгуулийн тоног төхөөрөмжөөс бусад шинээр хэрэгжүүлэх тоног төхөөрөмжийн санхүүжилтийг 50 хувиар буюу 62,930.4 сая төгрөгөөр, 2026 онд дуусах хөрөнгө оруулалтын төслүүдийг хөндөхгүйгээр, 2027 он болон түүнээс цааших онуудад шилжих хөрөнгө оруулалтын төслүүдийн 2026 онд санхүүжих дүнг зам, тээврийн салбарынхыг 17.2 хувиар буюу 77,367.8 сая төгрөгөөр, бусад салбарынхыг 15 хувиар буюу 127,010.7 сая төгрөгөөр, УТ2601300905 төслийн кодтой “Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой барилга байгууламж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 150,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацааг 2026-2027 он гэж өөрчлөн, 2026 онд санхүүжих дүнг 50,000.0 сая төгрөгөөр, уг саналуудад давхардаагүй Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлж, нийт 14,529.3 сая төгрөгөөр Хавсралт 1-д тусгагдсаны дагуу нийт 331,838.2 сая төгрөгөөр бууруулах.

## **1.2.Зардал нэмэгдүүлэх санал:**

### **Урсгал зардал нэмэгдүүлэх санал:**

- Боловсролын салбарын гүйцэтгэлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх хүрээнд багш нарын үндсэн цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-ээс 742.0 мянган төгрөгөөр, 11 дүгээр сарын 01-ээс 2,800.0 мянган төгрөгт хүргэхээр тооцож Боловсролын сайдын урсгал зардлыг 518,620.2 сая төгрөгөөр;

- Эмч, эмнэлгийн байгууллагын ажиллагсдын цалинг 15 хувиар нэмэгдүүлэхэд зориулж Эрүүл мэндийн сайдын урсгал зардлыг 190,300.0 сая төгрөгөөр;

- Төрийн өмчийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ажилчдын цалинг 15 хувиар нэмэгдүүлэхэд зориулж Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын урсгал зардлыг 9,794.9 сая төгрөгөөр, Боловсролын сайдын урсгал зардлыг 925.7 сая төгрөгөөр, нийт 10,720.6 сая төгрөгөөр;

- Ахмад настны тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлэхээр төсөлд тусгагдсаныг инфляцын түвшинтэй уялдуулан тооцож 8.6 хувь болгон нэмэгдүүлэхэд зориулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын урсгал зардлыг 145,000.0 сая төгрөгөөр;

- Халамжийн тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлэхээр төсөлд тусгагдсаныг инфляцын түвшинтэй уялдуулан тооцож 8.6 хувь хувь болгон нэмэгдүүлэхэд зориулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын урсгал зардлыг 19,500.0 сая төгрөгөөр;

- Монгол Улсын иргэний дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүүхэд залуучуудын суралцах тэгш боломжийг хангах, дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгодог “Илгээлт-2100” хөтөлбөрийн санхүүжилтийг 33,000.0 сая төгрөгөөр;

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын урсгал зардлыг 2,446.8 сая төгрөгөөр;

- Хүний эрхийн сурах бичигт зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 231.9 сая төгрөгөөр;

- Шатахууны нөөцийн агуулах, дэд бүтэц бүрдүүлэх хүүгийн татаас, хяналтын системийг бүрдүүлэх зардалд 20,000.0 сая төгрөгөөр буюу нийт 939,819.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

### **Хөрөнгийн зардал нэмэгдүүлэх санал:**

- Магадлалын ерөнхий дүгнэлтэд хийсэн аудитын дүгнэлтийг үндэслэж хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэхтэй холбогдуулан эрүүл мэнд, боловсролын салбарын зарим төсөл, арга хэмжээг төсөлд шинээр тусгах, санхүүжих дүнг нэмэгдүүлэх, мөн Хөгжлийн бодлогын зарим баримт бичгүүд, бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгагдсан авто зам, гүүр, эрчим хүч, иргэдийн орон нутагтаа ажиллаж, амьдрах, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн өрсөлдөх чадвартай бүсүүдийг бий болгох зорилт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор хөрөнгийн зардлыг 363,904.4 сая төгрөгөөр буюу Хавсралт 2-т тусгагдсаны дагуу нэмэх.

### **1.3.Орлого нэмэгдүүлэх санал:**

Татварын зарлагыг бууруулах буюу нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжих хугацааг хойшлуулж, үүнтэй уялдуулан татварын орлогыг 375,000.0 сая төгрөгөөр, мөн төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 2025 оны төсөвлөсөн дүнд хүргэж 5,000.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх.

### **1.4.Орлого бууруулах санал:**

Агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлогоос төсөвт төвлөрүүлэхээр тооцсон дүнг 40,000.0 сая төгрөгөөр, мөн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг 10,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Д.Батбаяр, Ж.Алдаржавхлан, Р.Батболд, Б.Заяабал, Д.Жаргалсайхан, Х.Жангабыл, П.Мөнхтулга, Г.Тэмүүлэн /цаашид “ажлын хэсэг” гэх/.

Энийг түрүүн санал хураачихсан. Гүйцээн боловсруулагч чиглэл асуудал чинь энэ байгаа. Нэг дэх асуудал нь.

2.Төсвийн тэнцэлд нөлөөлөхгүй зохицуулалт. Айн. Энэ дээр сая санал хураагаад эхний асуудлаар 6 асуудал хэлэлцэнэ гээд тэр дээрээ санал хураагаад дэмжигдчихсэн байгаа. Тэрний 1 дүгээрт нь.

### **2.Төсвийн тэнцэлд нөлөөлөхгүй зохицуулалтын санал**

2.1.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601100108 төслийн кодтой “Татварын мэдээллийн системийн дэд бүтэц, серверийн болон татварын албадын тоног

төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 23,026.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 19,706.6 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр төслийн 2 дугаар хавсралтад “Чойбалсан нисэх буудал /Аэродром/-ын хөөрч, буух зурвас, шинэчлэх /Дорнод, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг 59,120.0 сая төгрөг, санхүүжих дүн 19,706.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57 хүн байгаад байдаг. Санал хураалт. 97 гишүүнээс 57 гишүүн дэмжиж, 58,8 хувиар санал дэмжигдлээ.

2.2.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 3,068.7 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Цэцэрлэгийн барилга 150 ор /Дорнод, Дашбалбар сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 6,137.4 сая төгрөг, санхүүжих дүн 3,068.7 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 97 гишүүнээс 57 гишүүн дэмжиж 58,7 хувиар санал дэмжигдлээ.

2.3.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 2,231.9 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Цэцэрлэгийн барилга 150 ор /Дорнод, Матад сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 4,463.6 сая төгрөг, санхүүжих дүн 2,231.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

2.4.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102900758 төслийн кодтой “Гандангийн дэнж” шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв, барилгын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг 23,484.9 сая төгрөг, санхүүжих дүн 6,130.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,090.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Хүүхэд залуучуудын “Зүүн наран” хүрээлэн /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 9,271.9 сая төгрөг, санхүүжих дүн 3,090.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Түрүүчийн 2.3 дээр 97 гишүүнээс 56 гишүүн дэмжиж, 57,7 хувиар санал дэмжигдсэн байна шүү.

2.4-ийг сая уншсан. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 97 гишүүнээс 58 гишүүн дэмжиж, 59,8 хувиар санал дэмжигдлээ.

2.5.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой “Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 186,000.6 сая төгрөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,719.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Монголын нууц товчоо цогцолборын барилгын гадна тохижилтын ажлын нэмэлт ажил /Хэнтий, Дэлгэрхаан сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 685.0 сая

төгрөг”, “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Баян-Овоо сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн 434.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг, “Уурын зуухны барилгын шугам сүлжээний засвар /Хэнтий, Мөрөн сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 600.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусга. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 98 гишүүнээс 58 гишүүн дэмжиж, 59,2 хувиар санал дэмжигдлээ.

2.6.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,080.2 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Баян-Адарга сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн 404.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Бэрх тосгон/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн 651.8 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Шихихутаг, нууц товчоо түүхэн аялал жуулчлалын барилгын нэмэлт санхүүжилт” /Хэнтий, Норовлин сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 641.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Их хуралдай цогцолборын барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Биндэр сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 238.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Соёлын төвийн барилга, /Хэнтий, Батширээт сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 436.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг, “Соёлын төвийн барилга, /Хэнтий Цэнхэрмандал сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,707.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах. Санал гаргасан ажлын хэсэг. 98 гишүүнээс 57 гишүүн нь дэмжиж, 58,2 хувиар санал дэмжигдлээ.

Өнгөрсөн 7 хоногийн бүтэн сайн өдөр би Хэнтий аймгийн Батширээт сумд очиж уулзалт хийсэн. Соёлын төв нь газар луу доошийгоо ухчихсан, доошоо ордог. Тэгээд бүр дээр үеийн Соёлын төвтэй. Тэндээ хүмүүс нь багталцаж ядан, намхан дээвэртэй 1957 оны ийм Соёлын төвтэй байлаа. Энэ саналыг гаргасан ажлын хэсэгт Батширээт сумынхаа нийт иргэдийн өмнөөс талархал илэрхийлье.

2.7.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800893 төслийн кодтой “Замын-Үүд талаас Сайншанд чиглэлийн 16 км хатуу хучилттай замын хэсэгчилсэн их засвар /Дорноговь/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 22,268.3 сая төгрөг, санхүүжих дүн 10,020.8 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасаж, энэ эх үүсвэрээр “Саран хөхөө дуулалт театр, төсөвт өртөг 15,800.0 сая төгрөг, санхүүжих дүн 8,300.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан ажлын хэсэг. 98 гишүүнээс 52 гишүүн дэмжиж, 53,1 хувиар санал дэмжигдлээ.

2.8.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2003400774 төслийн кодтой Байгалийн түүхийн музейн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2020-2026 он, төсөвт өртөг 130,618.4 сая төгрөг, санхүүжих дүн 51,982.6 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг аудитын магадлалын ерөнхий дүгнэлтийг үндэслэн 94,691.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, санхүүжих дүнг 36,000.0 сая төгрөгөөр

бууруулж, энэ эх үүсвэрээр “Байгалийн түүхийн музейн үзүүлэг дэглэлт, үзмэрийн интерьерийн зураг, цуглуулга, үзмэрийн тоноглол, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 178,368.0 сая төгрөг, санхүүжих дүн 36,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан ажлын хэсэг. 98 гишүүнээс 52 гишүүн дэмжиж, 53,1 хувиар санал дэмжигдлээ.

2.9.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад тусгагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Цөлжилттэй тэмцэх тухай” суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлын үед зохиогдох соёл, урлагийн арга хэмжээний зардлыг 4,000.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын багцын Кино урлагийг дэмжих сангийн санхүүжилтийг нэмэгдүүлэх. Та үг хэлэх үү.

Тэрнээс өмнө би тэр 2.8-ын 36 тэрбум гэдгийг 3 тэрбум гээд уншихсан байна. 36 тэрбум шүү. 2.9-тэй холбоотой, Коп-17-той холбоотой Батбаатар ойрын үед үг хэлээгүй юм байна. Хэлчих.

**Б.Батбаатар:** Энэ Коп 17 бол зүгээр одоо явж байгаа ажил биш л дээ. Энэ чинь 4 жилийн өмнө 2022 оноос эхэлчихсэн. Сайд дотор багцдаа ингэж нэршлийг нь өөрчлөх хэрэг байгаа юм уу. Кино урлаг гэдэг чинь Коп-17 биш шүү дээ. Энийг зүгээр энэ чигээр нь үлдээгээд, энэ саналыг унагаагаад өгөөч гэж хүсэж байна.

Энэ бол Монгол Улсын бусдын өмнө.../минут дуусав/

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр Коп-17-г дэмжиж маш их хэмжээний хөрөнгө оруулалтыг тавьж байгаа. Тийм учраас гишүүд өөрсдийнхөөрөө саналаа өгцгөөнө. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Мэндсайхан, Цогтбаатар гишүүн горимын санал гаргая.

**Да.Цогтбаатар:** Гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ сая санал хураах төхөөрөмжид амжиж дарж амжсангүй. Санал хураалтыг дахин явуулж өгнө үү гэдэг санал гаргаж байна. Хүчингүй болгоод, дахин санал хураалт хийж өгнө үү.

**Б.Пүрэвдорж:** Наадах чинь горимын санал биш байна. Мэндсайхан гишүүн горимын санал гаргая.

**3.Мэндсайхан:** Техникийн саатал гарсан учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хурааж өгнө үү гэсэн хүсэлт байна. Энэ ажилласангүй улайгаад.

**Б.Пүрэвдорж:** Мэндсайхан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 99 гишүүнээс 53 гишүүн дэмжиж, 53,5 хувиар санал дэмжигдлээ. Мэндсайхан гишүүний гаргасан санал дэмжигдсэн учраас 2.9-өөр томъёоллыг уншиж танилцуулсан. Ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 52 гишүүн дэмжиж, 52 хувиар санал дэмжигдлээ.

2.10.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602900572 төслийн кодтой “Үерийн хамгаалалтын далангийн 2, 3 дугаар ээлжийн байгууламж /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг нь 10,407.8 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 3,122.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, энэ эх үүсвэрээр

"Шинэ суурьшлын бүсийн дэд бүтцийн ажил /Архангай Эрдэнэбулган сум/", хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 25,651.2 сая төгрөг, санхүүжих дүн 3,122.4 сая төгрөг" гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан ажлын хэсэг. 100 гишүүнээс 58 гишүүн дэмжиж, 58 хувиар санал дэмжигдлээ.

2.11.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг" гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 2,400.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр "Ахмадын сувиллын иж бүрэн засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 19-р хороо/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,300.0 сая төгрөг" гэсэн төсөл, арга хэмжээ болон "Хиймэл оюун мэдээллийн технологийн "Google"-ийн хөтөлбөр хэрэгжүүлэх лаборатори сургуулийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар сургууль/ хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,100.0 сая төгрөг" гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100 гишүүнээс 59 гишүүн дэмжиж, 59 хувиар дэмжигдлээ.

2.12.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400293 төслийн кодтой "Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 26,586.5 сая төгрөг, санхүүжих дүн 7,976.0 сая төгрөг" гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 600.0 сая төгрөгөөр, УТ2601400293 төслийн кодтой "Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн ажилчдын орон сууцны барилга, 50 айл /Говь-Алтай, Есөнбулаг сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 5,949.2 сая төгрөг, санхүүжих дүн 2,082.1 сая төгрөг" гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 600.0 сая төгрөгөөр, УТ2601400232 төслийн кодтой "Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 20,132.1 сая төгрөг, санхүүжих дүн 9,000.0 сая төгрөг" гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 300.0 сая төгрөгөөр буюу нийт 1,500.0 сая төгрөгөөр хөрөнгийн зардлыг бууруулж, Батлан хамгаалах яамны харьяа Үндэсний батлан хамгаалахын Их сургуулийн урсгал зардлыг 1,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100 гишүүн оролцож, 54 гишүүн дэмжиж, 100 гишүүнээс 54 гишүүн дэмжиж, 54 хувиар санал дэмжигдлээ.

2.13.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402901667 төслийн кодтой "Ховд хотын ундны усны хоёр дахь эх үүсвэр /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2024-2028 он, төсөвт өртөг 38,071.2 сая төгрөг, санхүүжих дүн 5,825.0 сая төгрөг" гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,500.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр "Сум, багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Увс, Завхан, Ховд, Говь-Алтай/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 4,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Бум-Очир гишүүн горимын санал гаргана.

**Д.Бум-Очир:** Төхөөрөмж ажилласангүй ээ. Уучлаарай. Тэгэхээр саяын саналыг хүчингүй болгож, дахиж санал хураалт явуулж өгнө үү.

**Б.Пүрэвдорж:** Бум-Очир гишүүний гарган саналаар санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 54 гишүүн дэмжиж, 54 хувиар санал дэмжигдлээ. Түрүүний уншсан саналын томъёоллын дагуу санал хураалт. 100 гишүүнээс 53 гишүүн дэмжиж, 53 хувиар санал дэмжигдлээ.

2.15.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдийн лабораторийн багаж, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 32,544.4 сая төгрөг Уучлаарай. Алгасчихсан байна.

2.14.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102900392 төслийн кодтой “Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /Архангай/, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг 26,964.8 сая төгрөг, санхүүжих дүн 6,118.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,608.5 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Нийтийн ариун цэврийн байгууламж бүхий барилгын гадна замын авто зогсоол /Архангай, Цэнхэр сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,608.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг 6 секундйн горим дээр тавьчихсан байгаа шүү. 100 гишүүнээс 60 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

2.15.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдийн лабораторийн багаж, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 32,544.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 1,200.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Кембрижийн хөтөлбөр хэрэгжүүлэх лаборатори сургуулийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн” /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 166 дугаар сургууль/, хэрэгжих хугацаа 1,200.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Сая энэ бол сая Ганхуяг ажлын хэсгийн даргын гаргасан 6 гүйцээн боловсруулах чиглэлд санал хураагдаж, дэмжигдсэн асуудал байгаа. Энэ гүйцээн боловсруулалтаар буцсан байгаа. Санал хураахгүй.

2.16.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601100108 төслийн кодтой “Татварын мэдээллийн системийн дэд бүтэц, серверийн болон татварын албадын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 23,026.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 3,320.3 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Газрын тос боловсруулах үйлдвэрийн цахилгаан хангамжийн 110кВ-ын ЦДАШ, 110/35/10кВ-ын Ширээт дэд станц, хэрэгжих хугацаа 2026-2028 он, 16,837.9 сая төгрөг, санхүүжих дүн 3,320.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан ажлын хэсэг. 100 гишүүнээс 60 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

### **3.Төсвийн тэнцэлд нөлөөлөхгүй санал**

#### **3.1 Төсвийн захирагч хооронд шилжүүлэх:**

1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын Сэлэнгэ аймгийн Мандал сумын хүүхдийн ордны үйл ажиллагааг орон нутаг руу шилжүүлэх

замаар Сэлэнгэ аймгийн суурь зардлыг 421.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100. Гишүүнээс 60 гишүүн дэмжиж 60 хувиар санал дэмжигдлээ.

### **3.2.Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний нэр өөрчлөх санал:**

1.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400557 төслийн кодтой “Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаанд нэн шаардлагатай тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний “үйл ажиллагаанд нэн шаардлагатай” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100 гишүүнээс 58 гишүүн дэмжиж, 58 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400570 төслийн кодтой “Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын төрийн өмчийн барилга байгууламжийн хүчитгэл, их засвар /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний “хүчитгэл,” гэснийг “сэргээн засварлах” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100 гишүүнээс 62 гишүүн дэмжиж, 62 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602900811 “Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Архангай, Өвөрхангай/” гэсэн төсөл, арга хэмжээний “Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” гэснийг “Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100 гишүүнээс 67 гишүүн дэмжиж, 67 хувиар санал дэмжигдлээ.

### **3.3.Төслийн 1 дүгээр хавсралтын талаарх санал:**

1.Төслийн Төслийн 1 дүгээр хавсралтын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “16.1.3.4 Цагаатгал, нөхөн олговортой холбоотой хууль тогтоомжийн нэгдмэл байдлыг хангах, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024 он, Суурь түвшин: 25, Зорилтот түвшин: “40” гэсэн дэд заалт, “16.1.3.5 Их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад хэлмэгдүүлэлт, түүний хор уршгийг таниулах чиглэлээр сургалтад хамрагдсан сурагчдын хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024 он, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10 %” гэсэн дэд заалт тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100 гишүүнээс 67 гишүүн дэмжиж, 67 хувиар санал дэмжигдлээ.

### **3.4.Засгийн газрын 2026 оны төсвийн жилд шинээр үүсгэх өрийн хэмжээнд өөрчлөлт оруулах санал:**

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг буюу “Өрийн удирдлагын тухай хуулийн 28<sup>1</sup>.1-д заасан зориулалтаар гаргах аймгийн үнэт цаасны дээд хэмжээг 150,000.0 сая төгрөг хүртэл” гэсний “аймгийн” гэснийг “аймаг, нийслэлийн” гэж, “150,000.0 сая төгрөг” гэснийг “425,000.0 сая төгрөг” гэж, холбогдох шийдвэрийн төслийн хамт өөрчлөх. Энэ чинь санал хураалтаар явна шүү дээ. Энэ дээр гүйцээн боловсруулах чиглэл. Яагаад гэвэл энэ тэнцэлд нөлөөлж магадгүй учраас гүйцээн боловсруулах чиглэлийг Ганхуяг дарга хүсэж байгаа юм байна. Тэгээд санал хураалт гүйцээн боловсруулах санал хураалт. 100 гишүүнээс 64 гишүүн дэмжиж, 64 хувиар санал дэмжигдлээ.

#### **4.Зарчмын зөрүүтэй саналын томьёололд нийцүүлэн хуулийн төсөлд өөрчлөлт оруулах санал:**

4.1.Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан дэмжигдсэн саналуудыг төсвийн тооцоололд бүрэн тусгаж, зарчмын зөрүүтэй дэмжигдсэн саналуудыг нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг тусгах, үүнтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын зарцуулах урсгал болон хөрөнгийн зардал, төвлөрүүлэх орлогын хэмжээ, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн болон Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагад нөлөөлөх өөрчлөлт, мөн төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томьёог жигдлэх засварыг хийх, мөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, эдийн засгийн ангилал, хэрэгжих хугацааг саналын томьёололд нийцүүлэн өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100 гишүүнээс 65 гишүүн дэмжиж, 65 хувиар санал дэмжигдлээ.

4.2.Монгол Улсын 2026 оны төсвийн тооцоололд өөрчлөлт оруулах болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналын томьёололтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн холбогдох хуулийн төслийг боловсруулж Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100 гишүүнээс 63 гишүүн дэмжиж, 63 хувиар санал дэмжигдлээ.

#### **Хоёр.Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан санал**

1.Төслийн Засгийн газрын нөөц сангаас 12,705.1 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Сумын төвийн цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж /Ховд, Эрдэнэбүрэн сум 1-р баг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,579.8 сая төгрөг, санхүүжих дүн 3,579.8 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Шинэ ховд үйлдвэрлэл технологийн паркийн цахилгаан хангамж, гол шугам сүлжээний ажил /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 2,174.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “35Кв-ын ЦДАШ, 35/10 кВ-ын 1х6300 кВА чадалтай дэд станцын угсралтын ажил /Ховд, Булган сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,641.5 сая төгрөг, санхүүжих дүн 2,641.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн барилга 10 ор /Ховд, Ховд сум 5 дугаар баг, Дунд ус/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 4,309.4 сая төгрөг, санхүүжих дүн 4,309.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн 3.Мэндсайхан.

Үүнтэй холбоотойгоор гүйцээн боловсруулах чиглэлийг түрүүн түрүүн хураалгачихсан. Гүйцээн боловсруулна.

2.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2101101137 төслийн кодтой “Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 546,556.0 сая төгрөг, санхүүжих дүн 121,721.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,600.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Сумдын хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн барилга, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 3,600.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр

нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн. Санал хураалт. 100 гишүүнээс 53 гишүүн дэмжиж, 53 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502923292 төслийн кодтой “Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг 167,595.9 сая төгрөг, санхүүжих дүн 47,649.8 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,917.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Туул гол орчмын үерийн хамгаалалтын байгууламж/ Улаанбаатар, Хан-Уул дүүрэг 12 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 5,917.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан санал хураалт 100 гишүүнээс 59 гишүүн дэмжиж, 59 хувиар санал дэмжигдлээ.

4.Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хөрөнгийн бусад зардлыг 4,700.0 сая төгрөгөөр бууруулж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны урсгал зардлыг 4,700.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа. Санал хураалт. 66 гишүүн дэмжиж, 66 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2101101137 төслийн кодтой “Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 546,556.0 сая төгрөг, санхүүжих дүн 121,721.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,588.6 сая төгрөгөөр бууруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын урсгал зардлыг 2,588.6 сая төгрөгөөр, Үндэсний аудитын газрын урсгал зардлыг 1,000.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, Б.Мөнхсоёл, Х.Ганхуяг. Санал хураалт. 100 гишүүнээс 64 гишүүн дэмжиж, 64 хувиар санал дэмжигдлээ.

### **Гурав.Бусад Байнгын хорооны санал**

1.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 9,000.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Онги-Цагаан бургастай төсөл, төслийн ТЭЗҮ, зураг төсөв, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 44,490.0 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 9,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, Ц.Мөнхбат, Г.Ганбаатар, Р.Эрдэнэбүрэн, Н.Наранбаатар, Б.Дэлгэрсайхан. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос дэмжсэн санал. Санал хураалттай холбогдуулан 1 л үг хэлье. Мөнхбаясгалан гишүүн үг хэлье.

**Л.Мөнхбаясгалан:** Энэ төсөл бол манай энэ жилийн 2026 оны улсын төсвийн хамгийн ногоон төсөл, хамгийн эко төсөл болоод байгаа. Тэгээд энэ өөрийнхөө багцаас хөрөнгө оруулалтын багцаас 9 тэрбум төгрөгийг говийн усны энэ “Онги-Цагаан бургастай төсөлд оруулж байгаа Эдийн засаг, хөгжлийн сайд Учрал болон Эдийн засаг, хөгжлийн яамныханд баярлалаа. Ингээд ногоон төслийг дэмжиж ногоон кнопоо дарж өгнө үү.

**Б.Пүрэвдорж:** Ажлын хэсгийн дарга болон Ардын намын байнгын хорооны бүлгийн дарга нартаа хэлээд, дэмжүүлэхээр болж байна шүү. Санал хураалт. 67 хувиар орлоо шүү дээ. 100 гишүүнээс 67 гишүүн дэмжиж, 67 хувиар санал дэмжигдлээ. Ажлын хэсгийн дарга Ганхуяг гишүүн дэмжсэнээр ав гэж байна. Ганхуяг гишүүн дэмжсэнээр санал өгсөн байна шүү. Уянгахишиг гишүүн, Шижир гишүүн 2 дэмжсэн.

### **Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал**

1. Ажлын хэсгийн санал. Дэмжээгүй ажлын хэсгийн санал шүү.

1. Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808722 төслийн кодтой “Өгийнуур-Мянганы замын хэвтээ тэнхлэг чиглэлийн хатуу хучилттай авто зам, 28.5 км /Хангайн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 43,603.2 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 12,989.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжих дүнг 4,853.3 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж /Архангай, Эрдэнэбулган төв сум, 5-р баг, Наранбулаг/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 13,263.2 сая төгрөг, санхүүжих дүн 3,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг болон “Тайхар чулуу хүртэлх 3.2 км хатуу хучилттай авто зам /Архангай, Ихтамир сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 5,853.3 сая төгрөг, санхүүжих дүн 1,853.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100 гишүүнээс 68 гишүүн дэмжиж, 68 хувиар санал дэмжигдлээ.

2. Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан санал

1. Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800770 төслийн кодтой “Хатгал-Ханх чиглэлийн 180 км хатуу хучилттай авто замын эхлэл /Хөвсгөл/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 41,350.1 сая төгрөг, санхүүжих дүн 10,100.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Жаргалант-Хатгал-Ханх чиглэлийн 332 км хатуу хучилттай авто замын эхлэл /Хөвсгөл/” гэж, төсөвт өртгийг “1,142,000.0 сая төгрөг” гэж тус тус өөрчлөх. Пөөх энэ чинь. Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан дэмжээгүй санал байна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн. Санал хураалт. 100 гишүүнээс 63 гишүүн дэмжиж, 63 хувиар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 170,899.7 сая төгрөг, санхүүжих дүн 25,635.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,798.0 сая төгрөгөөр бууруулж, “Прокурорын газрын цахим хавтаст хэрэг, зөрчлийн системийн сервер, тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 4,798.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, П.Сайнзориг. Сайнзориг гишүүн үг хэлнэ.

**П.Сайнзориг:** Баярлалаа. Уг нь бол энэ улсын хэмжээнд бас хүний эрхийг хангах чиглэлийн асуудал байгаад байгаа юм. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цаашдаа ер нь цахим хавтаст хэрэг рүү ороод, нотлох баримтууд үрэгддэггүй. Орон зай, цаг хугацаанаас хамаараад хэргийн оролцогчид бас хавтаст хэргийнхээ

материалтай танилцчихдаг. Жилд 2 сая гараад явчхаж байгаа байх. 2 сая 200 мянга орчим зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг цаасан суурьтай биш, ингээд цахим руу оруулах бүрэн бололцоо байгаад байгаа юм. Энэ сервер тоног төхөөрөмжийг авчихвал улсын хэмжээнд ажиллаж байгаа эрх бүхий албан тушаалтнууд буюу улсын байцаагч гэж нэртэй ийм хүмүүс үндсэндээ цахимаар буюу таблетыг ашиглаад, цаасгүйгээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хийж, цаашдаа хэмнэлт үүсгэх бололцоо байгаад байгаа юм. Засгийн газар цахимжилтаа хийчхээд байгаа боловч шүүх эрх мэдлийн байгууллагууд жоохон хоцрогдолтой байгаа. Энийг нь уг нь дэмжээд өгчихвөл бас Хууль зүй, дотоод хэргийн яам энийг нь бас ЭБАТ-уудыг холбох чиглэлийн юмыг нь бол нөгөө талаас нь хийчхээд байдаг. Эцсийн зогсоол буюу хүлээж авч байгаа прокурорынх нь асуудал гацчихаад байгаа юм. Тэгээд гишүүд маань энэ дээр кноподоо хүрэхгүй байж байгаад, ер нь улсын хэмжээнд явж байгаа гэмт хэрэг, зөрчлийн асуудлыг цаашдаа цахим суурьтай цахимд шилжүүлэх энэ ажил дээр бас нэг бодлогын дэмжлэг үзүүлээч ээ. Кноподоо хүрэхгүй байж үзээч ээ л гэж хүсэж байна.

**Б.Пүрэвдорж:** Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 59 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын урсгал зардлыг 1,578.0 сая төгрөгөөр бууруулж, Хүний эрхийн үндэсний комиссын даргын урсгал зардлын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,578.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг. Сайнзориг үг хэлнэ.

**П.Сайнзориг:** Дарга аа, энэ асуудал уг нь Хууль зүйн байнгын хороо дээр бас яригдах байсан. Орхигдчихсон юм. Тэгээд би Төсвийн байнгын хорооны гишүүний хувьд гаргаж байгаа юм. Улсын Их Хурлаас мандат авч буюу байгуулагдаж байгаа Хүний эрхийн Үндэсний Комисс маань байр түрээсэлж, үйл ажиллагаа явуулдаг юм байна. Энэ зардал нь байхгүй болчихоор он дамнасан өр авлага ч юм уу, энэ байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдах, Монгол Ардын нам гэлтгүй энд сууж байгаа суудалтай бүх намуудын мөрийн хөтөлбөр дээр хүний эрхийн асуудал уг нь байгаа. Тэгээд Хүний эрхийн Үндэсний Комисс үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангах үүднээс энэ асуудлыг нь тавьж өгөхгүй бол бараг үйл ажиллагаа явуулж чадахгүй, байрнаасаа гарах хэмжээнд хүртэл ингээд эрсдэлүүд явна. Тэгэхээр энийг уг нь бололцооны хэмжээнд дэмжээд өгөөч. Өөр яг сайдаас авчихъя гэхээр бас болж өгдөггүй. Тэгээд төлөвлөлтийн асуудал яасан учраас Эдийн засаг, хөгжлийн яамнаас зүгээр бага л хасаж байгаа юм. Энэ бол шалихгүй зардал байгаа байхгүй юу. Тэгээд энэ Улсын Их Хурлын дэргэдэх гэх юм уу, Улсын Их Хурлаас мандат авч явуулж байгаа Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааг бас хэвийн явуулж өгөх талд бас гишүүд анхаарч өгөөч ээ л гэж эцэст нь хэлмээр байна. Кноподоо битгий хүрээч ээ гэж хүсэж байна.

**Б.Пүрэвдорж:** Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

4.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 170,899.7 сая төгрөг, санхүүжих дүн 25,635.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга

хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн гадна замаас Эмээлт шувуун фабрик хүртэлх 12.55 км авто замын эхлэл /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Би түрүүчийн Сайнзориг гишүүний 3 дугаар асуудал дээр 100 гишүүнээс 59 гишүүн дэмжиж, Байнгын хорооны санал дэмжигдсэн байна шүү.

4 дэх асуудал нь явж байгаа. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг. Сайнзориг гишүүн үг хэлье.

**П.Сайнзориг:** Баярлалаа дарга аа. Манайд энэ аюултай ачаа, барааг тээвэрлэдэг тусгайлан зам ерөөсөө байдаггүй. Ингээд Алтанбулаг боомтоор ч юм уу орж ирж байгаа, эсвэл энэ ойролцоох төмөр замын агуулах савтай газрууд өртөөнүүд дээр буусан энэ аюултай ачаа бараанууд хотын дундуур гарч байж, урагшаа говийн уул уурхайн бүс нутаг руу болон бусад газар луу гараад байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлуудыг бас цэгцлэх үүднээс энэ 12,5км зам хэрэгтэй байгаа юм. Дээрээс нь Засгийн газрын бодлогын түвшинд Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас ТЭЗҮ-ээ батлуулсан 1 төсөл бол Эмээлт аж үйлдвэрийн парк байгаа. Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо буюу хуучнаар энэ үйлдвэрчний районд байсан бүх энэ арьс шир боловсруулах үйлдвэрүүд энэ эмээлт үйлдвэрийн парк руу бас гарах гээд байгаа юм. Энэ гарахын тулд энэ зам бас тэдгээр байгууллагуудын үйл ажиллагааг дэмжинэ.

2 дугаарт энэ хот дундуур аюултай ачаа, бараа оруулж ирж энэ эрсдэлийг үүсгэхгүй байхын тулд бас энэ замыг дэмжиж өгөөд, говийн замтайгаа холбоё л гэж байгаа юм. Саяхан нефть бүтээгдэхүүн тасраад, түгээлтүүдийг бас эрчимжүүлэх гээд явахад Дамдинням сайд харж л байсан байх даа. Зарим машинуудын бензин хот дундуур дусалчихсан асгараад л ингээд л явж байгаа. Тэгээд энэ их түгжрэл дунд ийм аюултай ачаа, бараа буюу энэ цистер хотын түгжрэл дунд ингээд нөхцөл байдлыг явна гэдэг бол том эрсдэл байгаад байгаа юм. Тэгээд энэ асуудлыг 2 талтай 1 дүгээрт тэр аюултай ачаа, барааг хот дотор оруулахгүйгээр гаргах, нөгөө талдаа Эмээлт аж үйлдвэрийн парк руу аж ахуйн нэгж, байгууллагууд буюу Хан-Уул дүүргийн 2 дугаар хороонд байрлаж байгаа энэ 30-аад аж ахуйн нэгж, байгууллагууд Эмээлт аж үйлдвэрийн парк руу гарах энэ ажиллагааг бодлогын хувьд дэмжиж өгье л гэж байгаа. Тэгээд энэ асуудлыг уг нь кноподоо хүрэхгүйгээр дэмжээд өгчихвөл аль аль талаасаа ингээд говийн замтай Дарханы замаасаа шууд урагшаа гараад явчих энэ бололцоог л бүрдүүлэх үүднээс явж байгаа юм.

**Б.Пүрэвдорж:** Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. 100 гишүүнээс 58 гишүүн дэмжиж, 58 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2503000996 төслийн кодтой “Аймгийн төвд баригдаж байгаа “Дулааны станц төсөл”-ийн 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Баянхонгор, Баянхонгор/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 51,948.9 сая төгрөг, санхүүжих дүн 19,832.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж /Хангайн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 5,000.0 сая

төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар. Саналтайгаа холбогдуулан Даваагийн Цогтбаатар гишүүн үг хэлнэ.

**Да.Цогтбаатар:** Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Энэ гаргаж байгаа санал нь бол өмнө нь энэ гишүүдийн яриад байгаа улс төржсөн төсөв энэ тэр гэдэгтэй ямар ч хамаарал байхгүй. Баянхонгор аймагт хэрэгжиж байгаа Дулааны станцын өргөтгөлийн 2 дугаар хэлхээний ажил гэдгээс тодорхой хэмжээний мөнгөн дүнгээр багасгаад, малчдадаа нөгөө малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, орлого олох боломжийг нь нэмэгдүүлж байгаа хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж рүү тавьж өгч байгаа зардал учраас та бүхэн төхөөрөмждөө хүрэхгүй байж дэмжиж өгнө үү.

**Б.Пүрэвдорж:** Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 20 гишүүн дэмжиж, санал хураалт дэмжигдсэнгүй.

6.Төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлын “Хангамж бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, зочны зардал, нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардал”-аас нийт 361,351.9 сая төгрөгийг хасаж, энэ эх үүсвэрээр багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин. Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 56 гишүүн дэмжиж, 56 хувиар санал дэмжигдлээ.

7.Төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлаас тохижилт үйлчилгээний зардлаас 12,397.9 сая төгрөг, сургалт, дадлага, бэлтгэлийн зардлаас 851.1 сая төгрөг, нийт 13,249.0 сая төгрөгийг бууруулж, энэ эх үүсвэрээр төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808717 төслийн кодтой “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Баруун бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 43,991.8 сая төгрөг, санхүүжих дүн 13,249.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 13,249.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин. Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 61 гишүүн дэмжиж, 61 хувиар санал дэмжигдлээ.

8.Төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлаас сургалт, дадлага бэлтгэлийн зардлаас 3,194.9 сая төгрөг, тавилгын зардлаас 1,871.1 сая төгрөг, мэдээлэл сурталчилгааны зардлаас 2,061.9 сая төгрөг, багаж, техник хэрэгслийн зардлаас 5,953.8 сая төгрөг, тохижилт үйлчилгээний зардлаас 16,918.2 сая төгрөгийг тус тус бууруулж, нийт 30,000.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Баруун бүс/ хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 43,991.8 сая төгрөг, санхүүжих дүн 13,249.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 30,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин. Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 63 гишүүн дэмжиж, 63 хувиар санал дэмжигдлээ.

9.Төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлаас сургалт, дадлага бэлтгэлийн зардлаас 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Баянхонгор аймгийн төвөөс Архангай аймгийн Чулуут сум хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Хангайн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин. Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 52 гишүүн дэмжиж, 52 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлаас сургалт, дадлага бэлтгэлийн зардлаас 1,419.4 сая төгрөг, бууруулж, энэ эх үүсвэрээр “Соёлын төвийн барилгын тайз технологи, акустик, гадна зам талбайн тохижилтын нэмэлт санхүүжилт /Завхан, Нөмрөг сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 1,419.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин. Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 55 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

### **3.Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал**

1.Төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлтийн 1 дүгээр хавсралтад дурдсан Улсын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй нийт 76,929.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 18 төсөл, арга хэмжээг хасаж, төсвийн алдагдлыг бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин. Төсвийн зарлагын хяналтын дэд хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 60 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ. 3

2.Багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор дараах төсөл, арга хэмжээг төслөөс хасаж, хөрөнгийн зардлыг нийт 126,293.4 сая төгрөгөөр бууруулах. Үүнд:

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800805 төслийн кодтой “Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 37 км /Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 106,868.4 сая төгрөг, санхүүжих дүн 20,036.4 сая төгрөг”;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800888 төслийн кодтой “Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Зүүн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 60,156.2 сая төгрөг, санхүүжих дүн 18,046.9 сая төгрөг”;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 170,899.7 сая төгрөг, санхүүжих дүн 25,635.0 сая төгрөг”;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800770 төслийн кодтой “Хатгал-Ханх чиглэлийн 180 км хатуу хучилттай авто замын эхлэл /Хөвсгөл/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 41,350.1 сая төгрөг, санхүүжих дүн 10,100.0 сая төгрөг”;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400215 төслийн кодтой “Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 8,396.8 сая төгрөг, санхүүжих дүн 3,778.9 сая төгрөг”;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400239 төслийн кодтой “Спорт заалны барилга /Хөвсгөл, Түнэл сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,156.8 сая төгрөг, санхүүжих дүн 970.6 сая төгрөг”;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400052 төслийн кодтой “Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 6,728.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,018.7 сая төгрөг”;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606700065 төслийн кодтой “Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 14,368.5 сая төгрөг, санхүүжих дүн 4,310.6 сая төгрөг”;

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400522 төслийн кодтой “Спорт заалны барилга /Ховд, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,103.4 сая төгрөг, санхүүжих дүнг 1,396.6 сая төгрөгөөр бууруулах.

Энэ чинь гишүүдийнхээ санал руу ингэж хамаагүй орж болж байгаа юм болов уу. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. Төсвийн зарлагын хяналтын дэд хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явъя. 100 гишүүнээс 60 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

3.Багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор дараах төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацааг хойшлуулах буюу хөрөнгийн зардлыг 53,045.4 сая төгрөгөөр бууруулах. Үүнд:

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200838 төслийн кодтой “Гадаадын иргэн харьяатын газрын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,365.4 сая төгрөг, санхүүжих дүн 1,064.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200992 төслийн кодтой “Дотоод хэргийн их сургуулийн цогцолборын Хилийн албаны сургуулийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 21,343.2 сая төгрөг, санхүүжих дүн 6,403.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200865 төслийн кодтой “Хилийн цэргийн 0243 дугаар ангийн авто гарааж, авто засварын барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,017.2 сая төгрөг, санхүүжих дүн 1,357.8 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200851 төслийн кодтой “Хилийн цэргийн 0257 дугаар ангийн спорт заалны барилга /Хөвсгөл, Мөрөн сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,078.5 сая төгрөг, санхүүжих дүн 1,385.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200837 төслийн кодтой “Хилийн цэргийн ангийн албан хаагчдын орон сууцны барилга /Хөвсгөл, Цагаан-Уул сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 6,534.9 сая төгрөг, санхүүжих дүн 1,960.5 сая төгрөг”;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200991 төслийн кодтой “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны, цагдан хорих байрны барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 6,467.8 сая төгрөг, санхүүжих дүн 1,940.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200355 төслийн кодтой “Цагдаагийн газрын барилга /Булган аймаг, Булган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 5,353.6 сая төгрөг, санхүүжих дүн 1,606.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200382 төслийн кодтой “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны, цагдан хорих байрны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,968.3 сая төгрөг, санхүүжих дүн 1,785.7 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200517 төслийн кодтой “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга /Өвөрхангай, Хархорин сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 14,609.5 сая төгрөг, санхүүжих дүн 3,652.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400274 төслийн кодтой “Зэвсэгт хүчний дүгээр ангийн тусгай сургалт бэлтгэлийн төв /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,471.6 сая төгрөг, санхүүжих дүн 1,562.2 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400285 төслийн кодтой “Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Баруун бүс/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 19,657.7 сая төгрөг, санхүүжих дүн 7,942.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400293 төслийн кодтой “Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 26,586.5 сая төгрөг, санхүүжих дүн 7,976.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400232 төслийн кодтой “Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 20,132.1 сая төгрөг, санхүүжих дүн 9,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601501960 төслийн кодтой “Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн оюутны дотуур байрын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 18,030.0 сая төгрөг, санхүүжих дүн 5,409.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. Төсвийн зарлагын болон Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 61 гишүүн дэмжиж, 61 өөр санал дэмжигдлээ.

4.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын урсгал зардлыг бууруулах хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн тооцооллын хавсралтын хавсралт 15-д тусгагдсан зээлийн хүүгийн татаас буюу Шинэ хоршоо чинээлэг малчин хөтөлбөрийн зээлийн хүүгийн дэмжлэгийн санхүүжилт 108,954.0 сая төгрөгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. Төсвийн зарлагын хяналтын дэд хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 60 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

#### **4.Бусад Байнгын хорооны санал**

1.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 404.3 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Баян-Адарга сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн 404.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 55 гишүүн дэмжиж, санал хураалт 55 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой “Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 186,000.6 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 434.1 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Баян-Овоо сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн 431.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 59 гишүүн дэмжиж, 59 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 651.8 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт

санхүүжилт /Хэнтий, Бэрх тосгон/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн 651.8 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 61 гишүүн дэмжиж, 61 хувиар санал дэмжигдлээ.

4.Боловсрол, Эрүүл мэнд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбараас бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлыг 0.37 хувиар буюу 29,204.3 сая төгрөгөөр бууруулж, төслийн 2 дугаар хавсралтын УТ2603800007 төслийн кодтой “Сонгуулийн ерөнхий хорооны тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 41,720.4 сая төгрөг, санхүүжих дүн 12,516.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг мөн дүнгээр нэмэгдүүлж, хэрэгжих хугацааг 2026-2026 он гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 56 гишүүн дэмжиж, 56 хувиар санал дэмжигдлээ.

5.Төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламж болох 36 хүртэлх сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэмжийн зардалд тусгагдсан санхүүжилтийг 178,089.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, уг эх үүсвэрийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зардлын бараа үйлчилгээний бусад зардлыг 7.83 хувиар буюу 178,089.9 сая төгрөгөөр бууруулах замаар бүрдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

Та чинь ирцээс гараагүй байгаа билүү. Ирцээс гарчхаагүй билүү. Санал гаргасан Ариунзаяа гишүүн үг хэлнэ.

**А.Ариунзаяа:** Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүддээ баярлалаа. Төрийн байгуулалтын байнгын хороо дээр бид хууль зүйн дүгнэлт бас албан ёсоор гаргуулсан. Төрийн албаны тухай хуулийн 9.2 дахь заалтыг зөрчиж байгаа. Төсвийн тухай хуулийг мөн зөрчиж байгаа. Төрийн албан хаагчдаа өдөр шөнөгүй, нойр хоолгүй, бага цалинтай явуулсныхаа ганц хүлээж байгаа өндөр насны тэтгэвэртээ гарахдаа би ажилласан жилээрээ тооцуулж, 36 сар хүртэл тэтгэмж авна гэдэг энэ бодлогоор ер нь бол тэсэж ажилладаг. Ялангуяа эмч, багш, цэрэг, цагдаа. Сангийн яам эх үүсвэрийн 50 хувийг нь тавьсан нь бол 1 дүгээрт Төсвийн хуулийг, Төрийн албаны тухай хуулийг зөрчсөн. Тэгээд өнөөдөр тайлбар хэлээд байгаа нь бол дотроо зохицуулалтуудыг хийчихнэ. Санаа зоволтгүй гэж хэлээд байгаа. Гэтэл гишүүд ээ, яг өнөөдөр та бидний хурааж байгаа санал дотор бол одоо байгаа орон зайг маш ихээр хумьж байгаа. Ирэх онд дотроо зохицуулалт хийх боломж гарахгүй.

Тийм учраас та бүхэн маань энэ 36 сар хүртэлх тэтгэмжийг хүлээж байгаа төрийн албан хаагчдынхаа нурууг нь тэнийлгэж, тайван амрах, бүтэн нойртой хонох, чин сэтгэлээсээ зүтгэх тэр зүтгэлд нь хариу барьж, энэ тэтгэмжийг нь бүрэн дүүрэн суулгаж өгөхийг хүсэж байна.

Төсвийн байнгын хорооны хамт олондоо бас баярлалаа. Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг уншихдаа яг энэ асуудлыг дэвшүүлсэн шүү гэдгийг бол бас онцолсон. Би салбарын сайд нарыг бас гуйж байна. Хэдийгээр Төсвийн байнгын

хорооны дарга, Төсвийн ажлын хэсгийн дарга урдаа ногоон лааз барьчихсан ногооныг дараарай гэж та бүхнийг удирдаж байгаа ч гэсэн төрийн албан хаагчдаа бодож, улаан кнопоо дарах эсвэл кноподоо хүрэхгүй байхыг хүсэж байна. Мянга мянган төрийн албан хаагчид яг одоо бас та бүхнийг харж байгаа шүү гэдгийг бас хэлмээр байна. Ингээд Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн ажлын хэсэг, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжихгүй байж, төрийн албан хаагчдынхаа энэхүү тэтгэмжийн асуудлыг бас бүрэн дүүрэн суулгаж өгөхийг хүсэж байна.

Ер нь бол төрд ажиллаж байгаа хүмүүс нэн ялангуяа бид нар бол хуулиа бас мөрддөг байх ёстой. Тэгэхээр хуулиар хүлээсэн үүргээ ч гэсэн бид нар хүлээх ёстой. Та бидний өмнөөс иргэдтэйгээ шууд нүүр тулж байдаг, та бидний буруутай, зөрүүтэй, гэнэтийн шийдвэрүүдийг хэрэгжүүлж байдаг төрийн албан хаагчдаа бол бид нар бас талархах сэтгэлээ илэрхийлэх ёстой. Ийм учраас ядаж энэ хуулиар олгох ёстой үүргээ хүлээж, төрийн албанд зүтгэснийх нь төлөө тэтгэвэртээ гарахад нь тэтгэмжийг нь бүрэн дүүрэн өгөх хэрэгтэй.

Хэрэвзээ дэмжигдэхгүй байлаа гэхэд хаана хандах вэ. Би тэтгэмжээ авч чадахгүй байна гэдэг асуудлыг олон хүн асууж байгаа. Магадгүй иргэний шүүх, захиргааны хэргийн шүүхэд хандаад бас энэ эрх ашгаа хамгаалуулах боломж нэг талдаа бас байна та бүхэнд. Тэгээд гишүүд минь кноподоо хүрэхгүй байж энэхүү саналыг дэмжиж өгөхийг хүсэж байна.

Санал гаргасан л гишүүн тайлбар хэлж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань яг чин сэтгэлээсээ өөрсдийнхөөрөө бас саналаа өгөөсэй гэж хүсэж байна. Тэгэхээр энэ дээр ажлын хэсгийн зүгээс бол хамаагүй бид нар зохицуулчихна гэдэг хариултыг бол хэлнэ. Тийм юм боломгүй гэдгийг та бүхэн бас сэтгэлдээ мэдэж байгаа байх. Ийм учраас энэ саналыг бас босгож өгөхийг хүсэж байна.

**Б.Пүрэвдорж:** Хэлээгүй, асуулт асуугаагүй. Үг хэлээгүй. Ажлын хэсгийн дарга Хассуурийн Ганхуяг гишүүн үг хэлнэ. Сайнзориг гишүүн яг энэ асуудал дээр цөөнх болсон гэдгийг бас дурдахыг хүсэж байна.

**Х.Ганхуяг:** Энэ саналыг яагаад Байнгын хороо, ажлын хэсгээс дэмжээгүй вэ гэхээр ерөөсөө л хойтон жил 10 хүн тэтгэвэрт гарах байсан бол 5-ыг нь гаргаад, 5-ыг нь 2027 ондоо л гараач гэдэг асуудал байхгүй юу. Энэ мөнгө төгрөгтэй холбоотой ямар ч асуудал байхгүй. Төсөв мөнгө нь хүрэлцэхгүй байгаа болохоор ирэх жил 100 хүн гарах гэж байсан бол 50 хувь нь гарчих, 50 хувь нь 2027 онд тэтгэвэртээ гараач ээ л гэсэн үг. Ямар нэгэн хүний мөнгийг хассан асуудал ерөөсөө байхгүй. Баярлалаа гишүүд ээ. 36 сараар тэтгэвэрт гарч байгаа хүмүүст нь бүтэн өгнө гэсэн үг. Одоо энийг хүлээгээд авчих юм бол тэнцэл маань өөрөө алдагдчихна. Тэгээд манай нөгөө яриад байгаа төсвийн хүрээ алдагдаад явчих юм байгаа юм. Баярлалаа гишүүд ээ.

**Б.Пүрэвдорж:** Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 53 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601000257 төслийн кодтой “Төрийн албаны шинэчлэлийн хүрээнд төрийн бүтээмжийн нэгдсэн мэдээллийн систем /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг

3,506.6 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 1,578.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 60 гишүүн дэмжиж, санал хураалт дэмжигдлээ\_

7.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн багцын урсгал зардал дахь төрийн шагнал одон медалийн зардлыг 1000000842,9 сая төгрөгөөр бууруулах санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хороо уг саналыг дэмжээгүй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 56 гишүүн дэмжиж, 56 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Багш, эмч нарын цалин, тэтгэврээс бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцад туссан урсгал зардлыг 0.8 хувиар буюу 170.0 тэрбум төгрөгөөр бууруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг тэтгэх мөнгөн тэтгэмжийн 397.5 мянган төгрөг, Асаргааны тэтгэмжийн 302.5 мянган төгрөг, Нийгмийн халамжийн тэтгэврийн 397.5 мянган төгрөгийг тус тус 24 хувиар нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, С.Эрдэнэбат. Ж.Баясгалан гишүүн уг хэлнэ.

Багш, эмч нарын цалин, тэтгэврээс бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцад туссан урсгал зардлыг 0.8 хувиар буюу 170.0 тэрбум төгрөгөөр бууруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг тэтгэх мөнгөн тэтгэмжийн 397.5 мянган төгрөг, Асаргааны тэтгэмжийн 302.5 мянган төгрөг, Нийгмийн халамжийн тэтгэврийн 397.5 мянган төгрөгийг тус тус 24 хувиар нэмэгдүүлэх.

**Ж.Баясгалан:** Бүх Их Хурлын гишүүддээ, сайд нартаа энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд сая гадаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд ирээд, 100 гаруй хүмүүс жагслаа. Тэгээд энэ хүмүүс маань жагсаж чадаагүйгээс болоод бид нарын эрх ашиг хөндөгдөөд байгаа юм бол жагсъя гэж ирсэн. Саранчулуун гишүүн бид 2 гараад тэр жагсаалыг болиуллаа. Яагаад. Яагаад вэ гэвэл хөгжлийн бэрхшээлтэй, ялангуяа нуруу нугасны гэмтэлтэй хүмүүсийн хувьд даарах юм бол бөөрний өгсөх замын халдвар гэж өвчнөөр өвддөг. Энэ нь үхэлд хүргэх хамгийн том шалтгаануудынх нь 1 байдаг. Тийм болохоор энэ хүмүүс хэдийгээр өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалж байгаа, бусдын эрх ашгийн төлөө зогсож байгаа ч гэсэн тэр хүмүүсийг зогсоох тийм эрх, зогсоох зүрх, зогсоох сэтгэл бид нарт байсангүй. Энэ хүмүүс 302 мянган төгрөгөөр амьдрах гэж өнөөдөр зовж зүдэрч яваа. Бид нар байшин барилгыг ... манайхан чимээгүй байж байгаарай. Бид нар байшин барилга 1 жил хүлээлээ гээд өвдөхгүй шүү дээ. Зам 1 жил хүлээлээ гээд үхэхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй, өвчтэй хүмүүс 1 жилийг хүлээж чадахгүй бурхныхаа оронд явах хэчнээн хүн байгаа вэ. Өдөр болгон, шөнө болгон өвдөж байгаа тэр хүмүүсийн өвчнийг бид нар яаж нимгэлэх вэ. Үгүй ээ, бид нар энэ 30-хан хувийг нэмчихье л дээ. Бид нар тэр хүмүүст ердөө 100 мянган төгрөг л нэмэх гээд байгаа шүү дээ. Ингэж нэмээд ядуурлын түвшнээс л чүү ай гарах юм байгаа юм. Хүн байна даа. Энэ чинь бүгдээрээ тийм биз дээ. Бид нар чинь эхээс төрсөн. Бид нар энэ зовлонгоор бүгдээрээ туулаагүй ч гэсэн эргэн тойронд байгаа хүмүүсээ харж байгаа шүү дээ. Хүн гэдэг утгаа бодоод энэ дээр нам хамаагүй, энэ дээр Баясгалан хамаагүй, хэн нэгэн хамаагүй хүн гэдэг энэ чанараа бодоод бүгдээрээ хүнлэг байхын тулд кноподоо битгий хүрээч ээ гишүүд ээ.

Бүх тойрогт, бүх дүүрэгт, бүх Монгол Улс даяар хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа. Анхнаасаа яриад явсан. Тэгээд Төсвийн байнгын хороо дээр ажлын хэсэг дээр өөр саналууд нэмэгдээд ороод ирсэн шүү дээ. Шударгаар хэлэхэд. Тэгэхэд яагаад энэ хүний амьтай холбоотой санал нэмэгдэж орж ирэхгүй байгаа юм бэ. Энэ чинь хүний амь шүү дээ.

Бид нар ингээд өчнөөн хоног энэ төсвийг хойшлууллаа. Энэ хооронд энэ хүмүүс өвдсөөр л байгаа. Та нараас гуйж байна. Би хүнээс юм гуйх дургүй. Гэхдээ би та нараас бүгдээс чинь гуйж байна. Хүний хувьд, хүн ёсны хувьд бүгдээс чинь гуйж байна. Тэгээд энэ саналд бүгдээрээ гар хүрэхгүй, энэ саналыг бүгдээрээ улайруулаад өгөөч ээ. Битгий энийг хүн ёсоо гаргаад энэ санал дээр бүгдээрээ гар битгий хүрээрэй гэж гуйж байна шүү. Хичээнгүйлэн хүсэж байна.

**Б.Пүрэвдорж:** Тайлбар хэрэггүй. Гишүүд өөрсдийнхөөрөө. Энэ чинь 170-ыг хаанаас олох вэ. Хассуурийн Ганхуяг гишүүн.

**Х.Ганхуяг:** Үгүй ээ, яах вэ яг энэ төсөв батлагдаад дуусах мөчид би бол ер нь Монгол Улсын хамгийн их үзэн ядагдах хүмүүсийн нэг болох юм шиг байна. Тэгээд бүгдээрээ гарч ирээд л цалин нэм, тэтгэвэр нэм. Үгүй ээ, тэгээд чадах чинээгээрээ бид нар төсвөөсөө 1 их наяд гаргаад, цалин, тэтгэвэр нэмж байгаа. Гэхдээ энэ чинь жил жилээрээ л явна шүү дээ. Ирэх жил бид нар боловсролынхон дээр арай илүү анхаарал тавьчихъя. Эмч нартаа ирэх жил бол 15 хувиар нэмж байна. Тэтгэмжтэй холбоотой зардлууд юу гэдэг юм 8,6 хувиар нэмж байгаа.

Би Баясгалан гишүүнтэй уулзсан. Тэгээд яах вэ, цөмөөрөө 2027 онд арай илүү анхаарчихъя. Яг дараа жил ингээд бүх юм нэгэн зэрэг ингээд ачаалал яахаар улсын төсөл үнэхээр дийлэхгүй байна. Би үнэнийг л хэлэхээс өөр арга алга. Тийм болохоор би та бүхнээс гишүүдээсээ гуйж байна. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Байнгын хороонд энэ яг аль аль зардлаас, яаж яаж гаргах юм. Энэ асуудлаараа гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна.

Гүйцээн боловсруулах бас энэ чинь арай өөр томьёолол, нэртэй болчихсон юм. Арай өөр байна. Санал хураалт явагдсан учраас гүйцээн боловсрох чиглэл өгөх боломжгүй байна. Санал хураалтаас өмнө гүйцээн боловсруулах чиглэл авах ёстой. Учрал сайд санал гаргая. Горимын санал.

**Н.Учрал:** Сая би уг нь дэмжсэн юм. Тэгсэн чинь дарагдсангүй. Тэгээд горимын санал гаргая.

**Б.Пүрэвдорж:** Энэ мэдээж хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ бид нар дэмжиж байгаа. Тийм тийм учраас ер нь бол байнгын хороон дээр бас тодорхой хэмжээгээр дундын хувилбарыг гаргаж ирье. Яг ингээд шууд бүгдийг нь нэмээд явах бас энэ төсөв дээр хүндрэл авчирна. Энэ чинь цаанаа бас дахиад тэр урсгал зардал, бүх зүйл чинь яг энэ төрийн үйл ажиллагааг гацаагүй явуулах ийм хөрөнгө мөнгө байдаг. Тийм учраас тэр мөнгөнөөс шууд ингээд тооцоололгүй аваад шийднэ гэдэг чинь бас нэг талдаа болохгүй. Тийм учраас би энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ нэг талдаа шийдэх ёстой. Тэгэхийн тулд бас өм цөм шууд ингэж шийдэхгүйгээр тодорхой хэмжээгээр дундын хувилбарыг хоорондоо ярилцаж гаргаж ир гэж та бүхэнд бас хэлэх байна.

Тэгээд Учрал гишүүний гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 57 гишүүн дэмжиж, 57 хувиар санал хүчингүй боллоо.

Хассуурийн Ганхуяг гишүүн үг хэлье.

**Х.Ганхуяг:** Гүйцээн боловсруулах чиглэл авъя дарга аа. Тэгэхгүй бол энэ эх үүсвэрийг нь бас харах хэрэгтэй юм байна. Төсвийн тэнцэл дээр ямаршуу хэмжээнд дарамт ачаалал ирэхийг нь харахгүй бол болохгүй байна дарга аа. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг бас тодорхой хэмжээгээр харалзах ёстой шүү. Баясгалан гишүүний саналыг заавал харгалзах ёстой шүү гэдгийг бас хэлье. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

9.Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.9 дэх “Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас” гэснийг “Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон нийгмийн даатгалын шимтгэл” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй. Гаргасан саналтайгаа холбогдуулан Ж.Золжаргал гишүүн үг хэлнэ.

**Ж.Золжаргал:** Энэ саналыг би татаж авна. Тэгэхдээ тайлбар хэлье. Нийгмийн даатгалын санд төрөөс даах, төрөөс төлөх тийм хэсэг байгаа. Нөгөө малчид, цэргийн албан хаагчид гэх мэтчилэн. Тэгэхээр энийг төрөөс төлөх, төлбөр хийх үүргийг татаас гэж нэрлэж байгаа нь 1 дүгээрт агуулгын хувьд буруу. 2 дугаарт төлбөр нийгмийн даатгалын сангаас мөнгө аваагүй, харин ч бид нар төлж байгаа гэдэг тайлбарт үндэслээд төсвийн алдагдлыг Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын дараа үлдсэн эерэг орлогоор нөхөж ирсэн байгаа юм. Их олон жил. Тэгээд энэ Төсвийн тухай хууль дээр зарлагын эх үүсвэрийг бичих ёстой. Тэр нь энэ хууль дээр ороогүй байгаа. Энэ задаргаа, тооцоон дээрээс харахад Нийгмийн даатгалын сангийн зарлагын дараа үлдсэн эерэг дүн 1,2 их наяд, Эрүүл мэндийн сангийнх болохоор 0,4 их наяд, нийлээд 1,6 их наяд төгрөг. 1,6 их наяд төгрөгийг татаас хэлбэрээр нөхөөгүй. Энэ нь төрөөс төлөх ёстой төлбөрөө төлөөд үлдсэн ашиг гэх юм уу эерэг тоо. Тэгэхээр энийг төсвийн алдагдлыг нөхөөд тусгай шаардлагын 2 хувиас бага алдагдал байх ёстой гэдэгтээ хүргүүлчихсэн байгаа. Тэгэхээр энийг цаашдаа суурь өөрчлөлтөө хийхгүй бол Нийгмийн даатгалын сан нь арвижихгүй олон жил ингэж явж ирсэн байгаа юм гэж үзэж байгаа. Тэгээд үүнтэй холбоотой 3 санал байгаа. Энэ саналуудаа татаж авна. Үүний эх үүсвэр бол угаасаа байхгүй. Ер нь хойшдоо энэ асуудлыг нэг тийш нь болгохгүй бол 10 жилд гэхэд 1,5 их наяд төгрөгөөр Нийгмийн даатгалын сан арвижих боломжтой байсан байна лээ гэсэн тооцоо гарсан. Саналаа татаж авъя.

**Б.Пүрэвдорж:** Золжаргал гишүүн саналаа татлаа.

10.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2003400730 төслийн кодтой “Төв халх” дуулалт жүжгийн театр /Дундговь, Сайнцагаан сум/, хэрэгжих хугацаа 2011-2028 он, төсөвт өртөг 32,990.1 сая төгрөг, санхүүжих дүн 8,671.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 543.7 сая төгрөгөөр бууруулж, УТ2403100365 төслийн кодтой “Спорт заалны барилга /Дундговь, Луус сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 1,366.3 сая төгрөг, санхүүжих дүн 255.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 543.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат, Г.Ганбаатар. Гаргасан саналтайгаа холбогдуулан Г.Ганбаатар гишүүн үг хэлнэ.

**Г.Ганбаатар:** Өдрийн мэнд гишүүд ээ. Юуны өмнө түрүүнд бас говийн бүсэд хэрэгжих Орхон голоос Онги голыг тэтгэх, Онгиос говийн Балгасын улаан нуурыг тэтгэх төслийг дэмжиж өгсөнд талархаж байгаагаа бас хэлье.

Энэ төсөл, энэ зарчмын зөрүүтэй санал бол Дундговийн Сайнцагаан сум дээр хэрэгжих төслөөс дотроо гүйж байгаа юм. Эх үүсвэр бол шаардлагагүй. Луус сум дээр ирж байгаа спортын барилгаа дуусгачихъя. 543,7 сая төгрөг байгаа юм. Дундговь аймгийн төсөл хооронд нь гүйлгэж байгаа юм шүү. Өөр эх үүсвэр шаардлагагүй учраас дэмжиж өгнө үү гэж хүсье. Тэр “Төв халх” дуулалт бүжгийн театр нь 2011 онд эхэлсэн. Мөнгө тавиад яваад байдаг дуусахгүй. Энэ хэзээ дуусахыг мэдэхгүй. Түүнээс 543 сая төгрөгийг нь тэр Луус суманд байгаа спортын барилгаа ядаж дуусгая л гэж байгаа юм. Олон юм зэрэг эхлээд дуусахгүй байснаас нэгийгээ ч гэсэн дуусгая гэсэн санаа шүү. Тэгээд дэмжээд өгөөрэй. Кноподоо битгий хүрээрэй. Нэмэлт эх үүсвэр мөнгө хэрэггүй төсөл шүү.

**Б.Пүрэвдорж:** Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 22 гишүүн санал өгч, 22 хувиар дэмжигдсэнгүй.

11.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808718 төслийн кодтой, “Багануур тойрог авто зам, 14.4 км /Багануур хот/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 43,321.9 сая төгрөг, санхүүжих дүн 14,656.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, төрийн өмчит Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуульд шаардлагатай урсгал зардлыг санхүүжүүлэхээр Боловсролын сайдын урсгал зардлыг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн. Санал хураалт. Санал чинь дэмжигдчихлээ. Чи өөрөө тэгээд өөрийнхөө эсрэг санал өгчихлөө. Тэгэхдээ босчихлоо. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдсэнгүй. Тийм учраас Сандаг-Очир гишүүний энэ санал дэмжигдсэн гэсэн үг.

12.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардлыг 3,199.0 сая төгрөгөөр бууруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багц дахь Урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийг 3,199.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, С.Зулпхар, Д.Рэгдэл, С.Эрдэнэбат. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн.

Энэ дээр гүйцээн боловсруулах чиглэлийг түрүүн авсан билүү. Хассуурийн Ганхуяг гишүүн үг хэлнэ.

**Х.Ганхуяг:** Энэ 12 дугаар санал буюу Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардлыг 3.199-өөр бууруулж, нөгөө талдаа 3.199-өөр нэмэгдүүлэх энэ саналыг гүйцээн боловсруулах чиглэл авчихъя дарга аа. Түрүүний саналуудтайгаа нэгтгээд.

**Б.Пүрэвдорж:** Энэ чинь арай өөрөөр хэлэх ёстой байгаад байгаа юм. 3 дахь хэлэлцүүлэгт дахин хэлэлцүүлэх чиглэл өгч Төсвийн байнгын хороонд гурав дугаар хэлэлцүүлэгт буцаахаар.

13.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601300966 төслийн кодтой “Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 67,119.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв”-ийн үйлдвэрлэлийн түүхий эд, материалын зардалд 1,100.0 сая төгрөг, мөн төслийн 2 дугаар хавсралтад “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв”-ийн автомашин, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 700.0 сая сая төгрөг”, “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв”-ийн өргөтгөлийн барилгын засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 200.0 сая сая төгрөг”, гэсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун. Саранчулуун гишүүн үг хэлье.

**О.Саранчулуун:** Оройн мэнд гишүүд ээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөдөлмөр эрхлэлтээр дэмжихийн тулд, 1 дүгээрт сургалт байх ёстой, 2 дугаарт яг ажил хийж байгаа тэр аж ахуйн нэгжийг нь дэмжих ёстой, 3 дугаарт аж ахуйн нэгж, байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авах хэрэгтэй, 4 дүгээрт орчны тоног төхөөрөмжөөр тохиргоог нь хийх ёстой гэсэн ийм 4 сайн жишиг олон улсад ч гэсэн байна.

Манай улсад бас энэ чиглэлээр ажлууд хийгдэж байгаагийн нэг нь бол олон жил явж байгаа. Тэгэхдээ одоо яг энэ бүрэн утгаараа ажиллах гээд байгаа энэ ажил маань бол хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төв байгаа юм. Энэ төвийг өнгөрсөн жил Энх-Амгалан сайд байхдаа 3,5 тэрбумын төсвөөр дэмжлэг үзүүлж, тоног төхөөрөмж, өргөтгөл дээр нь улсын төсвөөс төлөвлөж ажилласан юм байна лээ. Гэтэл өнгөрсөн жил төсвийн гүйцэтгэгч сонгон шалгараагүйн улмаас мөнгө нь татагдаад, тэр үйлдвэр болон энэ ажлынх нь эргэлтийн хөрөнгө зогсчихсон байгаад байгаа. Тэгээд энэ үйлдвэрт нь яг ажил хийж байгаа харааны бэрхшээлтэй хүмүүс 82 ажилтнаас 60 гаруй нь харааны бэрхшээлтэй хүмүүс байдаг юм байна. Тэгэхээр бид нар бүх газар харааны бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авч чадахгүй ч гэсэн өөрсдөө ажиллаж байгаа үйлдвэрийн дэмжлэг үзүүлээч ээ гэдэг ийм төсөл байгаа. Тэгээд энэ төслийн дүн дээр эх үүсвэрийг нь болохоор бид нар энэ НҮБ-ын Коп-ын зардлаас гэж Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр ярьж, дэмжигдсэн байгаа. Тэгэхдээ та бүхэн бас энэ дээр нөгөө Аубакир сайд болон Байгаль орчны сайд бас өөр өөрийн нөгөө шийдлүүдээ хэлэлцүүлгийн үеэр ярьж байсан. Тэгэхдээ одоо давхар нэг сонсоод, нэмэлт тайлбар сонсоод тэгээд саналаа татаж авах уу, хэдүүлээ энэ дээр яах вэ гэдгийг бас сонсмоор байна. Дэгээрээ тайлбарлаж болохгүй. Тэгвэл энэ төслийг маань дэмжиж өгнө үү. Түрүүн бол бид нар өөр маш том, олон хүний асуудал дээр саналаа дэмжсэнгүй шүү дээ. Одоо энэ бол 2 тэрбум төгрөгийн асуудлаар, 2 тэрбум төгрөгөөр бид нар харааны бэрхшээлтэй 300 гаруй хүнтэй холбоотой асуудлыг шийдэх гэж байна. Энэ дээр кноподоо хүрэхгүй байж дэмжиж өгнө үү.

**Б.Пүрэвдорж:** Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Эрдэнэболд гишүүн горимын санал гаргана.

**С.Эрдэнэболд:** Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ, өнөөдөр 11 дүгээр сарын 7-ны өдөр. Тэгэхээр үндсэндээ 11 сарын 10-нд бид нар төсвөө батлах учиртай. Тэгээд сүүлийн сар гаруй хугацаанд бол энэ төсөв тойрсон асуудал гацаанд орчихсон байгаа. Тэгэхээр бид нар энэ удаагийн хурлыг цаг сунгаад, энэ цаасан дээр байгаа санал хураалтыг дуустал нь үргэлжлүүлэх саналыг гаргамаар байна.

Улс орны ажил шийдвэр гаргах түвшинд маш их гацаж байгаа учраас энэ ажлыг явуулах хэрэгтэй байна. Тийм учраас бүгдээрээ бас тэсвэр тэвчээр гаргаад, санал хураалтыг дуустал нь үргэлжлүүлъя. Хэдэн цаг болтол ч хамаагүй үргэлжлүүлъя гэсэн горимын саналыг дэмжиж өгнө үү гэж санал гаргаж байна.

**Б.Пүрэвдорж:** Эрдэнэболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 57 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ. Санал дэмжигдсэнтэй холбоотойгоор түрүүчийн гаргасан 13 дугаар саналаар санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 58 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Уучлаарай. Одоо. Хүчингүй 13 дугаар саналыг хүчингүй болгох Эрдэнэболд гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 62 гишүүн дэмжиж, санал хураалт хүчингүй боллоо.

Харин түрүүн хүчингүй болгоогүй байсан байна. Тэгээд 13 дугаар Саранчулуун гишүүний гаргасан саналаар санал хураалтыг явуулъя. Цаашаа явъя. Саранчулуун гишүүний санал дэмжигдлээ гэсэн үг.

14.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400522 төслийн кодтой “Спорт заалны барилга /Ховд, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,103.4 сая төгрөг, санхүүжих дүн 1,396.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Хүний хөгжил, нийгмийн бодлогын бодлогын байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хорооноос дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүнээс 60 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүний тэр 8 дугаар санал буюу Баясгалан гишүүний санал болон 10 дугаар саналыг хамтатгаад 3 дугаар хэлэлцүүлэгт Төсвийн байнгын хороо гүйцээн боловсруулахаар чиглэл өгч байгаа шүү. 8, 12 юм байна шүү.

15.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400239 төслийн кодтой “Спорт заалны барилга /Хөвсгөл, Түнэл сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,156.8 сая төгрөг, санхүүжих дүн 970.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 гишүүн оролцож, 63 гишүүн дэмжиж, 63 хувиар санал дэмжигдлээ.

О.Алтангэрэл гишүүн ирцээс гарах хүсэлтээ ирж хэлсэн. Ирцээс гаргая.

16.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400052 төслийн кодтой “Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 6,728.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,018.7 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 99 гишүүнээс 61 гишүүнд дэмжиж, санал дэмжигдлээ.

17.Төслийн Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808719 төслийн кодтой “Баруун-Урт-Бичигт чиглэлийн хатуу хучилттай авто зам /Зүүн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2028 онд, төсөвт өртөг 319,998.9 сая төгрөг, санхүүжих дүн 23,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын багцын урсгал зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн. Ц.Мөнхтуяа гишүүн саналтайгаа холбоотой үг хэлнэ.

**Ц.Мөнхтуяа:** Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Манай гишүүд суугаарай, Дамдинням сайд суугаарай. Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-ийг амилуулах ийм санал оруулж байгаа юм. Ер нь бол амьгүй хуулиуд маш их байгаа манай Монголд. Тийм ээ. Тэгэхээр зүгээр нэг тунхаг төдий орон сууцжуулна гээд л орхичихдог. Яаж, хэрхэн яаж орон сууцжуулах вэ, хэдэн төгрөгийн төсөв тавих вэ гэдэг нь тодорхойгүй байдаг.

Тийм учраас миний хувьд Боловсролын ерөнхий хуулийн 13.4-ийг амь оруулах гэж багш ажилтанд орон сууцын дэмжлэг төрөөс үзүүлнэ гээд нэг заалт байгаа юм. Тэгэхээр энэ дээр би бас өөрсдөө мөнгөө ол гэсэн учраас хэд хэдэн замаас шүүж байгаад санал оруулж байгаа юм. Тэгээд манай Их Хурлын гишүүд бүгдээрээ л багш нартаа хайртай, боловсролдоо хайртай гэдэг. Тэгээд миний энэ саналуудыг бас дэмжээд өгөөрэй гэдгийг бас хүсэж байна. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Ганхуяг гишүүн үг хэлнэ.

**Х.Ганхуяг:** Энэ дээр бас бид нар нэлээн судалсан. Засгийн газраас ажлын хэсэг гарчихсан байгаа юм байна лээ. Яг багш, эмнэлгийн салбарын би бас танд уулзаад хэлсэн шүү дээ. Тэгээд ажлын хэсэг гарчихсан явж байгаа юм байна лээ. Ямар ч байсан 5-10 мянган айлын орон сууцыг яг ипотекийн зориулалтаар боловсролын салбар, эрүүл мэндийн салбарт яаж гаргаж болох вэ гэдэг судалгаа хийгээд явж байгаа юм байна лээ. Та дараа нь Бат-Амгалан сайдтай уулзаад явчхаарай. Тэгэхгүй бол одоо яг төлөвлөчихсөн юмнаас ингээд татчихаар нөгөө бусад ажлууд нь бүгдээрээ уначихаар байгаа. Та болж татчихвал их сайн байна. Тэгээд үнэхээрийн татаж болохооргүй бол цөмөөрөө ногооныг дараад л явахаас л өөр аргагүй болчхоод байна л даа.

**Б.Пүрэвдорж:** Тэгээд Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 99 гишүүнээс 59 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

18.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808512 төслийн кодтой “Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 59.2 км /Хойд бүс/”, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 101,370.6 сая төгрөг, санхүүжих дүн 19,710.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 99 гишүүнээс 57 гишүүн дэмжиж, санал хураалт дэмжигдлээ.

19.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808289 төслийн кодтой “Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62,56 км /Төвийн бүс/”, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 117,450.0 сая төгрөг, санхүүжих дүн 25,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” Гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 98 гишүүн оролцож, 98 гишүүнээс 50 гишүүн дэмжиж, 51 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2403100360 төслийн кодтой “Спорт заалны барилга /Архангай, Эрдэнэбулган сум, Булганхангай хороолол/” хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 1,101.0 сая төгрөг, санхүүжих дүн 577.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, “Заяын Гэгээний хүрээ хийдийн цогцолборын” дээврийн засвар /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 577.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал. Санал гаргасантай холбоотой Б.Хэрлэн гишүүн үг хэлнэ.

**Б.Хэрлэн:** Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Тэгэхээр энэ Зая гэгээний цогцолборт хамаардаг хийдийн дээврийн засварын ажилд зориулж би спорт заалны төсвийг шилжүүлж, энэ жилдээ засварт нь хэрэглэхээр энэ зарчмын зөрүүтэй санал гаргасан. Энэ саналаа татаж байна.

Гэхдээ энд нэг юмыг хэлэх хэрэгтэй гэж би бодож байна. Өнөөдөр соёлын биет өвийг сэргээн засварлах, хамгаалах, хадгалах тухайд ерөнхийдөө төрийн бодлого үнэхээрийн үгүйлэгдэж байгаа юм байна. Өнөөдөр Архангай аймгийн төвд бол бараг 10 ширхэг спорт заал байгаа. 25 мянган хүн амтай аймгийн төвд 10 спорт заал гэдэг бол дэндүү ихэдчихсэн л дээ. Тэгээд тэрний 1 заалных нь төсвийг уг нь шилжүүлэх ийм хүсэлт гаргасан боловч энэ зарчмын зөрүүтэй санал маань дэмжигдээгүй байгаа. Тэгээд энэ саналаа татаж байна. Татчихъя.

**Б.Пүрэвдорж:** Хэрлэн гишүүн саналаа татлаа.

21.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808162 төслийн кодтой “Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66 км, /Баруун бүс/” хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 150,926.6 сая төгрөг, санхүүжих дүн 23,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 98 гишүүн оролцож, 57 гишүүн дэмжиж, 58,2 хувиар санал дэмжигдлээ.

22.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой “Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179,7 км, /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, 186,000.6 сая төгрөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 98 гишүүнээс 51 гишүүн дэмжиж, 52 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152,5 км, /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 98 гишүүнээс 58 гишүүн дэмжиж, 59,2 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 170,899.7 сая төгрөг, санхүүжих дүн 25,635.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 98 гишүүнээс 57 гишүүн дэмжиж, 58,2 хувиар санал дэмжигдлээ.

25.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102800331 төслийн кодтой “Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 124.5 км /Дорнод/, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг 185,514.9 сая төгрөг, санхүүжих дүн 45,921.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 98 гишүүнээс 58 гишүүн дэмжиж, 59,2 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800805 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 37 км /Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 106,868.4 сая төгрөг, санхүүжих дүн 20,036.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 98 гишүүнээс 54 гишүүн дэмжиж, 55,1 хувиар санал дэмжигдлээ.

Мөнхтуяа гишүүний санал явж байгаа шүү дээ.

27.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808473 төслийн кодтой “Даланзадгад-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар, 156 км /Говийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 157,864.8 сая төгрөг, санхүүжих дүн 40,460.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

28, 29, 30, 31 дүгээр саналуудыг Амгаланбаатарын Ганбаатар гишүүн гаргасан байна. Гаргасан саналтайгаа холбоотойгоор Ганбаатар үг хэлнэ.

**А.Ганбаатар:** Өдрийн мэнд ээ. Тэгээд гол нь төсөв хугацаандаа батлагдах шаардлагатай байгаа учраас зарим оруулсан саналаа татъя. Гэхдээ яах вэ Ерөнхий сайд бол хүн бол мега төсөл гэж хэлсэн шүү. Тэгээд энэ хүнтэй холбоотой, хүний хөгжилтэй жижигхэн төсвүүд нь унаад байгаа шүү. Тэгээд 28, 30 31 дүгээр саналаа татлаа. 29-ийг гүйцээн боловсруулах чиглэл өгөөрэй. Тэр дээр тусгай олимп гээд энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт наадам спортоор хичээллэх ганц тэрбум төгрөг байдаг юм. Тэрийг нь гүйцээн боловсруулах дээр оруулж ирээд өгөхгүй бол

бас болохгүй байх. 3-ыг нь татаад, 1-ийг нь гүйцээн боловсруулах ийм саналтай байна.

29.Төслийн Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/” хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, Тусгай олимпын урсгал зардлыг санхүүжүүлэхээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын урсгал зардлыг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Энэ саналыг гүйцээн боловсруулах чиг чиглэл өгч, Төсвийн байнгын хороонд гуравдугаар хэлэлцүүлэгт шилжүүлж байна. Өөрөө хүссэн шүү дээ.

Байнгын хорооны ажлын хэсгийн дарга, Байнгын хорооны дарга 29 дүгээр саналтай холбоотойгоор.

**Х.Ганхуяг:** Таны саяын уншсан саналыг гүйцээн боловсруулахаар дарга аа чиглэл авчихъя. 29, 30.

**Б.Пүрэвдорж:** Төсвийн төсвийн байнгын хороонд гурав дугаар хэлэлцүүлэгт гүйцээн боловсруулах чиглэлээр шилжүүлж байна. 28, 30, 31 дүгээр саналыг А.Ганбаатар гишүүн татсан учраас санал хураалт явахгүй.

32.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152,5 км, /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 436.0 сая төгрөгөөр бууруулж, УТ201500780 төслийн кодтой “Соёлын төвийн барилга, /Хэнтий, Батширээт сум/”, хэрэгжих хугацаа 2021-2026 он, төсөвт өртөг 4,020.8 сая төгрөг, санхүүжих дүн 1,272.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 436.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн. Гаргасан саналтай холбоотойгоор М.Ганхүлэг гишүүн үг хэлнэ.

**М.Ганхүлэг:** Гишүүддээ оройн мэндийг хүргэе. 32, 33 дугаар санал давхардсан тул татах саналтай байна. 32, 33.

**Б.Пүрэвдорж:** Яагаад гэвэл түрүүн Батширээт сумын юу дэмжигдчихсэн. Гаргасан саналаа татсан тул санал хураалт явахгүй. 32, 33 хоёулаа тээ. Хоёуланг нь санал хураалт явахгүйгээр Ганхүлэг гишүүн саналаа татсан.

34.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400522 төслийн кодтой “Спорт заалны барилга /Ховд, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,103.4 сая төгрөг, санхүүжих дүн 1,396.6 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг, УТ2603400239 төслийн кодтой “Спорт заалны барилга /Хөвсгөл, Түнэл сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,156.8 сая төгрөг, санхүүжих дүн 970.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, УТ2603400052 төслийн кодтой “Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 6,728.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,018.7 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг тус тус хасаж, энэ эх үүсвэрээр “Хүүхдийн төв номын сан, Хүүхэлдэйн театрын барилга”, төсөвт

өртөг 60,768.8 сая төгрөг, санхүүжих дүн 4,385.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн. Гаргасан саналтай холбоотойгоор Ганхүлэг гишүүн үг хэлнэ.

**М.Ганхүлэг:** Гишүүддээ дахин оройн мэндийг хүргэе. Хүүхдийн байгууллагын 100 жилийн ой болж байгаа. Хүүхэд рүүгээ чиглэсэн төсөл, арга хэмжээнүүд дээр тодорхой бас санаачилгуудыг бас гаргасан. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороогоороо бид бүхэн бас салбарынхантай төсвийн асуудлаар бас уулзсан. Зураг, төсвийн бүх шаардлага юмнуудаа бол хангачихсан. Хүүхэлдэйн театр, Хүүхдийн номын сангийн энэ төсвийн ажлыг бас манай Байнгын хорооны гишүүдэд бас уламжилж, санал болгосон. Үндсэндээ хаанаас авах вэ гэхээр Соёлын төвийн барилгууд байгаа. Аудитын болон бусад хавсралт саналууд дээр зураг төсвийн болон тодорхой бичиг баримтын бүрдлийн хувьд бол бас дутуу байгаа ийм 3 төслийг хасаад, Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театрын нэгдсэн цогцолборыг байгуулах энэ саналыг бас оруулж байгаа. Тийм учраас Байнгын хорооны гишүүд маань бол дэмжсэн. Төсвийн байнгын хороо дээр бас дэмжигдээгүй байгаа энэ саналыг та бүхэн маань бас кноподоо хүрэхгүй байж дэмжиж өгөхийг хүсье.

**Б.Пүрэвдорж:** Уг нь манай Ховд аймгийн Буянт сум ирэх жил 100 жилийн ойтой. 1 спорт заалны барилга тавьсан чинь хэчнээн олон хүн хасна гэж санал гаргаж байна. Манай Ховд аймагт 1 л сум 100 жилийн ойтой. Үгүй ээ, энэ чинь гишүүд нэг нэгнийхээ юм руу халдаж болохгүй шүү дээ бас. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт 98 гишүүнээс 56 гишүүн дэмжиж, 57,1 хувиар санал дэмжигдлээ.

35.Боловсрол, Эрүүл мэндийн сайдаас бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын цалингаас бусад урсгал зардлыг 196.0 тэрбум төгрөгөөр бууруулж 6-12 дугаар ангийн нийт сурагчдын үдийн хоол хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 196.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн. Хассуурийн Ганхуяг гишүүн үг хэлнэ.

**Х.Ганхуяг:** Энийг Сэдээ дарга аа, бас тантай уулзаж ярилцана шүү дээ. Энэ саналыг бүгдээрээ бас дараа нь 2027 оноос ч юм уу боломж юу байх нь вэ судалъя. 2026 онд бол бүх юмаа ер нь шавхчхаад байна дарга аа. Тэгэхээр энийг цөмөөрөө ногоон кнопоо дараад 2027 он руу хойшлуулъя. Саналтайгаа холбоотойгоор Сэддорж гишүүн үг хэлнэ.

**Р.Сэддорж:** Оройн мэнд хүргэе. Энэ бол 196 уг нь биш юм байгаа юм. Тэгээд Дорноговь аймагт сайхан жишээ байна. Жишээ нь 2500 төгрөгөөр хүүхдийнхээ хоолыг шийддэг юм байна. 6-12 дугаар ангийн хүүхдийн хоолыг. Тэгэнгүүтээ 900 төгрөгийг нь төсөвтөө суулгаад, 1600 төгрөгийг нь эцэг эхээс нь гаргуулаад ингээд шийдэж байгаа юм байна. Тэгэхээр ядаж 50 хувийг нь юм уу 1/3-ийг нь оруулаад явахгүй бол цаана чинь улсын сургуулийн хүүхдүүд бол өдрийн цайгүй, өдрийн цайгаа уух гэж хичээлдээ ирдэг. Тэгээд 6-12 дугаар ангийн хүүхдүүд цайгүй учраас сурах, боловсрох тэр бүх юманд нь гацаатай л ийм л юмнууд болж байна. Тэгээд сургууль даяар 1-5 дугаар ангийн хүүхдүүд цай уугаад байдаг. 6-12 дугаар ангийнхан нь цай уудаггүй. Тэгээд дэлхийн 180-аад орон энэ цайны асуудлаа шийдчихсэн юм байна. Тэгээд бид нар бол шийдээгүй орны тоонд нь орж байгаа юм

байна. Тэгэхээр энэ 800 гаруй мянган хүүхэд байгаа тэд нараас 60 хувь нь бол 1-5 дугаар ангийн үдийн цайндаа хамрагддаг юм байна. Үлдэж байгаа 40 хувь нь бол хамрагддаггүй юм байна. Энийг яаж шийдэх вэ.

Хүүхдийн хоол тэжээлийн тухай Улсын Их Хурлын хууль 2019 онд батлагдсан юм байна. Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол, цайг шийдэх тухай хууль. Тэгээд энэ хуулийн хэрэгжилт хангагдахгүй байна. Засгийн газар энийг анхааралдаа аваач ээ. Тэгээд 2027 онд яг олон түмэнд хэлнэ шүү дээ. Энэ чинь бид нарын яриа бол бүгд л явж байгаа. 2027 онд яг суулгах уу. Эсвэл энэ төсвийн тодотгол эд нараар Улсын Их Хурлын тогтоол дээр тусгаж өгөх үү Пүрэвдорж дарга аа. Улсын Их Хурлын тогтоол дээр төсвийн тодотгол эд нар хийвэл энийг 50 хувийг нь эцэг эхээс нь, 50 хувийг нь тодотголоор шийдье гэсэн ийм саналуудыг хэлье.

**Б.Пүрэвдорж:** Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Татчихсан юм уу. Татаагүй юм уу. Ганхуяг гишүүн.

**Х.Ганхуяг:** Гүйцээн боловсруулах чиглэл авдаг л байх даа бодвол.

**Б.Пүрэвдорж:** Байнгын хорооны даргын саналын дагуу Төсвийн байнгын хороонд төсвийн гурав дугаар хэлэлцүүлэгт гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

36.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 4,800.00 сая төгрөгөөр бууруулж, Залуучуудын хөтөлбөрийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцын урсгал зардлыг 4,800.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн. Ганхүлэг гишүүн үг хэлнэ.

**М.Ганхүлэг:** Монгол Улс Залуучуудын яамтай болоод Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам гэдэг нэршилтэй болсон юм. Тэгээд залуучуудын чиг үүрэг бүхий үйл ажиллагаа ер нь явуулна. Залуучууд руугаа анхаарна гээд. Тэгээд өнгөрсөн онд боловсролыг дэмжих жилийн өмнө энэ оныг үндсэндээ 2026 оныг Залуучуудыг дэмжих жил болгоё энэ тэр гэдэг асуудлууд Монгол Улсын Засгийн газар дээр нэлээн яригдаж байсан. Тэгээд та бид ер нь бол энэ залуучуудын оронд амьдарч байгаа, залуучуудаа дэмжинэ гэж бас зөндөө бас ярьж хэлдэг. Гэхдээ яг бодит байдал дээр энэ жил 2026 оны төсөв дээр залуучуудын үйл ажиллагааг дэмжих чиглэл дээр 200 сая төгрөг тавьсан бид нар. Тэгээд бас энэ чиглэлээр анхаарна, салбарын яам тодорхой чиглэл гаргаад ажиллана гэсэн хэр нь бодит байдал дээр бид нар бас нэг ийм байдлаар бас хандаж болохгүй байгаа юм. Залуучуудын дэд хороо бас байгуулагдсан. Дэд хорооны даргын хувьд бас тодорхой ажил, үйл ажиллагаа явуулах чиглэлүүдээр энэ бас яамдын тодорхой ажил хариуцсан төрийн албан хаагчидтай уулзаж ярилцахад цаашид үйл ажиллагаа явуулахад үнэхээр хүндрэлтэй байна. Залуучууд руу чиглэсэн залуу малчдын хөтөлбөрүүдийг зохион байгуулах гэсэн бид нар санал өгсөн. Залуучуудын сэтгэл зүй, энэ хорт зуршилтай холбогдолтой ажлын байр, гэр бүл рүү чиглэсэн энэ олон асуудлууд руу чиглэсэн тодорхой сургалт, хөгжлийн арга хэмжээнүүд, олон талт үйл

ажиллагаануудыг бид нар 21 аймаг, 9 дүүрэгт явуулахад 200 сая төгрөгийн төсөв тавьсан нь бас үнэхээр бас анхаарахгүй бол болохгүй асуудал байна гэдэг ийм зүйлийг бас тавьсан.

Тийм учраас залуучууд руу чиглэсэн 12 төсөл хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх энэхүү санхүүжилтийг бас гаргаж өгөөч ээ гэж үндсэндээ хүсэж энэ саналыг оруулсан байгаа. Тэгээд та бүхэн маань бас кноподоо хүрэхгүй байж, дэмжиж өгөхийг хүсье.

**Б.Пүрэвдорж:** Ганхүлэг гишүүн үг хэллээ. Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энхнасан гишүүн горимын санал гаргая.

**Л.Энхнасан:** Горимын санал гаргая. Сая төхөөрөмж ажилласангүй гацчихлаа. Энэ саналыг хүчингүй болгоод, дахиад санал хураалт явуулж өгнө үү.

**Б.Пүрэвдорж:** Энхнасан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Мөнхбаясгалан гишүүн горимын санал гаргая.

**Л.Мөнхбаясгалан:** Энэ төхөөрөмж гацаад байна шүү дээ дарга аа. Тэгэхээр саяын саналыг хүчингүй болгож өгнө үү.

**Б.Пүрэвдорж:** Мөнхбаясгалан гишүүн дэмжсэн байна шүү дээ. Болормаа гишүүн горимын санал гаргая.

**Х.Болормаа:** Гишүүддээ оройн мэнд хүргэе. Уучлаарай. Миний техник ажиллаагүй учраас горимын санал гаргаж байна. Саяын саналыг дахин хураалгаж өгнө үү гэж горимын санал гаргаж байна. Хүчингүй болгож, дахин хураалгаж өгнө үү.

**Б.Пүрэвдорж:** Болормаа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 98 гишүүнээс 57 гишүүн дэмжиж, горимын санал дэмжигдлээ. Горимын санал дэмжигдсэнтэй холбоотойгоор 36 дугаар саналын томъёоллын дагуу санал хураалт явуулъя. 98 гишүүнээс 56 гишүүн дэмжиж, санал хураалт дэмжигдлээ.

37.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601502049 төслийн кодтой “Ерөнхий боловсролын сургуулиудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 26,146.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “3 дугаар сургуулийн биеийн тамирын заалны барилга /Баян-Өлгий, Цэнгэл сум/, төсөвт өртөг ... сая төгрөг, санхүүжих дүн 1,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй саналтайгаа холбоотойгоор Бейсен гишүүн үг хэлнэ.

**Б.Бейсен:** Энэ санал давхацсан учраас татаж байна. Яагаад гэвэл төсвийн ажлын хэсэг дээр энэ давхар орчихсон байна. Тийм учраас татаж байна.

**Б.Пүрэвдорж:** Бейсен гишүүн гаргасан саналаа татаж байна. Санал хураалт явахгүй.

38.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд төсвийн алдагдлыг тодорхойлсон зүйл, заалт байхгүй байгаа нь уг хуулийн 1.1 дэх заалттай зөрчилдөж байна. Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуулийн төсөлд төсвийн алдагдлыг тодорхойлсон зүйл, заалт байхгүй байгаа тул “Төсвийн алдагдлыг тодорхойлсон зүйл, заалтыг Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагаас давсан орлогоор санхүүжүүлсэн тооцоог тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал. Саналтай холбогдуулан Золжаргал гишүүн үг хэлнэ.

**Ж.Золжаргал:** Саналыг татъя.

**Б.Пүрэвдорж:** Саналаа татлаа. Санал хураалт явахгүй.

39.Монгол Улсын 2026 оны төсвийн тооцоололд төсвийн алдагдал 1,380,000.0 сая төгрөг гэж гаргахдаа Нийгмийн даатгалын сангийн зарлагаас давсан орлого 1,281,362.7 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагаас давсан орлого 354,002.6 сая төгрөгийг ашигласан нь Нийгмийн даатгалын сангийн тухай хуулийн 12.2-д “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд нь шилжүүлэн зарцуулах, нэгтгэх, зориулалтын бусаар ашиглахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн тул тооцооллоос хасаж, төсвийн алдагдлыг 3,015,365.4 сая төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 2.9 хувьтай тэнцүүлж бодитоор тооцох замаар 1,065,11.7 сая төгрөгөөр тэнцэл сайжруулах. Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601501785, УТ2601501777, УТ2601501767 төслийн кодтой төсөл, арга хэмжээнээс бусад төслүүдийн санхүүжилтийг 2027 он болгон хойшлуулж, нийт 1,065,011.7 сая төгрөгийн буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 1.9 хувьд хүргэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй. Саналтай холбогдуулан Золжаргал гишүүн үг хэлнэ.

**Ж.Золжаргал:** Энэ 39 дүгээр саналыг бас татаж авна. Түрүүн тайлбар ярьсан. Улс орны төсөв баталсны дараа Нийгмийн даатгалын сангийн хуримтлалыг бий болгох, түүнийг төсвийн алдагдалд нөхөгдөхгүй байх энэ нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг хийх хэрэгтэй гэж үзэж байгаа.

**Б.Пүрэвдорж:** Золжаргал гишүүн саналаа татлаа.

40.Даатгалын санд төвлөрсөн орлогыг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, Орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлийг үнэлж дүгнэлт хийх, хууль эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулах, олон нийтэд сурталчлах зардалд 3,500.0 сая төгрөг, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан, эрт тэтгэвэрт гарсан ахмадуудыг асрах, сувилах, сэргээн засах зардалд 5,000.0 сая төгрөг, Олон нийтийн хяналтыг мэргэжлийн болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зардалд 1,500.0 сая төгрөгийг тус тус тусгах. Энэ эхэн дээрээ би нэг үгээ алдчихсан байна. Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан шүү. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн. Саналтай холбогдуулан гишүүн үг хэлнэ.

**С.Эрдэнэбат:** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нийт төсвийн зардлын 0,5 хувийг зарцуулах хуулийн заалттай. Гэхдээ манай төсөв бол энэ зардлыг ер нь бол тавихгүй явсаар ирсэн юм байна лээ. Тэр зардалтай

харьцуулахад энэ зардал бол өчүүхэн зардал. Хоёрдугаарх нь, энэ санд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах сангийн үлдэгдэл хөрөнгө бол хангалттай байгаа.

Тийм учраас тэндээс багахан хэмжээний мөнгийг гаргаад, энэ осол аваараас урьдчилан сэргийлэх, осол аварт өртсөн ялангуяа ахмад, хөгжлийн бэрхшээлтэй болчихсон хүмүүсийг нөхөн сэргээх засалт Ахмадын тухай хуулийн дагуу. Мөн олон нийтийн хяналтыг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх гэх мэтчилэн ийм зардлууд тавья. Тэгээд энэ талаар бол Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай бол ярилцсан. Сангаасаа бол тодорхой ийм хэмжээний зардлыг бол гаргаж болно гэдэг ийм саналыг бол ярьсан.

Тийм учраас та бүгдийг кноподоо хүрэхгүй, энэ саналыг дэмжиж өгөхийг хүсье гэдгийг хэлмээр байна. Түрүү жил би бас нэг ийм санал хэлээд, анхааруулаад байсан. Тэгээд харамсалтай нь бас манай станцууд дээр осол гараад 100-аад тэрбум төгрөгийн алдагдал хүртэл барьж байсан. Тийм учраас энэ нийтийн болзошгүй эрсдэл, осол аваараас урьдчилан сэргийлэх ажилд хөрөнгө мөнгө тавих хэрэгтэй байна. Хүн төвтэй манай парламент маань бас энэ тал дээр жоохон шинэчлэл хийх Засгийн газрын болон Их Хурлын стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт оруулсан саналууд маань санхүүжилтгүйгээс болоод ерөөсөө явж өгөхгүй байгаад байгаа юм. Тийм учраас бол сайдын багц дотроо бол угаасаа хөдөлж байгаа. Ямарваа нэгэн төсвийн бусад зардлуудыг тавих юм бол байхгүй. баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Ганхуяг дарга үг хэлнэ.

**Х.Ганхуяг:** Ер нь яг иймэрхүү саналууд маш их байгаад байгаа юм байна. Бид нар яах вэ, зүгээр юу яачихъя тэгэх үү. Саналын тоо хүрэхгүй бол гүйцээн боловсруулж болж байна. Эсвэл гүйцээн боловсруулах авчихъя даа. Тэгээд тэнд ярилцаад л үзье.

**Б.Пүрэвдорж:** Төсвийн байнгын хороонд гурав дугаар хэлэлцүүлэгт гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

41.Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 оны төсвийн жилд хэрэгжих хөрөнгө оруулалтын нийт зардал болох 3,267.3 тэрбум төгрөгийн зардлаас Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, зэвсэгт хүчин, боловсролын салбараас бусад салбарт 2026 онд шинээр баригдах барилга байгууламжийн хөрөнгө оруулалтыг тэвчих замаар нийт 301,066.7 сая төгрөгийн санхүүжилтийг хэмнэж, энэ эх үүсвэрээр Эрүүл мэндийн даатгалын сангийн төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцан төлөх даатгуулагчдын шимтгэлийн орлого 431,181.3 сая төгрөгийг 301,066.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 732,848.3 сая төгрөг болгох. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн. Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёолол томьёоллоор санал хураалт явуулъя. 98 гишүүнээс 52 гишүүн дэмжиж, 53,1 хувиар санал дэмжигдлээ.

42 дугаар саналыг Эрдэнэбат гишүүн гаргасан байна. Эрдэнэбат гишүүн гаргасан саналтай холбоотойгоор үг хэлнэ.

**С.Эрдэнэбат:** Багш нарын, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ахмад эд нар гээд төсвийн анхны хэлэлцүүлэгд энэ саналыг тавьсан юм. Тэгээд ба багш нарын маань асуудал бас энэ саналын дийлэнх нь бол байгаа. Тийм учраас энэ саналыг бол шийдэгдсэн учраас багш нарын асуудал хэлэлцээрт хүрээд шийдэгдсэн учраас, мөн эрүүл мэнд дээр бол би дахиад тодорхой төсөв хэлэлцүүлэг, санал явж байгаа учраас гүйцээн болуулах саналыг аваад, энэ саналаа татъя гэж бодож байна. Гүйцээн боловсруулах аваад.

**Б.Пүрэвдорж:** Эрдэнэбат гишүүн нэмж 1 минут.

**С.Эрдэнэбат:** Үгүй ээ, энэ санал дотор зарим нь дэмжигдээд явчихсан саналууд байгаа. Зарим нь бол үлдчихсэн саналууд байгаа учраас гүйцээн боловсруулах байдлаар бол заримыг нь татаад авчихъя. Тэгэхээр эргээд орвол гэдэг тийм нөхцөлөөр би түрүүн ярьсан шүү дээ.

**Б.Пүрэвдорж:** 42.Төслийн Төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан дараах зарим төсөл, арга хэмжээг хасаж болон санхүүжих дүнг бууруулж нийт 411,069.3 сая төгрөгийн 60 хувиар Боловсролын салбарын урсгал зардлыг, 20 хувиар Эрүүл мэндийн салбарын урсгал зардлыг, ахмад настны тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэлд 20 хувийг тусгах Үүнд:

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808085 төслийн кодтой “Аргалант-Баянцогт сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 26.7 км, төмөрбетон гүүр, 36 у/м /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 44,729.5 сая төгрөг, санхүүжих дүн 15,166.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808211 төслийн кодтой “Баруунбүрэн-Амарбаясгалант хийд чиглэлийн хатуу хучилттай авто зам, 33.4 км /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 39,472.1 сая төгрөг, санхүүжих дүн 15,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808162 төслийн кодтой “Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66 км /Баруун бүс/, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 150,926.6 сая төгрөг, санхүүжих дүн 23,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804339 төслийн кодтой “Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай авто зам, 54.18 км /Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 66,368.6 сая төгрөг, санхүүжих дүн 42,904.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804371 төслийн кодтой “Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 44,988.8 сая төгрөг, санхүүжих дүн 30,499.8 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804360 төслийн кодтой “Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замаас Хужирт сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 43.3 км /Өвөрхангай, Хужирт сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 69,037.3 сая төгрөг, санхүүжих дүн 38,576.2 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804406 төслийн кодтой “Ховд-Дөргөн сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 40.7 км /Ховд, Дөргөн сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 49,854.2 сая төгрөг, санхүүжих дүн 25,159.7 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804412 төслийн кодтой “Хэрлэн голын төмөрбетон гүүр, 265 у/м, хатуу хучилттай авто зам, 14.2 км /Хэнтий, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 49,920.1 сая төгрөг, санхүүжих дүн 21,065.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102800632 төслийн кодтой “Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай авто зам, 122.4 км /Төв, Угтаалцайдам, Цээл, Заамар сум/, хэрэгжих хугацаа 2022-2026 он, төсөвт өртөг 182,566.3 сая төгрөг, санхүүжих дүн 80,101.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800805 төслийн кодтой “Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 37 км /Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 106,868.4 сая төгрөг, санхүүжих дүн 20,036.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 170,899.7 сая төгрөг, санхүүжих дүн 25,635.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800907 төслийн кодтой “Хэрлэн голын төмөрбетон гүүр, 217.6 у/м /Дорнод, Хэрлэн сум/ хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 22,845.1 сая төгрөг, санхүүжих дүн 6,053.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400215 төслийн кодтой “Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/ хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 8,396.8 сая төгрөг, санхүүжих дүн 3,778.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2403100364 төслийн кодтой “Өвлийн спортын ордны барилга /Дархан-Уул, Дархан сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 22,438.0 сая төгрөг, санхүүжих дүн 6,423.7 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102900758 төслийн кодтой “Гандангийн дэнж” шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв, барилгын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг 23,484.9 сая төгрөг, санхүүжих дүн 6,130.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601900178 төслийн кодтой “Үр тариа хадгалах агуулах /Увс/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 9,000.0 сая төгрөг, санхүүжих 4,050.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602001067 төслийн кодтой “Хавдар судлалын Үндэсний төв-II” цогцолборын А, С блокийн барилга, гадна шугам сүлжээ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 234,232.9 сая төгрөг, санхүүжих 40,523.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 20,261.0 сая төгрөгөөр бууруулах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602001014 төслийн кодтой “Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Үндэсний оношилгоо, эмчилгээний төв барилгын их засвар /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 4,383.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 2,191.5 сая төгрөгөөр тус тус бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй.

10 минут чуулганы хуралдааныг завсарлуулъя.

### ЗАВСАРЛАГА

**Б.Пүрэвдорж:** 10 минутын завсарлага дууслаа. Гишүүд танхимдаа орж ирээрэй.

Даваасүрэн гишүүн, Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан дэмжигдсэн саналууд байгаа. Тэр дэмжигдсэн санал дээр 2 дээр нь аймгаа тодорхой болгож бичээгүй юм байна. Бичилгүйгээр санал хураалтаа явуулсан юм байна. Тийм учраас Хөвсгөл аймаг гэж тодотгож бичих ёстой юм байна шүү. Энийг Төсвийн байнгын хороонд гурав дугаар хэлэлцүүлэгт шийдвэрлэхээр шилжүүлж байна.

Саяын 42 дугаар саналтай холбоотойгоор завсарлах хугацаанд ажлын хэсгийн дарга болон Эрдэнэбат нар ярилцсан байна. Тэгээд Эрдэнэбат гишүүний микрофоныг өгье.

**С.Эрдэнэбат:** Боловсролын салбарынхан маань ерөнхийдөө хэлэлцээр хийгээд, тэр эх үүсвэрийг бол шийдсэн. Ихэнх энэ саяын миний санал хураалгах гэж байсан дотор бол угаасаа хасагдаж байгаа саналууд бас нэлээн юмнууд бол орж ирж байгаа юм байна. Эрүүл мэнд болон ахмад гэх мэтчилэн зүйлүүд дээр бол тодорхой эх үүсвэрүүдийг бол ярилцаад шийдэх талаар бол ярилцсан. Тийм учраас би энэ саналаа бол татчихъя. Оруулбал ер нь бол унах юм шиг байна.

**Б.Пүрэвдорж:** Саналаа татлаа.

43.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601900239 төслийн кодтой “Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн паркийн арьс шир, боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 9,438.3 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 2,831.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Ирцээ сайжруулаарай. Санал хураалтад бэлтгэе. Үүдэнд байгаа гишүүд ороорой. Батлут ороогүй. Сая саналыг уншиж танилцуулсан. 43 дугаар санал.

Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 51 гишүүн дэмжиж, 53,7 хувиар санал дэмжигдлээ.

44.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601900237 төслийн кодтой Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн паркийн цахилгаан хангамж, гол шугам сүлжээний ажил /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,953.6 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 1,779.2 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 57 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

45.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400215 төслийн кодтой “Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 8,396.8 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 3,778.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 56 гишүүн дэмжиж, 58,9 хувиар санал дэмжигдлээ.

46.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 641.6 сая төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр “Шихихутаг нууц товчоо түүхэн аялал жуулчлалын цогцолборын барилга”-ын нэмэлт төсөв /Хэнтий, Норовлин сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн 641.6 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат. Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 58 гишүүн дэмжиж, 61,1 хувиар санал дэмжигдлээ.

47.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 238.6 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Их хуралдай цогцолборын барилга”-ын гадна тохижилтын нэмэлт ажил, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн 238.6 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат. Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 58 гишүүн дэмжиж, 61,1 хувиар санал дэмжигдлээ.

48.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа

2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 685.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Монголын нууц товчоо цогцолборын барилга”-ын гадна тохижилтын нэмэлт ажил, /Хэнтий, Дэлгэрхаан сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн 685.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат. Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 52 гишүүн дэмжиж, 54,7 хувиар санал дэмжигдлээ.

49.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606700119 төслийн кодтой “Төрийн цахим үйлчилгээ, хиймэл оюун, их өгөгдлийн суурь дэд бүтцийн тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 19,445.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 700.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын төсвийн багцад “Өсвөрийн инженерүүдийн инновацын төвийн барилгын ТЭЗҮ, зураг төсөв”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 700.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал. Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй. Саналтайгаа холбогдуулан Золжаргал гишүүн үг хэлнэ.

**Ж.Золжаргал:** Энэ манай Төсвийн байнгын хорооны гишүүд ер нь дэмжихээр санал байсан юм. Тэгээд уржигдар нөгөө хурал явж байгаад дараалал үсрээд цагийн дараа орж танилцуулъя даа гэж бодож байсан 10 минутын дараа болчихоод нөгөө тайлбараа хийж амжаагүй. Тайлбар нь болохоор ер нь угаасаа нөгөө салбарынхаа төлөвлөлтөд орсон ажлыг өөрийнх нь сайдын эрхлэх тогтчихсон зардлаас нь багахан хэмжээг чиглүүлээд, нийлбэр дүн дээр бол ямар ч өөрчлөлт байхгүй. Тэгээд энэ Залуучуудын инновацыг дэмжих төвийн зураг төсөв ТЭЗҮ-ийн ажил энэ салбарын удирдлагууд бас дэмжиж байгаа. Ойлголцсон ийм зүйл байгаа. Тэгээд яах вэ, жижигхэн ийм юмыг ирээдүйд энэ залуусын ... тайлбараа зогсоочих юм уу. Залуучууд бас их ирээдүйд хэрэгтэй. Босгож өгнө үү. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 7,4 хувиар санал дэмжигдсэнгүй.

50.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 700.0 сая төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцад “Нийслэлийн түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд унадаг дугуй, скүүтэрийн гүүрэн тусгай зам барих ТЭЗҮ, зураг төсөв, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 700.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн. Золжаргал гишүүн үг хэлнэ.

**Ж.Золжаргал:** Энэ мөн ижил шалтгаанаар Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн боловч Төсвийн байнгын хороо дээр тайлбар хийж чадаагүй. Уначихсан зүйл байгаа. Зураг, төсөв, үндэслэлийн төсвийн үнийн дүнд багтаад тэндээс нь 40-

0,7-г яг энэ чиглэлд зориулж гэж тусад нь гаргаж бичсэн юм. Тэгээд нөгөө скүүтэр дугуйнууд чинь явж чаддаггүй, хүмүүс мөргөлдөөд уурлаад байдаг. Өргөн ийм замтай дундаа бүстэй энэ Энхтайваны өргөн чөлөө, Энэбишийн гудамж энэ тэр гэсэн тийм талбай дээр автомашин, явган хүн, унадаг дугуй хэнд ч саад болохгүйгээр хөнгөхөн структуртай ийм зүйлийн судалгаа зургийг ядаж хийчихье. Дараа дараа жилдээ тэгээд хөрөнгө оруулалтаа хаанаас яаж зохицуулах вэ гэдэг нь явна биз дээ. Ийм зүйл байгаа. Тэгээд энийг ойлголцсон салбарын удирдлагуудтай нь бол ойлголцсон байгаа. Та бүхэн босгож, дэмжиж өгнө үү. Улаан товчоо дарж өгөөрэй гэж хүсье.

**Б.Пүрэвдорж:** Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байна шүү. 95 гишүүнээс 26 гишүүн дэмжиж, 27,4 хувиар санал дэмжигдсэнгүй.

51.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Хүнсний болон үрийн буудайн нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, эргэлтийн хөрөнгийн сантай болгоход зориулсан татаасыг 23,000.0 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 58 гишүүн дэмжиж, 61,1 хувиар санал дэмжигдлээ.

52.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд инновац нэвтрүүлэх, тухайн жилд худалдан авсан техникт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх, бордоог хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, бэлчээрийн ашиглалт, хамгааллыг сайжруулах, отрын нөөц бэлчээр, усан хангамж, өвс тэжээлийн нөөц, хангамжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулсан татаасыг 24,300.0 сая төгрөгөөр бууруулах. Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 59 гишүүн дэмжиж, 62,1 хувиар санал дэмжигдлээ.

53.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Атрын 4 дүгээр аянд зориулсан Хүнсний ногооны урамшууллын татаасыг 11,500.0 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 57 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

54.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь цагаан алт хөтөлбөрийн ноосны урамшууллын татаасыг 15,600.0 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 58 гишүүн дэмжиж, 61,1 хувиар санал дэмжигдлээ.

55.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь арьс ширний урамшууллын татаасыг 6,200.0 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 55 гишүүн дэмжиж, 57,9 хувиар санал дэмжигдлээ.

56.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Цагаан алт хөтөлбөрийн “Бусад арга хэмжээ”-нд тусгагдсан санхүүжилтийг 600.0 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 57 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

57.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн хүүгийн дэмжлэгийг 608,900.0 сая төгрөгөөр бууруулах. Ийм мөнгө байхгүй дээ. Ийм мөнгө байхгүй учраас ийм саналын томьёоллыг яагаад оруулж байгаа юм. Ийм мөнгө ерөөсөө төсөв дээр байхгүй шүү дээ. Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн хүүгийн дэмжлэг гэж байхгүй. Тэгээд хураах уу. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 58 гишүүн дэмжиж 61,1 хувиар санал дэмжигдсэнгүй.

58.Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багц дахь Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт хөтөлбөрийн зардлыг 856.3 сая төгрөгөөр бууруулж, Говийг усжуулах судалгааны нэгжийн урсгал зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, Ц.Мөнхбат, Г.Ганбаатар, Р.Эрдэнэбүрэн. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэдэг. Мөнхбаясгалан гишүүн саналтай холбоотой үг хэлэх үү. Санал хураалтыг явуулъя. 95 гишүүнээс 14 гишүүн дэмжиж, 14,7 хувиар санал дэмжигдсэнгүй. Энэ санал нь төсөвт тусгагдаж байна гэсэн үг.

59.Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багц дахь Агаар орчныг бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийг 78,530.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, энэ эх үүсвэрийг дараах төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжих дүнг бууруулж болон төслөөс хасаж тооцох. Үүнд:

-Төслийн 2 дугаар хавсралтын УТ2600100054 төслийн кодтой, “Ерөнхийлөгчийн Тамгын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 500.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээг хасах;

- УТ2600200018 төслийн кодтой, “Улсын Их Хурлын Тамгын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 3,637.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2601200838 төслийн кодтой “Гадаадын иргэн харьяатын газрын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,365.4 сая төгрөг, санхүүжих дүн 1,064.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга төсөл арга хэмжээг хасах;

- УТ2601200355 төслийн кодтой “Цагдаагийн газрын барилга /Булган, Булган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 5,353.6 сая төгрөг, санхүүжих дүн 1,606.1 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээг хасах;

- УТ2601501976 төслийн кодтой “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн эмнэлгийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 9,237.6 сая төгрөг, санхүүжих дүн 2,771.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2601501953 төслийн кодтой “Хангайн бүсийн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цогцолборын гадна тохижилт /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,126.8 сая төгрөг, санхүүжих дүн 1,407.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2602800888 төслийн кодтой “Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Зүүн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 60,156.2 сая төгрөг, санхүүжих дүн 18,046.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2602800636 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архустын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 170,899.7 сая төгрөг, санхүүжих дүн 25,635.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2603400215 төслийн кодтой “Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 8,396.8 сая төгрөг, санхүүжих дүн 3,778.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2603400522 төслийн кодтой “Спорт заалын барилга /Ховд, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,103.4 сая төгрөг, санхүүжих дүн 1,396.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2603400239 төслийн кодтой “Спорт заалын барилга /Хөвсгөл, Түнэл сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,156.8 сая төгрөг, санхүүжих дүн 970.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2603400052 төслийн кодтой “Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 6,728.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,018.7 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2602900939 төслийн кодтой “Инженерийн шугам сүлжээ /Ховд, Дарви сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,792.7 сая төгрөг, санхүүжих дүн 1,256.8 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2602900037 төслийн кодтой “Үерийн хамгаалалтын барилга, байгууламж, далан суваг /Хөвсгөл, Их-Уул сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,652.9 сая төгрөг, санхүүжих дүн 1,643.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2602900572 төслийн кодтой “Үерийн хамгаалалтын далангийн 2, 3 дугаар ээлжийн байгууламж /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 10,407.8 сая төгрөг” санхүүжих дүн 3,122.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2602900674 төслийн кодтой “Үерийн хамгаалалтын далангийн байгууламж, 5 км /Завхан, Улиастай сум, Жаргалант, Чигэстэй баг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 7,829.8 сая төгрөг, санхүүжих дүн 3,523.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2606700065 төслийн кодтой “Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 14,368.5 сая төгрөг, санхүүжих дүн 4,310.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2603300016 төслийн кодтой “Авлигатай тэмцэх газрын барилгын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 239.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах;

- УТ2601300963 төслийн кодтой “Цаг уурын харуулын барилга /Баян-Өлгий, Булган, Увс, Баянхонгор, Дундговь, Хөвсгөл, Архангай, Говь-Алтай, Завхан, Ховд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 388.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах;

УТ2601501638 төслийн кодтой “Дотуур байрын барилга, 75 ор /Сүхбаатар, Халзан сум, 1 дүгээр баг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,695.5 сая төгрөг, санхүүжих дүн 1,213.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц. Гаргасан саналтай холбогдуулан Лувсанжамц гишүүн үг хэлнэ.

**Г.Лувсанжамц:** Оройн мэнд хүргэе. Энд сууж байгаа бүх гишүүд, сайд нараас асууя. Та бүхэнд утааг шийдэх хүсэл, зориг байна уу. Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйл Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ. 16.2.Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасан байдаг.

Гэтэл өнөөдөр бид хамгаалж чадахгүйгээр барахгүй сүүлийн 20 жил энэ утааны асуудлыг шийдэж чадахгүй байна. Энд сууж байгаа зарим гишүүд энэ хугацаанд 20 жил гишүүн хийж байсан шүү. Өнөөдөр Улаанбаатар хот дэлхийн хамгийн бохирдолтой хотуудын нэг болсон. Дархан, Эрдэнэт хотууд, зарим аймгийн төвүүд ч гэсэн утаатай болсныг тойргийн гишүүд маань сайн мэдэж байгаа. Өнөөдрийг хүртэл төрөөс авч хэрэгжүүлж байгаа олон арга хэмжээнүүд хангалттай үр дүнд хүрэхгүй байгааг бид бүгдээрээ харж байна. Өнгөрсөн хугацаанд нийтдээ 5,6 их наяд төгрөгийг үргүй зарцуулсан. Бид шатааж дуусдаг зүйлд төсөв зарцуулаад үр дүнд хүрэхгүй байгаагаа өнөөдөр хүлээн зөвшөөрмөөр байна. Одоогоос л энэ арга барилыг өөрчлөөд бид нар хэрэглээг биш, хэмнэлтийг дэмждэг

энэ тогтолцоо руу шилжих хэрэгтэй байна. Тэгэхгүй бол бид нар дахиад 20 жил агаарын бохирдлоосоо салж чадахгүй. Утааг бууруулах цорын ганц шийдэл бол байшин гэрээ стандартын дагуу зөв дулаалаад, яндангаа буулгах өөр гарц бид нарт байхгүй. Дулаалгыг дэмжих нь зуух, нүүрс зэргийг дэмжихээс илүү үр дүнтэй. Хамгийн гол нь төсвийн зардлыг хэмнэх ач холбогдолтой гэдгийг та бүхнийг ойлгоосой гэж хүсэж байна.

2028 он гэхэд нийслэлийн утааг 50 хувиар бууруулах, 2032 он гэхэд улсаараа бид нар утаагүй болох судалгаа шийдлийг өнгөрсөн хаврын чуулганаар би та бүхэнд танилцуулсан. 9 сард Занданшатар Ерөнхий сайдад бас танилцуулсан. Энэ бодлогыг дэмжинэ гэсэн боловч төсөвт 1 ч төгрөг суугаагүй байна. Тиймээс Үндэсний аудитын газраас гаргасан дүгнэлтэд төсвийн шаардлага хангаагүй, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусаагүй, ТЭЗҮ байхгүй. Эдгээр төсөл арга хэмжээг хасаад, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын Агаар орчныг бууруулах үндэсний хөтөлбөрийн санхүүжилтэд нэмж өгөхийг хүсэж байна. Энэ санал маань 2026 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд та бүхний дэмжлэгтэйгээр туссан, хуульд нийцэж байгаа гэдгийг онцолж хэлмээр байна. Та бүхэн кноподоо хүрэхгүй байж дэмжиж өгөхийг хүсэж байна.

**Б.Пүрэвдорж:** Үүдэнд байгаа хүмүүсээ гялс оруулчих. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 50 гишүүн дэмжиж, санал хураалт дэмжигдсэн байна. Байнгын хорооны санал дэмжигдсэн байна.

60.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2101101137 төслийн кодтой “Гадаадын зээл тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 546,556.0 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 121,721.0 сая төгрөг “гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,390.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны “Тарифт цалингийн жишиг шинэчлэн батлах тухай” 95 дугаар тушаал батлагдсантай холбогдуулан үүссэн зардлын зөрүү 1,111.0 сая төгрөг, Монгол Улсын дээд шүүхийн байр /Хангарди/-ны гадна фасадыг дулаалах, засварлах ажлыг гүйцэтгэх 279.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 48 гишүүн дэмжиж, 50.5 хувиар санал дэмжигдлээ.

61.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 170,899.7 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 25,635.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,798.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Прокурорын газрын цахим хавтаст хэрэг, зөрчлийн системийн сервер, тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг 4,798.0 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 4,798.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал. Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 52 гишүүн дэмжиж, 54,7 хувиар санал дэмжигдлээ.

62.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой “Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 216,979.6 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 12,631.3 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Дүүргийн шүүхийн нэгдсэн барилга /Хан-Уул цогцолбор/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 75,254.5 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 28,663.5 сая” төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 12,631.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар. Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй. Өөрийнх нь байнгын хороо дэмжээгүй байна шүү дээ. Тэгээд Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

63.Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын урсгал зардлыг 300.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж. Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй. Тэгэхээр энэ 2 жилийн өмнө ойролцоогоор 18 тэрбум төгрөгийн зардалтай байсан. Өөрөөр хэлбэл ийм байгууллага яг өнөөдрийн байдлаар бол 800 орчим сая төгрөг бол болж буурсан байгаа. Тэгэхээр нөгөө нөхөн олговорууд олгогдохгүй байгаа.

Тэгэхдээ ирэх жил бол хэд хэдэн их нөхөн олговорууд бий. Тийм учраас энэ саналыг гаргасан. Тэгэхээр та бүхнийг дэмжээд, энэ 300 сая төгрөгийг дэмжээд өгчхөөрэй гэж хүсэж байна. Баярлалаа. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 19 гишүүн дэмжиж, 20 хувиар санал дэмжигдсэнгүй.

64.Боловсрол, эрүүл мэнд болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбараас бусад салбарын урсгал зардлыг 15 хувиар бууруулж энэ эх үүсвэрээр ахмад настны тэтгэврийг 10% дээр нэмэх 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг 567 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Өргөдлийн байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 95 гишүүнээс 52 гишүүн дэмжиж, 54,7 хувиар санал дэмжигдлээ.

65.Бүх төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардлыг 2 хувь буюу 770.0 тэрбум төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудын цалинг 50 хувиар нэмэхээр тооцож Эрүүл мэндийн сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганма. Өргөдлийн байнгын хороо дэмжсэн санал. Саналтайгаа холбогдуулан Ганмаа гишүүн үг хэлнэ.

**Д.Ганмаа:** Баярлалаа. Оройн мэнд хүргэе. 770 тэрбум их мөнгө юм шиг сонсогдож байгаа байх. Тэгэхдээ энэ бол эмч, эмнэлгийн ажилчдын 50 хүртэлх хувьд нэмэгдэх цалин. Эмч, эмнэлгийн ажилчдыг бид нар зөвхөн цар тахлын үед санаж болохгүй, цөмөөрөө ковидыг санацгаая. Хэн гэр орноо, үр хүүхдээ, бүх юмаа мартаад, амь нас эрүүл мэндээ бодохгүйгээр тэнд очиж өвчтөнүүдийг сахиж байсан билээ. Яагаад бид нар энэ хүмүүсийг байлгах ёстой билээ. Төр 770 тэрбумыг эмч, эмнэлгийн ажилчдын 50 хувийг ерөөсөө ч харамлах ёсгүй гэж үзэж байна. Яагаад харамлах ёсгүй гэж үзэж байгаа вэ гэхээр энэ сумын бусад хөрөнгө оруулалтуудыг би таван 7 хоногийн өмнөөс эхлээд ярьж байгаа. Эдгээр мөнгийг оруулаад ирэх

боломж байдаг гэдгийг бид нар сая Төсвийн байнгын хороо, ажлын хэсгээс бэлээхэн харлаа. Бид хэд энэ мөнгийг нэмэхгүйгээр цаашаа үргэлжлүүлээд явах юм бол дараагийн 7 хоногийн 4 дэх өдөр эмч, эмнэлгийн ажилчид ажил хаяна гэдгээ мэдэгдчихсэн байгаа. Ажил хаяхдаа тэд нар тангарагтай уягдаад зайлшгүй шаардлагатай үйлчилгээгээ үзүүлээд хаях боловч энэ Засгийн газар анх удаа эмч, эмнэлгийн ажилчдыг хаясан. Тэрнээс болж хүмүүсийн амь нас, эрүүл мэнд эрсэдсэн тохиолдолд энэ Засгийн газар, энэ салбарын сайдад хар толбо болж үлдэнэ шүү гэдгийг би энд анхааруулмаар байна. 1 дүгээрт.

2 дугаарт төрийн үйлчилгээ гэдэг салбарт эмч, эмнэлгийн ажилчдыг оруулснаар бид нар өөрсдөө тогтолцоог нь ингэсэн. Үүнийх нь үр дагавар нь, эднийх нь эрсдэл нь яагаад эмч, эмнэлгийн ажилчдад өөрсдөд нь буух ёстой юм бэ. Энийг бид нар хүлээн зөвшөөрөх огт боломжгүй. Хэрвээ энэ засаг үнэхээр ажил хийе гэж бодож байгаа бол энэ цалингийн асуудлын 50-хан хувийг нь нэмээд, энэ асуудлыг шийдээд, эмч, эмнэлгийн ажилчдыг иргэдээ эрсдэлээс хамгаалах хэрэгтэй. Иргэдийг эрүүл мэндтэй байхын тулд, аж амьдрал нь зүгээр байхын тулд, эрсдэлийг нь бууруулахын тулд зайлшгүй энийг дэмжих шаардлагатай. Энэ дээр зайлшгүй кноподоо хүрэхгүй байж дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Мэндсайхан гишүүн горимын санал гаргана.

**3.Мэндсайхан:** Сая санал хураалт дээр техник гацаад болсонгүй. Санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хурааж өгнө үү.

**Б.Пүрэвдорж:** Бадамсүрэн гишүүн горимын санал гаргая. Мэндсайхан гишүүн ирцээсээ гарчихсан байсан байна. Дэлгэрсайхан гишүүн горимын санал гаргана.

**Б.Дэлгэрсайхан:** Кноп ажилласангүй 1 дүгээрт. 2 дугаарт би дэмжсэн санал өгсөн шүү дээ. Тэгээд болсонгүй. Дахиж хураалгах уу. Хүчингүй болгож, дахиж хураалгаж өгөөч.

**Б.Пүрэвдорж:** Дэлгэрсайхан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 51 гишүүн дэмжиж, 53,1 хувиар санал дэмжигдлээ.

Санал дэмжигдсэнтэй холбоотойгоор 65 дугаар саналыг түрүүн уншиж танилцуулсан. Санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 50 гишүүн дэмжиж, 50 10-ны 1 хувиар санал дэмжигдлээ.

66.Боловсролын салбарын урсгал зардлыг 350.0 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн салбарын урсгал зардлыг 114.4 тэрбум төгрөг, Ахмад настны тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдүүлэхэд 100.0 тэрбум төгрөг, нийт 564.4 тэрбум төгрөгийг дараах төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг бууруулж .... энэ татсан санал байна шүү.

Тэгэхээр энэ дээр тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэхэд 100 тэрбум төгрөг гээд бичсэн байна. Тэгэхээр энэ ахмад настны тэтгэврийн асуудлаар би өнгөрсөн 4 жилийн туршид тууштай ажилласан. Тэгээд энэ хүрээндээ Тэтгэврийг индексжүүлэх тухай хуулийг өргөн барьж, өнгөрсөн жилийн төсвийн хуультай миний тэтгэврийг индексжүүлэх хууль хамтатган хэлэлцэгдэж батлагдаж, үүний үр дүнд жил болгон инфляц хэдэн хувьтай байна. Тэр хувиар тэтгэвэр нэмэгдэх энэ хууль хэрэгжиж

эхэлж байгаа. Өнгөрсөн жил хэдийгээр 10 орчим хувийн инфляцтай байсан ч гэсэн Засгийн газар 6 хувиар тэтгэвэр нэмсэн. Энэ жил ер нь бол оны эцсээр бол 10.3 хувийн инфляцтай гарах ёстой. Гэвч Засгийн газар энэ инфляцыг 8,6 хувь гэж тооцож, энэ жил яг энэ тэтгэврийг индексжүүлэх өргөн барьсан хуулийн минь дагуу нийтдээ 690 тэрбум төгрөгөөр ахмадуудын тэтгэвэр нэмэгдэж байгаа. Тийм учраас ер нь бол Их Хурлын гишүүд тэтгэврийг 1 сая 500 мянга болгоё гээд л янз янзын юм ярих юм. Тэгсэн мөртөө үр дүн байхгүй. Харин үүний оронд тэтгэврийг индексжүүлэх хууль бол жил болгон хэрэгжээд явдаг. Үүний үр дүнд ахмадуудын тэтгэвэр жил болгон нэмэгддэг болж байгаа шүү. Тэгэхээр ер нь бол углуургаар нь асуудлыг шийдээд ингэж явах нь илүү зүйтэй. Бусдаар төсөв болохлоор л нэг ахмадын тэтгэврийг нэмнэ гэж ярьчихаад ямар ч үр дүнгүй байдаг ийм зүйл байж болохгүй. Тэгэхээр жил болгон миний өргөн барьж батлуулсан Тэтгэврийг индексжүүлэх тухай хууль хэрэгжиж явна.

Тэгээд энэ дээр бол өнгөрсөн жил Сангийн сайд Жавхлан бас энэ дээр нэлээн саналыг минь сонсож, Төсвийн хуулиар хамтран хэлэлцүүлсэнд бас танд талархал илэрхийлье.

Ганхуяг гишүүн ажлын хэсгийн дарга горимын санал хэлье.

**Х.Ганхуяг:** 1 дүгээрт энэ 66 дугаар санал бол манай Байнгын хороо дээр байхад Эрдэнэбат гишүүн өөрөө татсан санал. Энэ техникийн алдаа орсон байна. 67-оос хойших саналууд нөгөө Дэгийн тухай хууль зөрчигдсөн асуудал яригдсан. Тэгээд эд нарыг бүгдийг нь болзошгүй гээд нөгөө бүгдийг нь Байнгын хороо руу буцаая гээд бид нар санал гаргачихсан байгаа.

**Б.Пүрэвдорж:** Яг нөгөө өөрөөр хэлбэл энэ чинь дэгийн хууль зөрчигдөөд, өөр хүн кноп дарсан.

**Х.Ганхуяг:** Өөрийгөө ирцэд орчихсон байна гэж бодоод кноподчихгүй юу.

**Б.Пүрэвдорж:** Харин тийм. Тийм учраас ....

**Х.Ганхуяг:** Мөн дарга аа, байж байгаарай. Энэ асуудлаар яг нөгөө бүх саналаа хэлээд дуусгачихъя дарга.

**Б.Пүрэвдорж:** Бүгдийг нь хэлчих.

**Х.Ганхуяг:** Эхний нөгөө бид нар хураасан 6 саналтай холбоотойгоор бид нар гадаад зээлийг ашиглалтыг 307 тэрбумаар бууруулж байгаа. Үүнтэй холбоотойгоор бид нар шилжилтийн үеийн зохицуулалт хууль, эрх зүйн асуудал байгаа. Энэ нь юу вэ гэхээр 19.1 дээр гадаад зээлийн эх үүсвэр хэрэгжүүлж байгаа Газрын тос боловсруулах үйлдвэр барих, Эрдэнэбүрэний УЦС барих эд нар дээр танаас бас чиглэл авах ёстой.

67-оос авхуулаад 67, 68, 69, 70, 71, 72, 73, 74, 75, 76, 77, 78, 79, 80, 81, 82, 83, 84, 85, 86, 87, 88, 89, 90, 91, 92, 93, 94, 95, 96, 97, 98, 99, 100, 101, 102, 103, 104, 105, 106, 107, 108, 109, 110, 111, 112, 113 саналуудыг Байнгын хороо руу та буцааж өгнө үү.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр бас яг энэ асуудлаар манай Төсвийн байнгын хорооны ахлах зөвлөх яг тодорхой мэдээлэлтэй байгаа. Тэгэхээр 66-69-ийг уншина. Яагаад гэвэл 66-69 бол яг тухайн үед зөв явсан. 70-аас хойш бол дэг зөрчигдсөн байна гэдэг ийм тодорхой дүгнэлт гарсан. Өөрөөр хэлбэл бичлэг харж байгаад энэ асуудлыг гаргаж ирсэн байгаа. Тийм учраас одоо 66-аас хойшоо цөмөөрөө 69 хүртэл саналаа уншаад хураалгана. Тэгэхээр Ганхуяг гишүүний гаргасан саяын саналуудыг үндэслээд 70-аас хойших саналуудыг болон түрүүний урьд нь өгсөн 3 дахь хэлэлцүүлэгт дахин явуулах чиглэл өгсөн хэд хэдэн микрофон дээр хэлэлцсэн асуудлууд байгаа. Зарим нь санал хураагдсан асуудлууд байгаа. Энэ асуудлуудыг Төсвийн байнгын хороонд 3 дахь хэлэлцүүлэгт дахин явуулах чиглэл өгч, буцааж байна. Буцаах санал хураалтыг явуулъя. Санал хураахгүй шүү дээ. Тэгэхээр энэ бүх асуудал чинь бүгдээрээ хамгийн эхэлж 6 асуудал дээрээ багцлаад хураачихсан.

Тийм учраас дахин санал хураалт явахгүй. Тэгээд гурав дугаар хэлэлцүүлэг дээр дахин явуулах чиглэлийг өгч байна.

66 дугаар асуудлыг гишүүн нь өөрөө татчихсан юм биш үү. Байнгын хороо дээр татсан учраас санал хураалт явуулахгүй юм байна.

67.Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Их Хурлын даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн “2.1.1.1 Хууль тогтоомжид хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байна.” гэсэн дэд заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ч.Анар, Х.Баасанжаргал, Ж.Галбадрах, Д.Бум-Очир, Д.Ганмаа, Б.Жаргалан, Ж.Золжаргал, С.Зулпхар, Б.Мөнхсоёл, А.Ундраа, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, Б.Хэрлэн, Д.Энхтүвшин. Өргөдлийн байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Уучлаарай. санал хураалтыг хүчингүй болгоё. Лувсанжамц гишүүн үг хэлнэ.

1 зар хэлээдэхье. Үүний дараагаар даргын зөвлөлийн дэмжсэний дагуу Шадар сайдыг танилцуулах, тангараг өргүүлэх ажиллагаа үргэлжлүүлэн явагдана. Тийм учраас бэлтгэл ажлыг хангахыг Тамгын газрынханд үүрэг болгож байна. Лувсанжамц гишүүн үг хэлье.

**Г.Лувсанжамц:** Баярлалаа. 67 дугаар зүйлээс авхуулаад 113 хүртэл 185 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэгт байгаа манай гишүүд маань хамтраад нам харгалзахгүйгээр иргэдийн төлж байгаа татвар, хувийн хэвшлийн төлж байгаа татварыг зөв зохистой зарцуулдаг болъё. Юунд зарцуулж байгаагаа бид нар үр дүнг нь хэмждэг болъё гэсэн зарчмын зөрүүтэй саналуудыг оруулсан.

Төсвийн 1 дүгээр хавсралт бол хөрөнгө оруулалт, урсгал зардалтай ямар ч хамааралгүй. Ямар ч тойргоос, ямар ч сайдаас, ямар ч төсвийн ерөнхийлөн захирагчаас төсөв хасаагүй болно. Бид нар төсвийн 1 дүгээр хавсралт байгаа 397 шалгуур үзүүлэлтийг 250-ийг нь засаж байгаа. Тэгээд бид нар дараа нь 2026 оныхоо төсвийн гүйцэтгэлийг харахдаа энэ үр дүнгээр нь сайд нарыг, төсвийн ерөнхийлөн захирагч нарыг үнэлье гэж байгаа юм. Тэгэхээр та бүхэн Монгол Улсын иргэдийн, аж ахуйн нэгжүүдийн төлж байгаа татварыг үр дүнтэй зарцуулахыг, цаашдаа татварыг зөв бодлогоор хэрэгжүүлдэг болгох зарцуулалтыг зөв болгох энэ саналыг маань дэмжиж өгөхийг хүсээд, кноподоо хүрэхгүй байхыг хүсэж байна.

**Б.Пүрэвдорж:** Бас их зөв, чухал зүйлийг манай Лувсанжамц гишүүн гаргаж байна. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Хамгийн өндөр санал авлаа шүү. 96 гишүүнээс 2 гишүүн дэмжиж, 2,1 хувийн саналаар таны санал дэмжигдсэн байна. Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

68.Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Их Хурлын даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “2.1.1.2 Хүний эрхийг хангах чиглэлээр баталсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%.” гэсэн дэд заалт, “2.1.1.3 ОУ-ын гэрээ, конвенцын хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “2.1.1.4 Хүний эрх, жендерийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээний хэрэгжилт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 48.3, Зорилтот түвшин: 50.7” гэсэн дэд заалт, “2.1.1.5 Шийдвэр гаргалт нь олон нийтийн оролцоотой, иргэдийн санаа бодлыг тусгасан үр дүнтэй гэдэгт итгэдэг хүн амын эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 48.3, Зорилтот түвшин: 50.7” гэсэн дэд заалт, “2.1.1.6 Хууль, шийдвэрийн давхардал, хийдэл, зөрчлийн тоо буурсан хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т-10%” гэсэн дэд заалт тус тус нэмэх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ч.Анар, Х.Баасанжаргал, Ж.Баярмаа, Д.Бум-Очир, Ж.Галбадрах, Д.Ганмаа, Б.Жаргалан, Ж.Золжаргал, С.Зулпхар, Б.Мөнхсоёл, А.Ундраа, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, Б.Хэрлэн, Д.Энхтүвшин. Өргөдлийн байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 20 гишүүн дэмжиж, 20,8 хувиар санал дэмжигдсэнгүй. Лувсанжамц нарын гишүүдийн саналууд дэмжигдсэн гэсэн үг.

69.Төслийн 1 дүгээр хавсралтын Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “4.1.1.1 Хяналтын шатны журмаар шийдвэрлэгдэж буй хэргийн дундаж хугацаа /бууруулах/ Хэмжих нэгж: Хоног, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т-10%” гэсэн дэд заалт, “4.1.1.2 Хууль хэрэглээний нэгдмэл байдлын түвшин. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2023, Суурь түвшин: 67.8, Зорилтот түвшин: 70” гэсэн дэд заалт, “4.1.1.3 Хууль тогтоомжийг боловсронгуй болгохоор боловсруулж хүргүүлсэн санал. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 3, Зорилтот түвшин: 6” гэсэн дэд заалт, “4.1.1.4 Судалгааны чанарыг дээшлүүлэх арга хэмжээ. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 0, Зорилтот түвшин: 1” гэсэн дэд заалт, “4.1.1.5 Шүүхийн цахимжилт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2023, Суурь түвшин: 76.4, Зорилтот түвшин: 79” гэсэн дэд заалт, “4.1.1.6 Шүүхийн шийдвэрийн нээлттэй, ил тод байдал. Хэмжих нэгж: Хоног, Суурь он: 2024, Суурь түвшин: 22.7, Зорилтот түвшин: 20” гэсэн дэд заалт, “4.1.1.7 Шүүн таслах ажиллагаанд оролцоход шаардлагатай хүртээмжийн үйлчилгээ хүссэн иргэдэд эзлэх үйлчилгээ авч чадсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “4.1.1.8 Хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн талаарх мэдээллийг тэгш хүртээмжтэй (дохионы хэлмэрч, хадмал орчуулга зэрэг хүртээмж) олон нийтэд мэдээлсэн мэдээллийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 0, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “4.1.1.9 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн эрхийг хангасан арга хэмжээ. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10” гэсэн дэд заалт, “4.1.1.10 Шүүхийн шийдвэрийг ойлгомжтой байлгах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ (шүүхийн шийдвэрийн тойм, хураангуй бичсэн тоо ба нийт шийдвэрийн

харьцаа, олон нийтэд нээлттэй мэдээлсэн байдал). Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “4.1.1.11 Давж заалдах тогтолцооны үр нөлөө (хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцсэн үндэслэл). Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10” гэсэн дэд заалт, “4.1.1.12 Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-д заасан арга хэмжээний хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ч.Анар, Х.Баасанжаргал, Ж.Баярмаа, Д.Бум-Очир, Ж.Галбадрах, Д.Ганмаа, Б.Жаргалан, Ж.Золжаргал, С.Зулпхар, Б.Мөнхсоёл, А.Ундраа, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, Б.Хэрлэн, Д.Энхтүвшин. Өргөдлийн байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Тэгэхээр дараа дараагийн өнгөрсөн жилийн төсөв дээр Лувсанжамц гишүүн яг энэ асуудлаар ярьж байсан. Засаад юм хумаа оруулж ирэхгүй дахин дахин ингэж уншуулдаг энэ яам, Засгийн газар бас энэ дээрээ бас тодорхой асуудлаа зөв болгож орж ирж байгаарай гэж бас хэлмээр байна. Ингээд бусад асуудал бол Төсвийн байнгын хорооны хороонд гурав дахь хэлэлцүүлгийн дахин явуулах чиглэл өгснөөр буцаж байна.

Төсвийн тухай хууль болон бусад хуультай холбоотойгоор асуудлыг хэлэлцэж дууслаа.

Төсвийн гурав дугаар хэлэлцүүлэг чуулганаар хэлэлцэгдэж хэлэлцэгдэж дуусаагүй байгаа. Өөрөөр хэлбэл гурав дугаар хэлэлцүүлэг Төсвийн байнгын хороонд буцаж очсоноор дахин санал хураалт явуулж, засаж оруулж ирсний үр дүнд төсвийн гурав дугаар хэлэлцүүлгийг одоо Төсвийн байнгын хороо энэ асуудлаа хэлэлцэж, Төсвийн байнгын хороо хуралдаж шийдвэрлээрэй.

Чуулганы хуралдаанаар төсвийн асуудлыг хэлэлцэх асуудлыг 1 дэх өдрийн 14 цагаар болгож хойшлуулж байна. Хуралдаан даргалагчийн эрх үүрэг 13 дугаар зүйл дээр заагдсан байдаг. Тэгэхээр 13.1.9-д илтгэл, танилцуулгад сонсох, асуулт хариулт явуулах, санал, дүгнэлт танилцуулах, санал хураах, цагийг тогтоох эрх бол хуралдаан даргалагчид байдаг. Тийм учраас өнөөдөр 2025 оны 11 сарын 10-ны өдрийн 14 цагт Төсвийн байнгын хороо хуралдаж, саяын гурав дугаар хэлэлцүүлэгт санал хураах үйл ажиллагааг явуулна. 11-ний 10 цагаас чуулганы хуралдааныг хуралдуулж, 2026 оны төсвийн асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэх цагийг тогтлоо.

19.58 цаг.

Даргын зөвлөлийн хурлаар шийдэгдсэний дагуу Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 сарын 7-ны өдөр Засгийн газар 1/124 дүгээр албан бичгээр Засгийн газрын гишүүнийг огцруулах, Засгийн газрын гишүүнээр томилох асуудлыг танилцуулах тухай асуудлыг ирүүлсэн. Үүний дагуу даргын зөвлөл хуралдаж, өнөөдрийн хэлэлцэх асуудлын дараалалд оруулсан байгаа.

Ингээд Засгийн газрын гишүүнийг томилоод, танилцуулах асуудлыг эхэлье. Ерөнхий сайдыг дуудна уу.

Улсын Их Хурлын тухай хуулийн 28.25.8-д Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны даргаар ажиллахгүй гэсэн заалттай учраас Байнгын хорооны даргын асуудлаа шийдвэрлэсний дараа Засгийн газрын гишүүнийг танилцуулах асуудал явагдана.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан ... Төсвийн байнгын хорооны гурав дугаар хэлэлцүүлэгт чиглэл өгөх тухай хэд хэдэн 6 гол асуудлаар олон асуудлыг чиглэл өгөх тухай шийдвэрлэсэн байгаа.

Тийм учраас Төсвийн байнгын хорооны хурлыг 10-ны өдрийн 14 цагт хуралдуулж, энэ гурав дугаар хэлэлцүүлгийг хийж дуусгахыг үүрэг болгож байна.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан хаасныг мэдэгдье.

20.02 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*